Н.ГАНТУЛГА
Хууль сахицулах их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, хууль зүй доктор, дэд профессор, хурандаа

АВИЛГЫН СЭТГЭЛ ЗҮЙН ҮНДЭС



Хээл хахуул авах нь авилгын хамгийн эртний хэлбэр гэж үзэж болно. Авилгын шинжтэй эрх зүйн зөрчлүүдийн нэг гол үндэс-нөхцөл нь нийгмийн бүлгийн хүрээнд тогтсон зарим сөрөг зан үйл-тодорхой хэм хэмжээ байдаг. Тухайлбал: Нийтэд албан ёсоор зарлаагүй боловч авилгачдын хүрээлэлд хүлээн зөвшөөрөгдсөн "*хахууль авсан бол удирдлагатайгаа хуваалц*" гэсэн ахуйн сэтгэлгээ-дэг ёс үүнд юуны өмнө хамаарна. Иймээс авилгачдын зүгээс хээл хахууль, авилгын шинж чанартай нэгж тохиолдол, нийт үзэгдэлд хандах зан суртахуун /ёс зүй/ нь хууль ёсыг даган биелүүлэгч төрийн албан хаагчдынхаас эрс ялгардаг.

Судлаачдын үзэж байгаагаар авилгын сэтгэл зүйн үндэс-нөхцөл нь тэдний ухамсар-ахуйд бүрэлдэн тогтсон өөрсдийгөө хамгаалах сэтгэл зүйн механизм мөн. Тодруулбал авилгачдад өөрсдийн гэмт зан үйлийг өмөөрөн зөвтгөдөг дараах 5 сэдэл-учир шалтгаан байдаг талаар бүтээлүүдэд тэмдэглэжээ. Энэ нь:

1. "***Хариуцлагыг үгүйсгэх сэтгэл зүй***". Авилгач этгээд өөрийгөө авилгын субьект гэхээсээ илүү энэ үйл ажиллагаа-үйл явдлын обьект гэж тооцдог. Учир нь тэдний үзэж байгаагаар авилга авагч /зайлшгүй/ нөхцөл байдлын "золиос" болдог.

2. ***"Гэм хорыг үгүйсгэх сэтгэл зүй".*** Хахууль авсан албан тушаалтан өөрийн үйл ажиллагаанд гэм хор байхгүй гэж үздэг. Түүний хувьд хахууль авсан явдал нь тодорхой этгээдэд хамааралтай зөв */ур ашигтай/* шийдвэр гаргасан үйл ажиллагааных нь хариу "талархал" гэж тооцогддог.

3. ***"Хахуульд хохирогч /золиос/ байхгүй хэмээх сэтгэл зүй".*** Хахууль өгөгч нь шударга бус замаар олсон мөнгөнийхөө тодорхой хэсгийг л өгч байгаа тул түүнийг авсан албан тушаалтан хэнд ч хор хохирол учруулдаггүй. Иймээс авилгачдын хувьд хахууль өгөгч өөрөө эрх зүйн зөрчил гаргагч */хулгайч, татвараас зайлсхийгч, залилан мэхлэгч/* этгээд мөн.

4. ***"Авилгыг эсэргүүцэгчдийг бурууталах сэтгэл зүй".*** Тэд "*хүн бүр хахууль авдаг*" гэсэн үзэл хандлагатай ба үүнийгээ хамт ажиллаж буй зарим алба хаагч, дарга нарынхаа жишээгээр тайлбарладаг. Өөрөөр хэлбэл зөвхөн цалингаараа тэд амьдарч, одоогийн албан тушаал, орон байр, бусад орчин, хамгамжаа бий болгосон гэвэл ташаа болно гэж төсөөлөдөг.

5. ***"Ийнхүү нийгмийн ахуйд бүрэлдсэн дээрх дэг, ёс зүйн хэм хэмжээ, сэтгэл зүйн орчинд ёс суртахууны ариун нандин үнэлэмж, үзлүүд уусч, саармагжан***



үгүйсгэгддэг” ба олон нийтийн /тодорхой бүлгийн/ үзэл хандлагатай авилгач-дарга нарын үйл ажиллагаа ийнхүү зохицон оршдог гэж энэ хүрээлэлд тайлбарлагддаг.

Иймээс алба хаагчаас өгсөн хахуулиас дарга татгалзах нь тэднийг барьж өгнө, тэдэнд итгэхгүй байна гэсэн ташаа ойлголт, сэтгэл зүйн орчинг бичил хамт олны хүрээнд бий болгох, мөн тогтсон дэг ёс, уур амьсгалыг эвдэх зэрэг сөрөг нөлөөлөлтэй гэж авилгачид гэмт зан үйлээ зөвтгөдөг байх магадлалтай.



Н.ГАНТУЛГА

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа



Н.БАТДОРЖ

Ахлагчийн сургуулийн ахлах багш, хууль зүйн магистр, хошууч

ФРАНЦЫН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ (ПЕНИТЕНЦИАР) ТОГТОЛЦОО

Нэг. Удирдтгал

Албан ёсоор Бүгд Найрамдах Франц Улс хэмээн нэрлэгддэг Франц улс орнод Европт оршдог. Европ дахь үндсэн орноос гадна далайн чанад газар нутагтай. Францын үндсэн орон өмнө зүгийн Газрын дундад тэнгисээс, умар зүгт Ла-Маншийн хоолой, Умард тэнгис, дорно зүгийн Рейн мөрнөөс орно зүгийн Атлантын далай хүрнэ.

Францчууд эх орноо геометрийн дүрсээс нь шалгаалж L'Hexagone буюу "6 өнцөгт" хэмээн нэрлэх нь олонтаа.

Франц нь хагас-ерөнхийлөгчийн засаглалтай бүгд найрамдах улс бөгөөд хууль тогтоох, гүйцэтгэх



болон шүүх засаглал нь нэгдмэл. Нийслэл нь Парис хот.

Эх газрын Франц нь Бельги, Люксембург, Герман, Швейцари, Итали, Монако, Андорра, Испани улсуудтай хиллэдэг. Мөн Францын газар нутаг болох Франц Гвиана нь Бразил, Суринам улсуудтай, Сэйнт-Мартин нь Нидерландын Антилийн арлуудтай тус тус хил залгана. Ла-Маншийн хоолой доорх Ченнель туннелаар (Channel Tunnel) Британитай залгадаг.

17-р зууны сүүл үеэс 19-р зууны эхэн үе хүртэл Франц нь дэлхийн хамгийн хүчирхэг орнуудын тоонд тооцогдож байв. Франц ондор хогжилтэй орон бөгөөд эдийн засаг нь номинал ҮНБ-р дэлхийд зургаад, худалдан авах чадварын паритетаар тооцсон ҮНБ-ээр наймд жагсдаг..

Тэрээр Европын холбоог анх байгуулсан орнуудын



нэг, гишүүн орнуудаас хамгийн их нутаг дэвсгэртэй. Мөн НҮБ-ыг байгуулсан анхдагч орнуудын нэг ба НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн, цөмийн зэвсэгтэй орон юм.

Хоёр. Ял эдлүүлэх тогтолцооны зохион байгуулалтын бүтэц

2013 оны 07-р сарын 01-ний байдлаар энэ улсын Хууль зүйн яамны харъяа ял эдлүүлэх захиргааны бүрэлдэхүүнд түүний харъяа ял эдлүүлэх байгууллага, дахин нийгэмшүүлэх ба ял эдлүүлэх пробацийн[1] албадын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий 9 бүс дундын газар, 1 усан талбай бүхий нутаг дэвсгэрийг хариуцсан захиргаа байна.

Хорих дэглэм болон ялтны бүрэлдэхүүнээс хамаараад ял эдлүүлэх байгууллагын хэд хэдэн төрөл бий. Франц улсад ял эдлүүлэх 192 байгууллага үйл ажиллагаагаа явуулдаг ба тэдгээрийг а/ Мөрдөн тусгаарлах газар[2], б/ Ял эдлүүлэх байгууллага гэсэн 2 хэсэгт хувааж болно.

Мөрдөн тусгаарлах газрууд: Энэ төрлийн 99 газар бий ба тэдгээрт нийтээс тусгаарлагдан мөрдөн шалгагдаж шүүх хуралдааныг, мөн шүүхийн шийтгэх тогтоол хүчинтэй болох хугацааг хүлээж буй гэмт хэрэгтнүүд, 2 хүртэлх жилийн хорих ялтай (эсвэл хорих ялын үлдсэн иймм хугацаатай) ялтнууд хоригддог.

Ял эдлүүлэх байгууллагууд: Нийтдээ энэ төрлийн 85 байгууллага бий ба үүнээс төв хорих газар (шорон) -6, хорих төвүүд-25, хагас эрх чөлөөтэй дэглэм бүхий төв-11 болно. Мөн 43 ял эдлүүлэх төвүүд байдаг ба тэдгээрийн бүтцэд мөрдөн тусгаарлах газар, хорих төв/төв хорих газрууд байж болдог. Түүнчлэн 2007 оны 06 дугаар сараас 2008 оны 04-р сарын хооронд насанд хүрээгүйчүүдийн ял эдлэх 6 тусгай байгууллага нээгдсэн.

Төв хорих газрууд (шорон)-д урт



хугацааны хорих ялтай болон нийгэмд ихээхэн аюул занал бүхий хүмүүс ял эдэлдэг. Иймд дэглэм нь юуны өмнө аюулгүй байдлыг хангахад чиглэгддэг.

[1] Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх

[2] Манай улсын жишээн дээр адилтган үзвэл энэ нь Цагдан хорих байр болно.

Хорих төвүүдэд их бус буюу 2,



түүнээс дээш жилийн хорих ялтай, засрал хүмүүжилээ олж дахин нийгэмших боломжтой хоригдлууд ял эдэлдэг. Иймээс дэглэм нь юуны өмнө хоригдлыг дахин нийгэмшүүлэх үйл ажиллагаа ажиллагаанд захирагддаг.

Хагас эрх чөлөөтэй дэглэм бүхий төвүүд нь ял эдлүүлэх байгууллагын байрны гадна амьдрахыг зөвшөөрсөн болон эрх чөлөөг нь хэсэгчлэн хязгаарласан ялтнуудыг хүлээн авдаг. Энэ төрлийн хорих ял эдлэгсэд өдрийн цагаар мэргэжлийн үйл ажиллагаа (ажил хийх) явуулах, боловсрол, мэргэжлийн сургалтуудад хамрагдах, эмчилгээ хийлгэх болон бусад ажил-арга хэмжээнд оролцох зорилгоор ял эдлүүлэх байгууллагын байрнаас гадагшаа явах эрхтэй. Энэ бүхэн мөн л ялтныг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд юуны өмнө чиглэгддэг.

Ноогдуулсан ял нь илүү хөнгөн ялаар солигдсон этгээдүүдийн ял эдлэх төв (хэсэг)-д эрх чөлөө нь хэсэгчилэн хязгаарлагдсан дэглэмтэй; ял эдлүүлэх байгууллагын гадна амьдрахыг зөвшөөрсөн; нэг жилээс бага хорих ялын хугацаатай ялтнуудыг хүлээн авдаг ба гол үүрэг нь ялтнуудыг дахин нийгэмшүүлэх хөтөлбөрүүдэд хамруулахад чиглэгддэг.

Дахин нийгэмшүүлэх ба ял эдлүүлэх пробацийн албад: Францад ийм төрлийн 103 алба бий. Тэд засаг захиргааны нэгжийн эрх мэдэл-харъяалалд үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ албад шүүх засаглалын удирдлага дор хорихоос бусад (альтернатив)



төрлийн ял эдлүүлэх явдлыг, түүнчлэн мөрдөн шалгагдаж буй болон ял оноогдсон этгээдүүдийн шүүхийн өмнөх болон шүүхийн дараах процессын зарим төрлийн үйл ажиллагааг гүйцэтгэдэг. Эдгээр албадын гол үүрэг нь шүүн таслах үйл ажиллагааны хугацаанд тусламж үзүүлэх замаар дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг нь таслан зогсоох, оногдуулсан ялыг биечлэн /ганцаарчилан/ эдлүүлэх, дахин нийгэмшүүлэх болон хяналт тогтоосон хүмүүсийн үйл ажиллагаанд мониторинг, шалгалт хийх явдал юм.

Гурав. Тоо баримт ба үйл явдал

Энэ улсын хорих газруудад 2013 оны 05-р сарын 01-ны байдлаар 67.839 хүн, үүнээс мөрдөн хоригдож буй-16.987, хорих ял эдлэж буй 50.852 хүн байна. Хорих ял эдлэгсдээс 2041 хүн хагас эрх чөлөөтэй нөхцөлд, 435 хүн хорих байгууллагын гадна амьдрах эрхтэй нөхцөлд ял эдэлж байна.

Хорихоос өөр төрлийн ялыг цахим бугуйвч ашигласан хяналт дор 10.760 хүн, мөн ял эдэлсэн хугацаа дууссан боловч

цахим бугуйвчийг зүүж хяналтад хамрагдаж буй 678 хүн байна.

2207 хоригдогч эмэгтэй байгаа ба үүнээс мөрдөн хоригдож буй нь 678. Насанд хүрээгүй 771 хүн хоригдож буй ба үүний 477 нь мөрдөн хоригдогсод.

Энэ улсын хорих газрууд 57.235 хүнийг багтаах хүчин чадалтай ба өнөөгийн байдлаар 8 хорих газрын хувьд 200 ба түүнээс дээш хувийн, 33 газар 150-200%, 58 газар 120-150%, 33 газар 100-120%, 117 газар 100 ба түүнээс бага хувийн дүүргэлттэй байна.

Хорих газруудад 2447 эмнэлгийн ажилтан ажиллагадаг ба тэд Эрүүлийг хамгаалах яаманд харъяалагддаг. Энд эмнэлгийн-178 хэсэг, засаг захиргааны нэгж хоорондын-7 эмнэлэг, үндэсний хэмжээний "Френь" хориход байрлах - хорихын 1 госпитал, эмнэлэг-сэтгэл зүйн засаг захиргааны нэгжийн - 26 лаборатори бий. Хорих байгууллагуудын хэмжээнд 152 сэтгэл зүйч-эмч ажилладаг.

2012 оны 01-р сарын 01-ний байдлаар 100 мянган хүн аманд ногдох энэ улсын хоригдлын тоо нь 99,1 хүн байсан.

2011 онд хорих ял эдлэгсдийн дундаж хугацаа нь 9,6 сар байсан. Нийт ял эдлэгсдийн дунд 5 ба түүнээс дээш жилийн хорих ялаар шийтгэгдсэн 1,9 %, 1 жил ба түүнээс бага хугацаатай нь 81.5%, нэг сар ба түүнээс бага хугацаатай нь 13,3% тус тус болно. Мөн бүх насаараа хорих ялтай 487 хүн байна.

Ял эдлэгсдийн дундаж нас 34,4. Ял эдлэгсдийг гэмт хэргийн төрлөөр авч үзвэл: 26,5% нь хүчирхийллийн санаатай үйлдэл; 13,4% нь хүчин болон сексийн шинж чанартай хүч хэрэглэсэн үйл ажиллагаа, эсвэл тэдгээрийг хийхийг завдсан; 6% нь бусдыг санаатай алсан, 11,3% нь тусгай бүрэлдэхүүнтэй хулгайн гэмт хэрэг, 7,8% нь эдийн засгийн, 14,2% нь хар тамхи мансуурууулах бодисын хууль бус үйл ажиллагаатай холбогдсон гэмт хэрэг үйлдэгчид байна.

Ял эдлэгсдийн 82,4% нь францын, 17,6% нь гадаадын иргэн байна.

2011 онд 57.629 удаагийн богино хугацаагаар хорих газраас гарах зөвшөөрлийг олгосны гадна 7481 хүн хугацаанаасаа өмнө суллагджээ.

2012 оны 01-р сарын 01-ний байдлаар дахин нийгэмшүүлэх болон пробацийн албаны хяналтанд[3] 173.063 хүн ял эдэлж, үүнийг 4080 албан хаагч хянаж байжээ.

2011 онд энэ орны хорих газруудад: орголт -4 /2010 онд 7/; бусдыг барьцаанд авсан -7 /2010 онд 2/; нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын -667 удаагийн тохиолдол /2010 онд 761/; албан хаагчдад хүч хэрэглэсэн -4083 /2010 онд 30230/; бусад хоригдолд хүч хэрэглэсэн тохиолдол -8,365 /2010 онд 7825/; хүн амины -3 /2010 онд -4/ гэмт хэрэг үйлдэгджээ.

2011 онд 116 ялтан амиа хорлосон талаар бүртгэгдсэн ба энэ нь 10.000 ялтантай харьцуулахад 17,1 хувийг эзэлж байсан. Мөн 1932 амиа хорлох оролдлого бүртгэгдсэн.

2011 онд 24.934 хоригдогсод цалинтай ажлаар хангагдсан (60.304.105 еврогийн цалин авсан) ба энэ нь нийт хоригдогсдын 39,1% болно.

25,437 хоригдогсод мэргэжлийн бэлтгэлийн төрөл бүрийн дамжаанд, 46,186 насанд хүрсэн хорих ял эдлэгсэд анхан шатнаас дээд боловсрол олгох сургалтуудад хамрагджээ.

Францын хорих байгууллагуудад 2011 онд рецидив гэмт хэрэгтэй тэмцэхэд

3 "Хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлэх албаны" хэмээн өөрөөр нэрлэж болно.

чиглэгдсэн 190 орчим төрөл бүрийн хөтөлбөрүүд хэрэгжсэн.

Мөн энэ онд албан хаагчдаас 300 гаруй мэргэжлийн дасгалжуулагчид хоригдогсдын биеийн тамир спортын бэлтгэлийг удирдан явуулжээ.

2011 онд төрөл бүрийн шашины 1.249 төлөөлөгч (үүнээс 397 нь орон тооны ажилтны хувиар) хоригдогсодтой ажилласан ба тэдгээрийн 665 нь католик, 317 нь протестант, 151 нь мусульман, 70 нь иудеи, 24 нь үнэн алдартны, 32 нь шашны бусад урсгалд хамаарч байна.

2012 оны 01-р сарын 01-ний байдлаар энэ улсын хорих байгууллагууд 35,420 албан хаагчтай ба тэдгээрээс: удирдах ажилтанд-503, хяналт-харуул хамгаалалтын ажилтанд-26.094, дахин нийгэмшүүлэх ба пробацийн (хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх) албанд-4080, захиргааны ажилд-2811, техникийн үйлчилгээнд-602, бусад үйл ажиллагаанд-1330 хүн хамаарч байна. Шуурхай ажиллагаа, аюулгүй байдлын хэсэгт (хорихын тусгай зориулалт бүхий бүлэгт) 377 алба хаагч ажилладаг.

Францын хорихын захиргааны Үндэсний сургуульд 2011 онд 3467 хүн сургалтад хамрагдсан.

2012 оны 01-р сарын 01-ний байдлаар сард: хяналтын үүрэг гүйцэтгэгч бага (жирийн) албан тушаалтан 1447 (алба хааж буй эхний жил)-2072 евро, хорих байгууллагын дэслэгч 1752-2731 евро, ахмад 2277-3004 евро, захиргааны зөвлөх 3377-4963 евро, хорих байгууллагын дарга 2168-4638 евро, дахин нийгэмшүүлэх ба пробацийн албаны зөвлөх 1645-2917 евро, инженер техникийн ажилтан 1670-2575 еврогийн цалин авч байжээ.

2012 оны хорих байгууллагын нийт төсөв 2,39 тэрбум еврогоос бүрдэж байсан ба үүний 52% нь албан хаагчдад зарцуулагджээ.

2011 онд шинэ алба хаагчдыг энэ албанд авахад чиглэгдсэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн өргөн оролцоо бүхий үндэсний хэмжээний компанит ажил зохион байгуулагдсан ба 610 сул орон тоон дээр 22898 хүний өргөдлийг хүлээн авсан байна.

Дөрөв. Хорих байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо

Францад бусад иргэдийн адил түвшинд хоригдлын суурь эрхүүд хамгаалагдсан байдаг. Хорих байгууллагын захиргаа өөрийн чиг үүргийг Хүний болон иргэний эрхийн тунхаглал, Францын Үндсэн



хууль, 2009 оны 11-р сарын 24-ний өдрийн Ял эдлүүлэх /Пенитенциарный закон/ хууль болон хүний эрхийг хамгаалах олон улсын конвенцуудад нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.

Мөн захиргаа үйл ажиллагаандаа хүний халдашгүй байдал, нэр алдарт нь хүндэтгэлтэй хандах үүрэгтэй. Түүнчлэн хорих байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтын дэг журам /процедур/ нь Францын эрүүгийн процессын болон бусад хуулиудад тусгагджээ.

Өнөөдөр энэ улсын хорих байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьдаг дараах байгууллагууд байна. Энэ нь:

1. **Захиргааны болон шүүх эрх мэдлийн байгууллага, парламентаас корпусаас явуулах байнгын болон цаг үеийн хяналт.**

Хорих газрууд нь төрийн байгууллагуудын хяналтын обьект байдаг. Үүнд дотоод хяналтыг хорих байгууллагын мэргэжлийн албад, гадаад хяналтыг Хөдөлмөрийн хяналт шалгалтын газар[4], Эрүүлийг хамгаалахын Ерөнхий хяналт шалгалтын[5] болон бусад газрууд хэрэгжүүлдэг. Мөн шүүх засаглалын хяналтыг ял шийтгэлийг хэрэглэх шүүгч, мөрдөн хорих үйл ажиллагаанд хяналт тавих шүүгч, мөрдөн хорих танхимын ерөнхийлөгч, прокурор, ерөнхий прокурор хэрэгжүүлдэг. Парламентын Нийтийн танхимын депутатууд, Дээд танхимын сенаторууд, тэрчлэн Франц улсаас сонгогдсон Европын Холбооны парламентын гишүүд ямар ч цаг хугацаанд хорих байгууллагад очиж үйл ажиллагаатай нь танилцах, хоригдлуудтай чагнах, тагнах явдлаас ангид ганцаарчилан уулзах эрхтэй.

2. **Хөгжлийн зөвлөл**

2009 оны 11-р сарын 24-ны өдрийн Ял эдлүүлэх хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Хяналтын комиссууд нь Хөгжлийн асуудал хариуцсан зөвлөлүүд болон өөрчлөгдсөн. Энэ зөвлөл хорих байгууллага бүрт байрлаж түүний үйл ажиллагаагаа явуулах нөхцлийг ажиглан, сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээг санал болгох бүрэн эрхтэй. Ялангуяа энэ зөвлөл хорих байгууллагын зүгээс хоригдогсдын эрх, аюулгүй байдлыг сахиж буй байдал, эмнэлгийн үйлчилгээ, дахин гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх болон ял шийтгэлийг хөнгөн төрөл болгон солиход чиглэгдсэн ажил-арга хэмжээнд ажиглалт хийдэг.

Хөгжлийн зөвлөлийг тухайн хорих байгууллага байрлаж буй засаг захиргааны нэгжийн дарга[6] /эсвэл түүний орлогч/ тэргүүлдэг ба түүнд засаг захиргааны нэгжийн нэр хүнд бүхий алба хаагчид /өмгөөлөгчид, хотын дарга, магистратууд[7]/, тэрчлэн төрөл бүрийн байгууллагын төлөөлөгчид /төрийн бус байгууллага, нэгдлүүд, шашны зүтгэлтнүүд/-ээс бүрддэг. Энэ зөвлөл жилд 1-ээс цөөнгүй удаа цугладаг бөгөөд хуралдааныхаа үр дүнгээр илтгэл бичиж хууль зүйн сайдад илгээдэг.

3. **Хүний эрхийн бүрэн эрхт**



төлөөлөгч /түүний төлөөлөл/

Хүний эрхийн бүрэн эрхт төлөөлөгч нь төрийн байгууллага, албан тушаалтны

[4] Инспекция труда /Хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллага/

[5] Генеральная инспекция здравоохранения

[6] Префект

[7] Шүүх, прокурорын болон засаг захиргааны албан тушаалтнууд ингэж нэрлэгддэг.

үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг сахин хэрэгжүүлж буй байдалд хяналт тавих үүрэг бүхий хараат бус албан тушаалтан юм. Түүний үндсэн үүрэг-зорилгод хэний боловч эрхийг хамгаалах, хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа ялгаваргүй байдал, хуулийн өмнө эрх тэгш байх явдлыг хамгаалах явдал болно. Тэрээр мөн аюулгүй байдлыг хангах салбарт мэргэжлийн ёс зүйг сахиулах Үндэсний комиссын үйл ажиллагаанд оролцдог. Хүний эрхийн бүрэн



эрхт төлөөлөгч /мөн түүний төлөөлөл/ нь ялангуяа иргэд ба төрийн эсвэл захиргааны байгууллага хоорондын зөрчилдөөнт нөхцөл байдлуудыг эв зүйгээр шийдвэрлэх, зохицуулахад оролцдог. Хоригдогсод[8] хүний эрхийн бүрэн эрхт төлөөлөгчид захидал илгээх замаар шууд харьцах эрхтэй ба захидал нь ямар нэгэн хяналт шалгалтаас гадуур үнэ төлбөргүй илгээгддэг.

4. Албадан хорих газруудын Ерөнхий хянан байцаагч

Энэ албан тушаал нь 2007 оны 10-р сарын 30-ны хуулиар бий болсон. Албадан хорих газруудын Ерөнхий хянан байцаагч нь хорих ял эдлэх нөхцөл, хорих ял эдлэгсдийн шилжилт хөдөлгөөн болон тэдний эрхийг сахиж буй байдалд хяналт шалгалт явуулах эрхтэй. Энэ албан тушаалтан үйл ажиллагаагаа бүрэн дүүрэн хэрэгжүүлэх үүднээс орон тооны хянан байцаагч нарыг захиргаандаа авч ажлуулдаг. Тэд ямар ч үед ял эдлүүлэх байгууллагад орох, чагнах, тагнах явдлаас ангид ял эдлэгсэд, бусадтай уулзах эрхтэй.

Хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд (нэгдэл, төрийн бус байгууллагууд), түүнчлэн хувь хүн Ерөнхий хянан байцаагчид хоригдогсодын эрх зөрчигдөж буй аливаа баримтыг мэдээлэх эрхтэй. Харин холбогдох хяналт шалгалтыг явуулсны дараа Ерөнхий хянан байцаагч төрийн засаглалын зохих байгууллагад өөрийн санууулгыг хүргүүлэх эрхтэй ба тэрээр тогтоосон хугацаанд хариултыг өгөх үүрэгтэй. Түүнчлэн Ерөнхий хянан байцаагч гэмт хэрэг үйлдсэн нь түүнд илэрхий болсон баримтыг прокурорт мэдээллэх үүрэгтэй.

Ерөнхий хянан байцаагч нь аливаа зөвөлгөө, зөвлөмжийг өгөх, хууль, хууль тогтоомжийн бусад актуудад нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал гаргах эрхтэй ба өөрийн үйл ажиллагааны жил бүрийн тайланг нийтэд хэвлэн мэдээллэх үүрэгтэй.

5. Эрүүдэн шүүх болон хүнлэг бусаар, нэр алдарыг нь гутаан харьцах,



[8] Мөрдөн шалгагдаж байгаа болон ял эдлэгсэд



С.ЖАНЦАН

Хууль сахиулахын их сургуулийн шинжлэх ухаан, технологийн газрын цагдаа судлалын товийн дарга, доктор, профессор, цагдаагийн хурандаа

МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЙН ХӨГЖИЛ, НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Нэг. Монгол Улсад гэмт явдалтай тэмцэх тогтолцоо (салбар) үүсч хөгжсөн нь

- 1961 онд Монгол Улсын Шинжлэх ухааны академи байгуулагдсан. Нийгмийн шинжлэх ухаануудын дотроос хууль зүйн шинжлэх ухаан хожуу хөгжсөн гэж үзэж болно.

- 1934 онд Дотоод явдлын яамны төв сургууль /одоо Хууль сахиулахын их сургууль/ байгуулагдан хуулийн дунд мэргэжлийн албаны тусгай бэлтгэл бүхий ажилтнуудыг бэлтгэж эхэлснээс хойш 80 шахам жилийн түүхэн замналыг туулжээ. Энэ сургуулийг төгсөгчдөөс хожим олон арван гавъяат хуульчид, эрдэмтэд, дипломатчид, генерал офицерууд төрөн гарсан нь түүхийн үнэн юм. Хууль зүйн шинжлэх ухааны анхны докторууд болох хошууч генерал Р.Гүнсэн, хурандаа генерал Ж.Авхиа нар энэ сургуулийн төгсөгчид юм.

- ДЯЯ-ны төв сургууль хожим НАХЯ-ны Дээд сургууль, Цагдаагийн академи, Дотоод хэргийн их сургууль, Хууль сахиулахын их сургууль болтлоо өргөжиж хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд зохих хувь нэмрээ оруулж байна.

- 1960 онд МУИС-ийн бүрэлдэхүүнд хуулийн салбар байгуулагдан ажилласнаар хууль зүйн сургалт, судалгааны ажил явуулах, цаашид хууль зүйн шинжлэх ухан хөгжих оюуны уурхай болсон юм.

- 1992 онд МУИС-ийн хуулийн салбар, ШУА-ийн төр, эрх зүйн хүрээлэн, Хууль цаазын дунд сургуулийг нэгтгэн өргөжүүлсэн, мөн түүнчлэн 1994 онд Засгийн газрын тогтоолоор МУИС-ийн хуулийн салбар, ШУА-ын Төр, эрх зүйн хүрээлэн, Хууль зүйн яамны хууль судлалын төвийг нэгтгэн МУИС-ийн Хууль зүйн дээд сургууль болгон зохион байгуулан ажилласнаар хууль зүйн шинжлэх ухаан эрчимтэй хөгжих чухал нөхцөл болсон юм.

- Манай улсын хууль зүйн шинжлэх ухааны доктор, дэд докторуудын дийлэнх нь энэ сургуулийг үүсгэн байгуулагчид, багшилж байгаа хүмүүс, төгсөгчид байна.

- Хууль зүйн сургуулийн багш нар, судлаачид хууль зүйн шинжлэх ухааны төрөл бүрийн салбараар төсөл хэрэгжүүлж олон арван сурах бичиг, ном гарын авлага, нэг сэдэвт бүтээлүүд туурвисан нь хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд оруулсан жинтэй хувь нэмэр юм.

- Монгол Улсын салбар эрх зүй дотроос хүн, нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн хууль ёсны ашиг сонирхлыг нийгэмд аюултай халдлагаас хамгаалах чиг үүрэгтэй салбар эрх зүй болохын хувьд эрүүгийн эрх зүйн тулгамдсан асуудлууд түлхүү судлагдаж, энэ салбарт 1960 оноос эхэлж олон арван эрдэмтэд төрөн гарсан

нь тухайн шинжлэх ухааны хөгжлийг илтгэх харуулах чухал үзүүлэлт боловч олон асуудал судлаачаа хүлээж байна.

- Криминологийн шинжлэх ухааны хөгжил тухайн нийгмийн байгууламжид гарч буй мөн чанар, түүнийг төрүүлж буй шалтгаан, нөлөлж буй нөхцөлийн /сөрөг хүчин зүйлүүд/ талаар ямар үзэл бодол хандлага ноёрхож байснаас шууд шалтгаалдаг болохыг түүх гэрчилнэ. Тухайлбал, манайд олон арван жилийн турш гэмт явдлыг төрүүлдэг нийгэм, эдийн засгийн үндэс арилсан, социализмын мөн чанартай холбоогүй гэсэн хэт үзэл сурталжсан, онолын үндэслэлгүй, тухайлбал, бодит судалгаанд тулгуурлаагүй, агуулгын алдаатай бодлогод хөтлөгдөн гэмт хэрэг нь социализм хөгжихийн хирээр устаж алга болох түр зуурын үзэгдэл гэсэн байр сууринаас хандаж ирсэн учир хуучин тогтолцооны төр криминологийн шинжлэх ухааныг хөгжүүлэх асуудалд сул анхаарахад хүргэсэн. Гэмт хэрэгтэй тэмцэх нь аливаа төрийн дотоод чиг үүрэг болохын хувьд Монголын төр гэмт хэрэгтэй хийх тэмцэл чухал болохыг хүлээн зөвшөөрч, тухайн үеийн албан ёсны шийдвэрт тусгаж ирсэн нь сонирхол татдаг. Тухайлбал: 1921 оны 3-р сард гаргасан "Монгол ардын намаас түмэнд тунхаглан зарлах бичиг"-ийн есдүгээрт "Гэмтнийг гэснээн хашрааж удирдан боловсрулах..." 1924 оны 8-р сард хуралдсан МАХН-ын III их хуралд шүүх яамны илтгэлд Хэрэгт холбогдсон хүн бүрийг насан мууд тооцож үл болно. Юу гэвэл хэрэгтэн ардууд бол их төлөв гачигдсан ба дарлагдсанаас үүссэн хэрэг болох тул /шалтгаан нөхцлийг тусгайлан дурдсан С.Ж/ тэднийг энэрэн үзэж, сэтгэлийг засаж сайнд шилжүүлбэл зохих учир хэрэгтэн ардуудыг *гэгээрүүлэх* явдлыг чухалчилна..." гэж зааснаас үзэхэд гэмт хэрэг, хэрэгтэнтэй тэмцэхэд цээрлэлээс гадна хүмүүжлийн аргыг онцолсон байна. Гэмт явдалтай хэрхэн тэмцэл явуулж, ямар үр дүнд хүргэх асуудал хүн төрөлхтний өмнө тулгарч байсан адармаатай зорилтуудын нэг байсаар байна. Намжсан төрийн ийм харалган бодлого нь 1960 оны "хуулийн байгууллагуудын удирдах ажилтнуудын зөвлөлгөөн" дээр Ю.Цэдэнбалын *"Хөдөлмөрчдийн нийгмийн аж байдал, соёлын хэмжээ, тэдний социалист ухамсар дээшилж байгаагаас үзэхэд гэмт хэрэг гарах нийгмийн шалтгаан арилжээ.* Гэмт хэрэг үйлдэх явдал гагцхүү хуучин заншлаас болж байна. Шударга ажиллахгүйгээс амьдралын зүйлийг хулгай, хуурамч аргаар олох, хүмүүжил сулаас нийгмийн хэв журам эвдэх, сахилгагүйгээс осолдож цалгардаад гэмт хэрэг гарч байна. Эдгээр шалтгааныг арилгаж болох уу, болно. Үүнийг багасгасаар байгаад гэмт хэрэг гарах явдлыг бүр мөсөн устгаж болно" гэж гэмт хэргийн шалтгааныг тэр үеийн нийгмийн сөрөг үйл явдлаас зориуд хөндийрүүлэн зөвхөн "Шударга ажиллахуй", "Хүмүүжил сул", "сахилгагүй" гэсэн бие хүнтэй холбоотой сөрөг зүйчин зүйлүүдээр тайлбарласан нь амьдралаас тасархай, өнгөц, агуулгын алдаатай, "гэмт хэргийг бүр мөсөн устгах" тухай үл гүйцэлдэх зорилт дэвшүүлэхэд шууд нөлөөлсөнтэй холбоотой. Нам, төрийн тэргүүн "Гэмт хэргийг бүр мөсөн устгах" зорилт дэвшүүлснээс шалтгаалан гэмт явдлын мөн чанар, түүний шалтгаан нөхцөлийг хялбарчлан тайлбарлах, энэ үзэгдлийг судлах шинжлэх ухааны үндэслэлийг үл

тоормослох хандлага нам, төрийн бодлого, нийгмийн ухамсар, энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажилд ч удаан хугацаагаар давамгайлах болсон бодит үнэн юм.

- Тухайн үед гэмт явдлын шалтгааныг хуучин нийгмийн үлдэгдэл, хөрөнгөтөн орны харш нөлөөлөл, хүмүүсийн ухамсар ахуйгаас хоцордог тухай нийгмийн хөгжлийн үйлчилгээ зэрэгтэй холбон тайлбарлах алдаатай номлол улиг болсон байв. Тийм ч учраас гарч байсан гэмт явдлыг тухайн нийгмийн хүрээн дэх бодит бахйдалтай холбон онолын суурь судалгаа хийх замаар танин мэдэхийг үл ойшоон танхайрах, хулгайлах, согтуурах явдалтай тэмцэх он дамжсан олон хууль зарлиг, тогтоол шийдвэр гарч байсан боловч биелэгдэх объектив нөхцөл бүрдээгүйгээс хүсэн хүлээсэн үр дүн төдийлөн гарч байгаагүй юм. Энд "**хулгайг устгах**" компаанит ажил (аян) өрнүүлж, хий лоозогнож байсныг дурдахад хангалттай юм.

- Тухайн үеийн эрдэмтэн судлаачдын хийсэн судалгааны дүн, зөвлөмж, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн бодит өсөлт, нийгэм, иргэдэд учруулж байсан хор уршиг зэргийг харгалзан гэмт явдалтай хийх тэмцлийг шинжлэх ухааны үндэстэй явуулах болсны нэг бодит жишээ бол 1972 оны МАХН-ын Төв хорооны УТТ-ны 96-р тогтоолоор "БНМАУ-ын Прокурорын газрын дэргэд "**Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэн**" байгуулсан явдал юм. Энэ нь криминологийн шинжлэх ухааны хөгжилд чухал ач холбогдолтой үйл явдал байв. "Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах арга хэмжээний тухай" МАХН-ын ТХ-ны УТТ-ны 1974 оны 24-р тогтоолд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах ажлыг уг хүрээлэнд төвлөрүүлж, судалгаа шинжилгэний ажлын чиглэлийг тодорхойлон заасан юм.

- Тухайн үеийн эрдэмтэн судлаачдын хийсэн судалгааны дүн, зөвлөмж, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн бодит өсөлт, нийгэм, иргэдэд учруулж байсан хор уршиг зэргийг харгалзан гэмт явдалтай хийх тэмцлийг шинжлэх ухааны үндэстэй явуулах болсны нэг бодит жишээ бол 1972 оны МАХН-ын Төв хорооны УТТ-ны 96-р тогтоолоор "БНМАУ-ын Прокурорын газрын дэргэд "**Гэмт хэргийн шалтгаан нөхцөл судлах хүрээлэн**" байгуулсан явдал юм. Энэ нь криминологийн шинжлэх ухааны хөгжилд чухал ач холбогдолтой үйл явдал байв. "Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах арга хэмжээний тухай" МАХН-ын ТХ-ны УТТ-ны 1974 оны 24-р тогтоолд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах ажлыг уг хүрээлэнд төвлөрүүлж, судалгаа шинжилгэний ажлын чиглэлийг тодорхойлон заасан юм.

- Гэмт хэрэгтэй тэмцэхтэй холбоотой сэдвүүдээр өөрийн оронд 6 удаа эрдэм шинжилгээ, онол практикийн хурал зохион байгуулж үнэтэй санал, зөвлөмж боловсруулж байжээ. Профессор Г.Совд, доктор Р.Гүнсэн, Б.Содовсүрэн болон бусад тус хүрээлэнгийн захирлаар ажиллаж байсан доктор Ж.Авхиа, С.Бүррагчаа, Н.Жанцан болон бусад эрдэм шинжилгээний ажилтнууд, тухайлбал, н.Рэнчиндорж, Б.Эрдэнэбилэг, К.Тажебакед, Д.Сэвжиддорж, С.Наранбулаг, Н.Туяа, Ц.Бүжинлхам зэрэг судлаачид асар их хөдөлмөрлөж,

криминологийг хөгжүүлэх үндэс суурийг тавилцсан гавьяатнууд юм.

- Хуульч Л.Хүрлээ "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хөдөлмөрийн хамт олны ажиллагаа" сэдвээр 1976 онд, хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Н.Жанцан "Насанд хүрээгүйчүүдийн үйлдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх орчин цагийн асуудал" сэдвээр 1981 онд К.Тажебакед "Хөдөө аж ахуйн малыг ашиглан шамшигдуулах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам" сэдвээр 1982 онд, Б.Болдбаатар "Насанд хүрээгүй хүмүүс үйлдэж буй хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зам" сэдвээр 2004 онд, ОХУ-д хууль зүйн доктор Н.Баатаржав "Гэмт явдал, түүний шалтгаан судлалын криминологийн асуудал" сэдвээр 1985 онд тус тус дэд эрдэмтний зэрэг, хамгийн сүүлд буюу 2013 онд доктор, профессор Ж.Болдбаатар "Гэмт хэрэг илрүүлэхэд полиграф ашиглах онол, арга зүйн асуудал" сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг амжилттай хамгаалсан байна.

- Профессор Н.Жанцан 1978 онд "Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлье", "Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд эцэг эхийн үүрэг" 1984 онд "Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж буй гэмт явлын шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам", 1987 онд "Гэмт хрэгрэй тэмцэх, урьдчилан сэргийлэх онол, практикийн асуудал" ном 1999 онд "Криминологи" 2003 онд "Криминологи" сурах бичгүүдийг хэвлүүлжээ. К.Тажебакед "Хөдөө аж ахуйн малыг ашиглан шамшигдуулах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудал", Д.Сэвжиддорж "Худалдааны байгууллага дахь социалист өмчийн эсрэг гэмт хэрэг, тэмцэх арга зам", Л.Рэнчин "Согтуурал ба гэмт хэрэг", Л.Хүрлээ 1978 онд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хөдөлмөрийн хамт олны роль", Ц.Бүжинлхам, С.Наранбулаг 1986 онд "Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажил ба прокурорын байгууллага" 1986 онд Н.Жанцан, С.Нарангэрэл, Н.Баатаржав, К.Тажебакед нар хамтран "Криминологийн сурах бичиг", С.Жанцан 1995 онд "Гэмт явдал судлал", Б.Батзориг 1999 онд "Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах аргачлал", Л.Батжав 2001 онд "Гэмт явдал, түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудал", 2004 онд Н.Жанцан "Криминологи", 2005 онд Ц.Цэлмэг "Криминологи" зэрэг сурах бичиг, гарын авлага хэвлэгдсэн байна. Криминологийн сэдвээр олон тооны магиструуд төрөн гарсан нь энэ салбарыг хөгжүүлэх оюуны асар их хүч юм.

- 1973 оны 3 дугаар сарын 1-ний өдөр Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэд байгуулагдсан "Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах хүрээлэн" хэмээх эрдэм шинжилгээний бие даасан байгууллага байгуулагдаж манай улсад түгээмэл үйлдэгддэг, нийгмийн хор аюул ихтэй, хүний бие, эрүүл мэнд, социалист өмч, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүдийг дагнан судалж, тэдгээртэй төрийн байгууллага, иргэд, хууль сахиулах байгууллагууд хэрхэн тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг боловсруулан төрийн эрүүгийн бодлогод тусгуулж байсан боловч гэмт явдлын шалтгаан судлалын хүрээнд

хүрээлэнгийн судлаачид социалист нийгэмд бодитойгоор оршин байсан ажилгүйдэл, ядуурал, согтуурал зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдийг судалгаагаар илчлэн засаж залруулах арга замын талаар төрийн эрх барих, засаглах байгууллагуудад судалгааны тайлан (үр дүн) хэлбэрээр хүргүүлж байсан нь яваандаа төр, засгийн эрх баригч хүчнүүдэд таалагдахгүй болж ирсэн гэдэг. Ингээд ийм хүрээлэнг цаашид байлгах шаардлагагүй гэж үзээд 1983 онд 10 жилийн ойн босгон дээр татан буулгасан байдаг.

- Гэмт явдал судлалын хүрээлэнг татан буулгаснаар нийгмийн энэ сөрөг үзэгдэлтэй хийх тэмцлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны үр дүнд тулгуурлан хэрэгжүүлэхээс татгалзасан хэрэг юм.

- 1997 онд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай бие даасан хууль баталж, улмаар хууль зүйн яамны дэргэд гэмт хэргийн шалгаан, нөхцөл судлах хүрээлэн байж болохоор хуульчилсан нь чухал үйл явдал болсон. Гэвч энэ хүрээлэнг 5 жилийн дараа Цагдаагийн академийн дэргэд 2002 онд байгуулсан нэртэй боловч захирлаар нь автын инженер хурандааг томилсон боловч энэ хүрээлэн ямар ч үйл ажиллагаа явуулаагүй, бүтэц нь бүрдээгүй байсаар замхарсан байдаг.

- ЦЕГ-ын криминологи судалгаа хариуцсан байцаагчийн албан тушаал 2005 оноос бий болсон, 2011 оноос Мэдээлэл судалгааны төвийн Криминологи судалгааны төв, хэлтэс байгуулсан.

- Хуульчдийн давтан сургалтын төв нь Хууль зүйн үндэсний төв болж өргөжин, 2004 онд Криминологийн судалгааны сектор, 2009 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор, 2012 онд Нийтийн эрх зүйн судалгааны багт бүтцийн хувьд хамаарах болсон.

- Хууль зүйн сайдын 2012 оны Б/20 дугаар тушаалаар баталсан их сургуулийн бүтцэд Шинжлэх ухаан, технологийн газар байгуулан, түүний харъяанд Цагдаа, Хил, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл, Шүүхийн шинжилгээ судлалын төвүүд салбарын хэмжээний эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг явуулж, хэтийн төлөв, бодлого, үйл ажиллагааг тодорхойлолцож байна. Цаашид тус газрын харъяанд Гамшгийн эрсдэл судлалын төв, Инновацийн төв байгуулах чиглэлтэй байна.

2008 онд Цагдаагийн академийн бүтцэд Криминологи судалгааны тасаг байгуулагдаж, улмаар 2012 онд Хууль сахиулахын их сургуулийн Шинжлэх ухаан, технологийн газарт Цагдаа судлалын төв гэсэн явцуу бүтцээр, 5 орон тоотой гэмт хэрэгтэй тэмцэх бодлого боловсруулах ажлыг хийж байна.

Хоёр. Хууль сахиулахын их сургуулийн криминологи судалгааны өнөөгийн байдал

Хууль сахиулахын их сургуулийн Шинжлэх ухаан, технологийн газрын Цагдаа судлалын төв анх Дотоод хэргийн их сургуулийн бүтцэд 2011 оны 8 сард байгуулагдсан гэж үзэж болно.

Цагдаа судлалын төв:

а) гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого судлал,

б) гэмт явдлын шалтгаан, нөхцөл судлал,

в) гэмт хэрэгтэн бие хүн судлал,

г) гэмт явдлаас урьдчилан сэргийлэхүй судлал,

д) хэв журам хамгаалахуй судлал,

е) цагдаагийн түүх, менежмент, боловсрол, хүний нөөц, албаны техник, тусгай хэрэгсэл судлал,

ж) цагдаа-олон нийтийн харилцаа судлал гэсэн чиглэлээр цагдаагийн байгууллагын болон бусад төрийн байгууллагын захиалгат болон төлөвлөгөөт судалгааг хэрэгжүүлж байна.

Түс төв байгууллагдсанаас хойш хийсэн криминологи судалгааг товч дурдвал:

- ХЗЯ-наас ирүүлсэн даалгаврын дагуу "Гэрч, хохирогчийг хамгаалах шатанд прокурор, гааль, цагдаа, тагнуулын байгууллагын уялдаа холбоо, хамтын ажиллагаа", "Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал" сэдэвт судалгаа явуулж, судалгааны тайланг тус их сургуулийн захиралд танилцуулан, улмаар ХЗЯ-нд хүлээлгэн өгөв.

- ЦЕГ-аас 2012 оноос эхлэн хийлгэх 42 судалгааны ажлын захиалга ирүүлсэнээс 2012 онд:

- "Нийслэлийн дүүргийн хороо бүрт ажиллаж буй хэсгийн байцаагчийн эрх зүйн орчин, ажиллах нөхцөл, цаашид авах арга хэмжээ",

- "Цагдаагийн албаны өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдаж буй тусгай техник, хэрэгсэл, компьютер мэдээллийн хэрэгслийн хангалт, ашиглалтын байдал, цаашид авах арга хэмжээ",

- "Цагдаагийн хөдөлгөөнт эргүүлийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, боловсронгуй болгох арга зам" сэдэвт судалгааг "**Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл**" сэдэвт нэгтгэн, нэгдсэн удирдамжаар ЦЕГ-тай хамтран явуулж, судалгааны тайланг ХЗЯ, ЦЕГ-ын удирдлагад хүргүүлжээ. Энэхүү судалгааг салбарын эрдэмтэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар хийсэн анхны иж бүрэн судалгаа гэж үнэлсэн юм.

Зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал:

- Цагдаа судлалын төвөөс санаачлан 2012 онд **"Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд тулгамдаж буй асуудал"** сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг мөн оны 6 дугаар сарын 13-нд Гадаад харилцааны яаманд, 2013 онд **"Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага"** олон улсын эрдэм шинжилгээний хурлыг мөн оны 5 дугаар сарын 23-нд Төрийн ордонд тус тус амжилтай зохион байгуулсан. Эдгээр олон улсын хуралд гадаад, дотоодын төрийн болон иргэний нийгмийн өргөн төлөөлөл оролцож, хурлын эмхэтгэл, санал зөвлөмж гаргасан нь чухал ач холбогдолтой болсон.

"Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага" суурь судалгаа, үүнтэй уялдаатай түгээмэл үйлдэгддэг "Монгол Улсад үйлдэгдэж буй бусдын эд хөрөнгө хулгайлах гэмт хэргийн түгээмэл төрөл, шалтгаан нөхцөл", "Мансуурууулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага" сэдэвт хавсарга судалгааг

явуулж, тайланг эрхлэн гаргаж, Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага олон улсын эрдэм шинжилгээний хурлын II эмхэтгэлд хэвлүүлэв.

- Цагдаагийн ерөнхий газраас эрхлэн гаргадаг "**Улсын хэмжээнд 2011 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ, түүний үзүүлэлтүүдэд**" дүн шинжилгээ хийж, санал зөвлөмж бэлтгэн ЦЕГ-т хүргүүлж, хариуг авч, боловсронгуй болгох талаар хамтран ажиллаж байна. Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, цагдаагийн ахмад Б.Мөнхдорж "Монгол Улс дахь 2011 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх санал" товхимлыг ЦЕГ-ын МСТ-тэй хамтран эрхлэн гаргасан байна.

Гурав. Хууль сахиулахын их сургуулиас хэрэгжүүлэх криминологи судалгааны чиг хандлага

- Гэмт хэрэг, зөрчилтэй хийх тэмцлийг ямар нэг хэмжээгээр зохицуулсан агуулгатай олон тооны хууль батлан мөрдсөн боловч дорвитой үр дүн харагдахгүй байна.

- Гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох үйл явц, төрийн бодлого, шинжлэх ухааны үндэслэл бүхий судалгааны үр дүнд түлгуурлахгүй, баримжаагаар явж ирлээ.

- Манай Цагдаа судлалын төв нийгэмд газар авч байгаа шинэ төрлийн, өөрөөр хэлбэл тэмцлийн өвөрмөц арга, хүч хэрэгсэл шаардсан, террор үйлдэх, хүн хүдалдаалах, барьцаалах, хулгайлах, банк, санхүүгийн зохион байгуулалтай луйвар хийх, мөнгө угаах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, хорт болон аюулт бодис наймаалцах, хар тамхи, мансуурууулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг үйлдэх, мэдээллийн аюулгүй байдалд халдсан кибер гэмт хэрэг үйлдэх зэрэг үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг боловсронгуй болгох арга замыг судалж байна.

Засгийн газраас барьж буй бодлогоос дүрдвал:

- Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн V бүлэгт "**судалгаа, шинжилгээний ажлыг их, дээд сургууль болон бодлогын институт дээр төвлөрүүлж, Шинжлэх ухаан, технологийг дэмжих сангийн санхүүжилтийг энэ зорилготой уялдуулна**" гэж туссаны зэрэгцээ хууль зүйн салбарын шинэтгэлийн хүрээнд хийгдэх төлөвлөгөөт болон захиалгат эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг Хууль сахиулахын их сургуульд төвлөрүүлэн гүйцэтгэж байна.

- Хууль сахиулахын их сургуулийг шинэтгэлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэхийн тулд харъяа агентлагийн захиалгаар хязгаарлагдахгүй гадаад, дотоодын байгууллагын захиалгаар судалгааны ажил, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, олон улсын жишигт нийцсэн судалгааны их сургууль болох зорилт тавин ажиллаж байгааг хэлэхэд таатай байна.

- Засгийн газар болон Хууль сахиулахын их сургуулийн дээрх зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнгээр шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах, энэ салбарын

хөгжлийн тодорхойлох илүү өргөн цар, хүрээ, бүтэцтэй шинжлэх ухааны байгууллага байгуулах шаардлагад үндэслэн Хууль сахиулахын их сургуулийн Шинжлэх ухаан, технологийн газрын Цагдаа судлалын төв, Шүүхийн шинжилгээ судлалын төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийг нэгтгэн Криминологи судалгааны үндэсний хүрээлэн байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

- Хууль сахиулахын их сургуульд криминологийн институт байгуулахад БНСУ-ын Криминологийн институтээс туршлага судалж, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ гэдэгт найдаж байна.



О.БАТСАЙХАН

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш, ахмад

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ АШИГЛАХ НЬ

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх судалгааны ажил явуулахад Монгол Улсын нийгмийн харилцааны хөгжил, эрх зүйн шинэчлэлтийн бодлого, хэрэгжилтийн түвшинтэй уялдуулан гаргах шаардлагатай болж байна Монгол Улсын ШШГЭЗ-н шинжлэх ухаан судалгаандаа хэдий чинээ оновчтой **арга** хэрэглэнэ, үр дүн нь төдий чинээ сайн байх болно. ШШГЭЗ-н судалгааны үндсэн арга нь диалектик арга байдаг. Диалектик аргын мөн чанар нь аливаа асуудлыг судлахдаа шинжлэх ухаан, техникийн ололт, байгаль нийгмийн үзэгдэл, хөгжлийн зүй тогтолд тулгуурлан, юмс үзэгдлийн мөн чанарыг нээн илрүүлдэгт оршино. Тиймээс аливаа асуудлыг судлахдаа нэг талыг баримтлан туйлшрахаас болгоомжлох, юмс үзэгдлийн мөн чанарыг хөгжил хөдөлгөөнд нь тулгуурлан харилцан уялдаатайгаар авч үзэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд шинжлэх ухааны судалгааны аргад тулгуурлан уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай болдог.

Ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд ял эдлэгсдэд ШШГЭЗ-н

хөгжлийн тодорхойлох илүү өргөн цар, хүрээ, бүтэцтэй шинжлэх ухааны байгууллага байгуулах шаардлагад үндэслэн Хууль сахиулахын их сургуулийн Шинжлэх ухаан, технологийн газрын Цагдаа судлалын төв, Шүүхийн шинжилгээ судлалын төв, Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийг нэгтгэн Криминологи судалгааны үндэсний хүрээлэн байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

- Хууль сахиулахын их сургуульд криминологийн институт байгуулахад БНСУ-ын Криминологийн институтээс туршлага судалж, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ гэдэгт найдаж байна.



О.БАТСАЙХАН

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн процессын эрх зүйн тэнхимийн ахлах багш, ахмад

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХЭД СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ АШИГЛАХ НЬ

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх судалгааны ажил явуулахад Монгол Улсын нийгмийн харилцааны хөгжил, эрх зүйн шинэчлэлтийн бодлого, хэрэгжилтийн түвшинтэй уялдуулан гаргах шаардлагатай болж байна Монгол Улсын ШШГЭЗ-н шинжлэх ухаан судалгаандаа хэдий чинээ оновчтой **арга** хэрэглэнэ, үр дүн нь төдий чинээ сайн байх болно. ШШГЭЗ-н судалгааны үндсэн арга нь диалектик арга байдаг. Диалектик аргын мөн чанар нь аливаа асуудлыг судлахдаа шинжлэх ухаан, техникийн ололт, байгаль нийгмийн үзэгдэл, хөгжлийн зүй тогтолд тулгуурлан, юмс үзэгдлийн мөн чанарыг нээн илрүүлдэгт оршино. Тиймээс аливаа асуудлыг судлахдаа нэг талыг баримтлан туйлшрахаас болгоомжлох, юмс үзэгдлийн мөн чанарыг хөгжил хөдөлгөөнд нь тулгуурлан харилцан уялдаатайгаар авч үзэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд шинжлэх ухааны судалгааны аргад тулгуурлан уялдуулан хэрэгжүүлэх шаардлагатай болдог.

Ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд ял эдлэгсдэд ШШГЭЗ-н

шинжлэх ухаан хөгжлийнхөө үе шатуудад хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх, хүмүүжлийн нөлөө үзүүлэх гэхчилэн янз бүрийн байр сууринаас хандан үнэлэлт, дүгнэлт өгч байсан ба цаашид боловсронгуй болгоход шинжлэх ухааны судалгааны арга ,арга зүйн олон талын хамаарал шаардлагатай байгаагаар тод илрэн гардаг. Хорих ялыг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхэд гэхчлэн нас, хүйсийн байдлыг харгалзан тус тусад нь эдлүүлэхээс гадна ялтанд үзүүлэх эрхийн хязгаарлалтын хэр хэмжээгээр өөр хоорондоо ялгарах дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлдэг, сүүлийн 10 жилийн дунджаар жилд 7272 хүн хорих ял эдэлдэг. Практик алба хаагчдийн хийсэн судалгааны дүнгээс[9] үзэхэд жилдээ хорих байгууллагаар дамжиж байгаа хүмүүсийн тоо 8000 байдаг.[10]

Монгол улс өнөөгийн байдлаар шоронд ял эдлэж байгаа хүний тоогоор зарим улс оронтой харьцуулан авч үзвэл дараахь үзүүлэлттэй байгааг харж болно.

/Prison Brief for Mongolia[11]/

Шоронд байгаа хүний тоо /цагдан хоригдож байгааг орсон/	7,265 2012 оны байдлаар
Ял эдэлж байгаа хоригдлын дундаж тоо (100.000 хүн тутамд)	269 /2.7 сая хүн амтай/ дэлхийд 216 улсаас 44-т жагсаж байна.
Эмэгтэй хоригдол (нийт хоригдлын дунд эзлэх хувийн жин/	6.2%
Хүүхэд (нийт хоригдлын дунд эзлэх хувийн жин/	1.0% (18 наснаас доош)
Хорих газар	62 (25 хорих ял эдлүүлэх газар, 26 цагдан хорих төв, 11 баривчлах байр)
Хорих ял эдэлсэн байдал	1995 - 6,085 - (270) 1998- 6,070 - (265) 2001 6,414 - (271) 2005 7,256 - (296) 5\ 2008 6,998 - (274) 2012 7,570 - (287)

Эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр: 2009 онд батлагдсан Ялтны дунд явуулах сургалт, хүмүүжлийн ажлын зааврыг шинэчлэн ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/106 тоот тушаал "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны сэтгэл зүйчийн ажлын заавар" ШШГЕГ-ын даргын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/107 тоот тушаал "Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар"-уудыг батлан гаргаж мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн холбогдох эрх зүйн бичиг баримтуудыг мөрдлөг болгон ажиллаж байна. Одоогийн байдлаар хорих байгууллагад нийгмийн ажилтан-71, мэргэжлийн сэтгэл зүйч -26 ажиллаж байна.

он	2008	2009	2010	2011	2012
Нийгмийн ажилтан	50	55	58	67	71
Мэргэжлийн сэтгэл зүйч	7	8	10	13	26

Практикт ялтны дунд явуулж байгаа судалгааны чиглэлийг дараахь хүснэгтээс харагдана.

Он	2008	2009	2010	2011	2012 хагас жил
Хорих анги, ШГА –д хөдөлмөр эрхэлж, дадал чадвар эзэмшсэн нийт ялтан давхардсан тоогоор	298	698	1896	2154	206
Мэргэжил эзэмшүүлэх төвөөр дамжуулан	-	-	300	535	55
Бичиг үсгийн сургалтанд хамрагдсан	75	59	58	50	33
Амьдрах ухааны	254	245 .	213	113	-

[9] Ц.Мөнхбат. УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор., "Хорих ялын хэрэгжилт өнөөгийн байдал", эрдэм шинжилгээний өгүүлэл, Хууль дээдлэх ёс сэтгүүл 2009 оны №2., 73 дах тал

[10] Д.Дамдинцэрэн. "Шүүхийн шийдвэр, түүний хэрэгжилт" илтгэл. "Эрх зүйт төр-хууль ёсны хэрэгжилт" /Үндэсний зөвлөгөөний илтгэлүүд/. 2008 он. 162 дахь тал.

[11] http://www.prisonstudies.org/info/worldbrief/wpb_country.php?country=104 /last visited 2011.10.31/

сургалт					
Гадаад хэлний сургалт	10	45	79	51	
Компьютерийн сургалт	-	35	27	58	

Хорих ангиас суллагдан одоогийн байдлаар ажлын байранд зуучлуулан, ажил хийж байгаа иргэний судалгааг 2012 оны хагас жилийн байдлаар нэгтгэн үзэхэд **нийт 95** иргэнийг ажилд болон сургуульд зуучлан оруулж ажилласан байна.

Судалгаанд хамрагдсан иргэний боловсролын түвшинг авч үзвэл:

Боловсрол:

- боловсролгүй-4,
- бага боловсролтой- 11,
- бүрэн бус дунд-38,
- бүрэн дунд-30,
- дээд болон тусгай дунд мэргэжилтэй-12,

Мэргэжил:

- мэргэжилгүй-46,
- мэргэжилтэй-49,

Ажил эрхлэлт:

- одоогийн байдлаар хувиараа үйлдвэрлэл эрхлэж байгаа-13,
- хувийн компанид-68,
- төрийн үйлчилгээний байгууллагад- 14 иргэн тус тус ажиллаж байна.



Дээрх судалгаануудаас үзэхэд нийт ял эдлэгсдийн 0.8%-ийг эзэлж байгаа нь хорих байгууллага болон судлаачдаас ялтныг судлах үйл ажиллагааг тодорхой үе шаттайгаар, шинжлэх ухааны судалгааны арга,арга зүйг ашиглан өргөжүүлэх асуудал чухлаар тавигдаж байгааг харуулна.

Дэлхий дахинд ял эдэлж байгаа болон шоронгоос суллагдсан хүмүүст чиглэсэн төрийн бодлого үндсэн хоёр хэлбэртэй байдаг. Үүнд :

-Social control of criminals буюу нийгмийн хяналтын хэлбэр

-Rehabilitation of criminals буюу нийгэмд амьдрахад нь дэмжлэг үзүүлэх хэлбэр

Энэ хоёр хэлбэр нь тухайн улсын нийгмийн хөгжлийн чиг баримжаатай холбоотойгоор тодорхойлогддог.[12]

Нийгмийн хяналт нь шоронгоос



суллагдсан хүмүүсийг *"засрашгүй хүмүүс"* гэж үзээд "давтан, рецидив гэмт хэрэгтэн" хэмээн нэрлэж, түүнтэй хийх тэмцлийг чангатгадаг. Хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэж байгаа нь хууль тогтоомжийг үл ойшоож, засарч хүмүүжихийг хүсэхгүй байгааг илтгэн харуулах шалгуур гэж үзэж шоронгоос суллагдсан хүмүүст нийгмийн зүгээс тавих хяналт илүү чанга байх ёстой бөгөөд ингэснээр тэднийг ахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чадна гэж үздэг.

Харин зарим орнуудад хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн сэтгэл зүйг эмчлэх, нийгмийн туслалцаа үзүүлэх ажлын

[12] Susan Ehrlich Martin, Lee Sechrest, Robin Redner. 1981, National Research Council (U.S.). Panel on Research on Rehabilitative Techniques 'New directions in the rehabilitation of criminal offenders'

онолын үндэслэл 1970-аад оноос эхлэн ул суурьтай хөгжиж эхэлжээ. Энэ нь гэмт хэрэгтнийг нийгэмд дахин засаж, хүмүүжүүлж болдог, ингэхийн тулд шоронгоос суллагдсан хүмүүст туслалцаа дэмжлэг хэрэгтэй гэсэн хүмүүнлэг үзэлд тулгуурладаг. Ялтныг нийгэмшүүлэх чиглэлээр тусгайлан бэлтгэсэн мэргэжилтнүүд ажилладаг бөгөөд насанд хүрсэн хүн, хүүхдэд хүртэл ялгаатай сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч, мэргэжилтнүүд үйлчилдэг. Өөр нэг чухал зүйл нь *Ausbildung /мэргэжил олгох сургалт-их дээд сургуулиар олгох шаардлагагүй. сургалт үйлдвэрлэлийн төв/* тогооч жолооч, даатгалын ажилтан, мужаан, слесарь гэх мэт мэргэжил олгодог байна. Эдгээрийг санал болгосон байгууллагуудад хүргүүлдэг бөгөөд үүнийг хорих анги болон өөр төрлийн ял эдэлж байгаа хүмүүсийн дунд зохиодог төдийгүй суллагдсан хүнд ч хамааралтай байдаг байна. Энэ нь дараа нь энгийн амьдарлаа цааш нь хэвийн үргэлжүүлэхэд нилээд чухал үүрэгтэй байдаг бас баталгаа болдог байна.

Судалж үзсэн гадаадын улсуудад :

- *Хорих ял эдлүүлэх байгууллагын тухай хууль тогтоомжид өөрчлөлт хийх*
- *Хүний нөөцийг шинэ нөхцөлд ажиллах бэлтгэлийг хангах*
- *Ялтныг судлах ажлыг шинжлэх ухааны судалгааны арга зүйн үндэстэй явуулдаг* зэрэг цогц арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

<u>Судалгааны хүрээнд гаргах санал, зөвлөмж</u>

Хорих ял эдлэгсдийг судлахад дараах бүлэг асуудлыг анхаарах. Үүнд:

Нэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулснаар шийднэ гэж үзэх нь учир дутагдалтай юм. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах, ялтныг нийгэмшүүлэх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд хорих ангийн алба хаагчийн ажлын дундаж ачааллыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах асуудал онцгой ач холбогдолтой.

Үүн дээр нэмж ялын эрх зүйн зохицуулалт, эдлүүлэх хэлбэрийг илүү тодорхой болгож, ялтныг нийгэмшүүлэх, тэдний дунд явуулах судалгааг шинжлэх ухааны үндэстэй явуулах шаардлагатай. Шинжлэх ухаанд өргөн хэрэглэгддэг нотлох, дүгнэх, задлан шинжлэх, адилтгах, харьцуулах, загварчлах аргуудыг хэрэглэх.

Одоо хэрэгжүүлж байгаа анкетын судалгаа авах, бичиг баримт судлах, ял эдлүүлэх ажиллагааны тоо бүртгэл материалд дүн шинжилгээ хийх, зэрэг социологийн аргыг "Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр"-ын уялдааг хангахаас гадна, практик амьдралтай холбоотой, үндэслэл, нотолгоотой, дүгнэлт сайтай, судалгаа нь арга зүйн үндэстэй байх.

Хоёр. Гадаадын зарим орны эрдэмтэн, судлаачдын судалгаа явуулж буй арга, арга зүйн сайн хувилбарыг өөрийн хөрсөнд "буулгах"-даа ялтныг хөдөлмөрлөх, нийгэмд ажиллаж, гэр бүлийнхэнтэйгээ холбоотой байх боломж олгосон, дахин, давтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлсэн, сэтгэл зүй, зан байдалд нь өөрчлөлт орсон, гэмт хэрэг үйлдэх дадал, зуршилаасаа бүрэн татгалзсан, олон улсад үр дүнг нь илэрхий болсон байх шинжийг энэ тэргүүнд харгалзах.

Гурав. Хорих ангид ял эдэлж байгаа болон суллагдаж гарсан хүмүүст чиглэсэн төрийн дэмжлэг туслалцааны бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах нь шинжлэх ухааны үндэстэй судалгааг явуулах зайлшгүй чухал гэж үзнэ. Ийм хөтөлбөрийн зэрэгцээ ялтан хорих ангид байхдаа болон суллагдсанаас хойш гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх бодлогыг мөн хэрэгжүүлж байж хорих ялын

зорилго биелдэг гэж гадны судлаачид бичсэн байна.

Хорих ялын үр нөлөөг дээшлүүлэхэд эрх зүйн бус шинжлэх ухаан болох сэтгэл судлал, сурган зүй, эдийн засаг, менежментийн шинжлэх ухааны судалгааны аргатай нягт уялдаатай хөгжүүлэн, ямар байдлаар яаж холбогдох нь ял эдэлж буй субьектүүдийн эрхийн байдал, ялангуяа ял эдлүүлэх нөхцөл, журмыг хэрхэн боловсронгуй болгохоос ихээхэн шалтгаална. Сэтгэл судлалын шинжлэх ухааны үндсэн зарчмууд бүх төрлийн ял эдлэх, эдлүүлэх ажиллагаанд оролцогч субьектүүдэд тохирч байхад, ардын уламжлалт сурган хүмүүжүүлэх ухааны аргыг хорих ял эдлэгсэдэд хэрэглэхэд илүү үр нөлөөтэй байх жишээтэй байдаг ажээ.



М.ЦЭНД

Оросын Холбооны Улсын Дотоод Явдлын Яамны Москвагийн их сургуулийн адьюнкт, хурандаа

ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛАХ ХОЙШЛУУЛШГҮЙ АЖИЛЛАГАА

Хорих байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, нас баралт, орголтын тоон үзүүлэлтүүдийг судлан үзэхэд 2000 онд ялтны дундаас үйлдэгдсэн гэмт хэрэг 164, зөрчил 1265, нас баралт 97, орголт 333 байсан бол 2008 онд гэмт хэрэг 28, зөрчил 851, нас баралт 15, орголт 10 болж буурсан нь ШШГБ-н үйл ажиллагааны амжилтыг илэрхийлсэн сайн үзүүлэлт хэдий ч ЭБШХуулийн 172-р зүйл буюу хорих байгууллагад гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг шалгах, “хойшлуулшгүй ажиллагаа” явуулах мэдлэг, мэргэжлийн ур чадвартай байхыг биднээс шаардаж байна.

д/д	Он	Гэмт хэрэг			Бүгд	Зөрчил			
		Хорих анги	ЦХБ	БЯЭБ		Хор анги	ЦХБ	БЯЭБ	
1	2000	164			164	1265			1265
2	2001	178			178	1159			1159
3	2002	77			77	1290			1290
4	2003	29	5		34	953	54		1007
5	2004	10	8		18	854	196		1050
6	2005	23			23	858	170	13	1041
7	2006	4			4	532	4	4	540
8	2007	27	2		29	736	123		859
9	2008	24	4		28	773	78		851

зорилго биелдэг гэж гадны судлаачид бичсэн байна.

Хорих ялын үр нөлөөг дээшлүүлэхэд эрх зүйн бус шинжлэх ухаан болох сэтгэл судлал, сурган зүй, эдийн засаг, менежментийн шинжлэх ухааны судалгааны аргатай нягт уялдаатай хөгжүүлэн, ямар байдлаар яаж холбогдох нь ял эдэлж буй субьектүүдийн эрхийн байдал, ялангуяа ял эдлүүлэх нөхцөл, журмыг хэрхэн боловсронгуй болгохоос ихээхэн шалтгаална. Сэтгэл судлалын шинжлэх ухааны үндсэн зарчмууд бүх төрлийн ял эдлэх, эдлүүлэх ажиллагаанд оролцогч субьектүүдэд тохирч байхад, ардын уламжлалт сурган хүмүүжүүлэх ухааны аргыг хорих ял эдлэгсэдэд хэрэглэхэд илүү үр нөлөөтэй байх жишээтэй байдаг ажээ.



М.ЦЭНД

Оросын Холбооны Улсын Дотоод Явдлын Яамны Москвагийн их сургуулийн адьюнкт, хурандаа

ХОРИХ БАЙГУУЛЛАГАД ЯВУУЛАХ ХОЙШЛУУЛШГҮЙ АЖИЛЛАГАА

Хорих байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, нас баралт, орголтын тоон үзүүлэлтүүдийг судлан үзэхэд 2000 онд ялтны дундаас үйлдэгдсэн гэмт хэрэг 164, зөрчил 1265, нас баралт 97, орголт 333 байсан бол 2008 онд гэмт хэрэг 28, зөрчил 851, нас баралт 15, орголт 10 болж буурсан нь ШШГБ-н үйл ажиллагааны амжилтыг илэрхийлсэн сайн үзүүлэлт хэдий ч ЭБШХуулийн 172-р зүйл буюу хорих байгууллагад гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг шалгах, “хойшлуулшгүй ажиллагаа” явуулах мэдлэг, мэргэжлийн ур чадвартай байхыг биднээс шаардаж байна.

л/д	Он	Гэмт хэрэг			Бүгд	Зөрчил			
		Хорих анги	ЦХБ	БЯЭБ		Хор анги	ЦХБ	БЯЭБ	
1	2000	164			164	1265			1265
2	2001	178			178	1159			1159
3	2002	77			77	1290			1290
4	2003	29	5		34	953	54		1007
5	2004	10	8		18	854	196		1050
6	2005	23			23	858	170	13	1041
7	2006	4			4	532	4	4	540
8	2007	27	2		29	736	123		859
9	2008	24	4		28	773	78		851

Нас барсан, оргосон ялтан, сэжигтэн, яллагдагчдын судалгаа \1997-2008 он\



Хорих байгууллагын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, учралын тухай гомдол мэдээллийг шалган шийдвэрлэхийн тулд Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зохицуулсан хэм хэмжээнүүдийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл ШШГЭЗүй, ЭБШЭЗүй нь хуулийн дараах заалтуудаар уялдан хэрэгжинэ. Үүнд:

Хойшлуулшгүй ажиллагаа явуулах \ЭБШХ-н 172-р зүйл\, сэжигтэн яллагдагчид цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авах \59,68-р зүйлүүд\, хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтооолыг гүйцэтгэх \330-р зүйл\,торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах \332-р зүйл\, өвчний учир хугацаанаас өмнө ял эдлэхээс чөлөөлөх \333-р зүйл\,хорих ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах, ялаас чөлөөлөх \334 дүгээрзүйл\, гянда \335-р зүйл\, торгохялыгбаривчлах, хорих ялаар солих, хорих ял оногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулсныг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх \336-р зүйл\, эмнэлгийн байгууллагад байсан хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцох \337-рзүйл\, тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх \339-р зүйл\, ял

№	Он	Жилийн эцэст хоригдогсдын то			Нас барагсдын тоо				Оргодлын тоо			Бүгд
		Ялтан	Сэжигтэн	Нийт	Хорих	БЯЭБ	ЦХБ	Бүгд	Хорих	БЯЭБ	ЦХБ	
1	1997	6069			362			362	421			421
2	1998	6178			242			242	403			403
3	1999	6376			182			182	443			443
4	2000	5662			97			97	333			333
5	2001	6642			53			53	174			174
6	2002	6564	1151	7715	39			39	73			73
7	2003	5999	1666	7665	34	1	5	40	68	3	18	89
8	2004	6288	1810	8098	27		5	32	32	1	16	49
9	2005	7058	1848	8906	30		7	37	41		11	52
10	2006	5179	1561	6740	29		1	30	23	1	11	35
11	2007	6149	1771	7920	16		1	17	17		1	18
12	2008	6289	1869	8150	13		2	15	10			10

эдлүүлэх зорилгоор монгол улсын иргэнийг

шилжүүлж авах тухай хүсэлтийг хянан шийдвэрлэх \412-р зүйл\ зэрэг заалтууд хамаарна.

Монгол Улсын ЭБШХуулийн 7-р хэсгийн 21-р бүлгийн 171-р зүйлд “Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг 5 хоногт багтаан хянаж эрүүгийн хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Нэмэлт , хэргийн газарт үзлэг хийх шаардлагатай бол энэхүү хугацааг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга 14 хүртэл хоногоор сунгаж болно” гэж заажээ.

ЭБШХуулийн 172.3-р зүйлд: “Гомдо ”, 172.4.3. “хорих ангийн харьяа нутаг дэвсгэр дээр ялтны үйлдсэн гэмт хэрэгт хорих ангийн дарга, дэд дарга хойшлуулшгүй ажиллагаа явуулна” гэж тус тус заасныг манай ажилтнууд хэрэн хэрэгжүүлэхээ зарим талаар мэддэггүй юм. Иймд хойшлуулшгүй ажиллагаа гэж юу болох, түүний заалт бүрийг хууль зүйн хүрээнд хэрхэн хэрэгжүүлэхийг тайлбарлахаар зорьлоо.

Хойшлуулшгүй гэдэг нь “яаралтай”, “нэн даруй” гэсэн утгатай бөгөөд “хойшлуулшгүй ажиллагаа” гэдэг нь гэмт хэрэг, учралын тухай гомдол мэдээллийг хугацаа алдалгүй яаралтай баримтжуулан шалгаж гэмт хэрэг мөн эсэх, эрүүгийн хэрэг үүсгэх эсэх тухай асуудлыг шийдвэрлэхийн тулд ЭБШХуулийн 172-р зүйлийг нэн даруй хэрэгжүүлэх идэвхтэй үйлдлийг хэлнэ.

Монгол Улсын Эрүүгийн Байцаан шийтгэх хуулийн 172-р зүйлийн 3.1-д зааснаар“хүнийнэрхаягийгтодруулахзорилго орбаримтбичигшалгах” гэдэгт иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, гадаад паспорт, ажлын үнэмлэх, жолооны үнэмлэх зэргийг хамааруулан ойлгож болно.

Мөн хуулийн 172.3.2-р зүйлд зааснаар“ хүний бие, тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд үзлэг хийх” гэдэгт тухайн хүний бие, хувцас, эд зүйл, гар тээш, цүнх, уут, савыг хамааруулахаас гадна “тээврийн хэрэгсэл”-д автомашин, галт тэрэг, усан болон нисэх онгоц, завь, ердийн хөсөг, унадаг дугуй зэргийг, “ачаа тээш” гэдэгт автомашин, ердийн хөсөг, унадаг дугуй, галт тэрэг, агаарын болон усан онгоцоор зөөвөрлөн авч явахаар баглаж, бэлтгэсэн ачааг хамааруулна. ЭБШХуулийн 126-2, 127,129,130-р зүйлийг мөрдлөг болгон “үзлэг хийх” ажиллагааг гүйцэтгэнэ.

ЭБШХуулийн 172.3.3-р зүйлд заасан “аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эд зүйл, эд хөрөнгө, мөнгө агуулсан байр сав” гэдэгт аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс тэдгээрийн эд бараа, материал, мөнгө, үнэт зүйлс хадгалах зорилгоор ашиглаж буй тусгайлан тоноглосон өрөө тасалгаа, агуулах савыг хамаатуулах бөгөөд битүүмжлэх ажиллагааг явуулахдаа “сэжигтэн яллагдагч, тэдний асрамжинд байгаа хүмүүсийн өдөр тутмын зайлшгүй хэрэгцээний зүйлсийг битүмжилж болохгүй” гэсэн ЭБШХуулийн 134-р зүйлийн заалтыг баримтлах хэрэгтэй. Битүүмжлэх ажиллагааг гүйцэтгэхэд ЭБШХуулийн 134, 140-р зүйлийг удирдлага болгоно.

Хуулийн 172.3.4-т заасан “тээврийнхэрэгслийгсаатуулах, эдзүйл, мөнгийгтүрхугацаагаархураажавах” гэдэгт хэрэгт ач холбогдол бүхий эд зүйл, мөнгийг тухайн ажилтан зохих журмаар өөрийн мэдэлд түр хадгалж байх явдал юм.

“Саатуулах” гэдэг нь тухайн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хугацаагаар зогсоохыг хэлнэ.ЭБШХуулийн 132,133, 137,138,140-р зүйлийг баримтална.

Мөн хуулийн 172.3.5-р зүйлд“ шүүхэмнэлэг, криминалистикийн болон бусад шинжилгээнд зориулж дээж, хурууныхээ, ул мөрний хэв авах”-аар заажээ. “Дээж” гэдэгт хурууны хээнээс бусад хүний биеэс харьцуулсан шинжилгээнд авч болох толгойн болон суга, бэлэг эрхтэн, шилбэ, шуу, сахлын үс, цэр, нус, шүлс, үрийн шингэн, үтрээний арчдас, цус зэргийг хамааруулан үзнэ. “Хурууны хээ” гэдэг нь тодорхой этгээдийн гар, хөлийн хуруу, алганы хээг хэлнэ. “Ул мөрний хэв” гэдэгт хэрэг учрал болсон газарт үлдсэн хүн ба амьтны ул мөр, тээврийн хэрэгсэл, техник, багаж зэвсгийн үйлчлэлээр бий болсон мөр, ором, дардас,хээ зэргийг хамааруулна. ЭБШХуулийн 155,156,157,160-р зүйлүүдийг баримтална.

Хуулийн 172.3.6-д “иргэн, албан тушаалтнаас тайлбар авах, шаардлагатай тохиолдолд шинжээч томилж, дүгнэлт гаргуулах”-аар заасан бөгөд тайлбарыг амаар болон бичгээр гаргуулж болно. Амаар тайлбар гаргуулж байгаа бол тэмдэглэл хөтлөн бэхжүүлэн авах бөгөөд тайлбар гаргаж байгаа иргэн, албан тушаалтны хаяг, гарын үсэг заавал байх шаардлагатай. Тайлбарыг хэргийн материалд хавсаргана. Шинжээч томилох асуудлыг ЭБШХуулийн 155-160-р зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.

Эрүүлийн байцаагч шийтгэх хуулийн 172.3.7-д “нутаг дэвсгэр, орон байранд нэвтрэн орох, гарахад хяналт тогтоох”-оор заасан байна. “орон байр” гэдэгт нийтийн болон хувийн орон сууц, хашаа байшин, гэр, амбаар, сав, агуулах,гарааш, бие засах газар, малын хашаа саравч, урц, овоохой, пүнз, майхан, тэрэгт сууц, дотуур байр, зочид буудал, амралт сувиллын тодорхой өрөө тасалгааг хамааруулан ойлгож болно.

Мөн хуулийн 172.3.8-р зүйлд“ гэмт хэргийг таслан зогсоох, гэмт этгээдийг мөрдөх үед байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох” эрхтэй болох тухай заажээ. Энэ нь гэмт хэргийг халуун мөрөөр нь хөөж илрүүлэх, оргосон этгээдийг шуурхай эрэн сурвалжлах, гүйцэтгэх ажил зохион байгуулах үедбайгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох эрх олгосон байна.

Хуулийн 172.3.9-р зүйлд“ согтууруулах ундаа, мансууруулах, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах” тухай заасан байна. “Согтууруулах ундаа” гэдэгт хүнсний зориулалтын түүхий эдээр үйлдвэрлэсэн спирт, бүх төрлийн архи, 2 хувиас дээш этилийн спирт агуулсан дарс, пиво, сүүн төрлийн архи зэрэг хамаарна. “Мансууруулах бодис” гэдэг нь хүний уураг тархи, төв мэдрэлийн системд нөлөөлж сэтгэцийн өвчин үүсгэх чадвартай эм, бодис, бэлдмэлийг хэлнэ. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай 1961 оны конвенц бий. Хүний эрүүл мэндийг сарниулах, хордлогод оруулах, үхэлд хүргэх бодисуудыг “хордуулах бодис” гэнэ. Практикт согтуурлын зэргийг тодорхойлохын тулд драггер үлээлгэх аргыг ашигладаг. Шаардлагатай үед мэргэжилтний туслалцаатайгаар цусны шинжилгээ авч согтуурлынзэргийг тогтоож болно. Мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг

шалгахдаа дээр дурдсан аргуудыг ашиглахаас гадна тухайн хүний нүдний хүүхэн хараа томорсон эсэх, сэтгэцийн ямар байдалд байгаа \мансууууруулах бодис хэрэглэсэн үедээ хүн хэт хөөрлийн байдалд буюу сэтгэл санааны уналтанд орсон байдаг\, хөдөлгөөний хэмнэл алдагдсан эсэхийг ажиглах, биед үзлэг хийж 2 гарын шуу орчимд тариурын мөр байгааг илрүүлэх буюу хувцас, ачаа тээшинд үзлэг хийж мансууруулах бодис, тариур, эм бэлдмэл, ургамал байгаа эсэхийг шалгахаас гадна тусгайлан сургасан нохой ашиглаж болно.

Манай улсад хорих байгууллагад хэрэг бүртгэх эрх олгоогүй учир ажилтнууд, оюутнууд гэмт хэрэг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах арга тактикийн тухай мэдлэг тун хомс байна. Гэтэл ОХУ-н ЭБШХуулийн 2-р бүлгийн 8-р хэсгийн 21-р зүйлийн 150-3-4-т “ШШГБайгууллага хэрэг бүртгэлт явуулах эрхтэй” гэж \ОХУ-д хорих байгууллага шийдвэр гүйцэтгэх байгууллага тус тусдаа бие даасан агентлаг болж ажилладаг\, 157-5-д “Хорих ангийн дарга нар тухайн хорих ангийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэгт мөрдөн байцаалтын хойшлуулшгүй ажиллагаа явуулна”. “Эрүүгийн хэрэг үүсгэснээс хойш 10 хоногийн дотор хойшлуулшгүй ажиллагааг гүйцэтгэнэ”, 144-р зүйлд “гэмт хэргийн тухай мэдээллийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.Гомдол мэдээллийг шалгах явцад дараах ажиллагааг гүйцэтгэж болно. Үүнд:

-иргэний бичиг баримт, эд зүйл шалгах

-аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эд зүйл, хөрөнгө, мөнгө агуулсан байр савыг битүүмжлэх

-шүүхийн шинжилгээ хийлгэх, шинжээчийн дүгнэлт гаргуулах

-тайлбар гаргуулан авах

-шүүх эмнэлэг, криминалистикийн болон бусад шинжилгээнд зориулж дээж, хурууныхээ, ул мөрний хэв авах

-хэрэг та ч холбогдол бүхий тээврийн хэрэгслийг саатуулах, эд зүйл, мөнгийг түр хугацаагаар хураож авах

-хэргийн газар, бичиг баримт, магадлагаа, эд зүйл, цогцост үзлэг хийх

-дээрхи үйл ажиллагаанд мэргэжилтнүүдийг оролцуулах

-хэрэг бүртгэх байгууллагад гүйцэтгэх ажил зохион байгуулах даалгавар өгөх” гэжээ.

ЭБШХуулийн 172-р зүйлийн 3,4 дэх хэсэг буюу “хойшлуулшгүй ажиллагаа явуулах” тухай ойлголтыг өөртөө агуулсан “эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл” гэсэн долдугаар хэсэг нь байцаан шийтгэх ажиллагааг эхлэн явуулах хууль ёсны үндэслэлийг хангалттай тогтоох зорилготой процессийн бие даасан шат юм. Хууль сахиулах байгууллагын ажилтнуудад эрүүгийн хэрэг үүсгэх шатанд \гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг хянан үзэх, хойшлуулшгүй ажиллагаа явуулах үед\ процессын ажиллагаа хийж болохгүй гэсэн ойлголт нилээд байдаг. Судалгаанаас үзэхэд хэрэг бүртгэгч мөрдөн байцаагч нарын 45-60 хувь нь эрүүгийн хэрэг үүсгэх шатанд\ гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг шалгах явцад\ процессийн ажиллагаа явуулж болохгүй гэж үзэж байжээ. Гэтэл ОХУ-н ЭБШХуульд энэ нь мөрдөн байцаах ажиллагааны нэгэн хэсэг гэж үзэж зохих хууль журмын дагуу хэрэгжүүлдэг байна. Энэ ойлголтыг залруулан хууль зүйн доктор,

Ж.Болдбаатар: “Эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагааны эрүүгийн

Хэрэг үүсгэх үндэслэл бий болоход эхлэн, энэ талаар гарсан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болоход дуусна”, хууль зүйн доктор Б.Бат-Эрдэнэ “...эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагааны эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа шинээр бий болох хууль зүйн факт болдог” гэж тус тус тодорхойлжээ.

Санал:

1. ХСИС-н ШШГС-д суралцаж буй сонсогч нарт ЭБШЭЗ, гэмт хэргийн нотолгооны онол, криминалистик шинжилгээ, кримининалистикийн тактик, шүүх эмнэлэг, шүүх ня-бо, шүүх сэтгэц гэм судлал,хууль зүйн сэтгэл судлал, галын бэлтгэл, самбозэрэг хичээлүүдийн цагийг нэмэгдүүлэх, сонгон судлуулах
2. Дээрхи сонсогч нарын уртын дадлагыг цагдаагийн байгууллагад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар хийлгэн дээрхи хичээлүүдээр олж авсан мэдлэгийг практик дээр гүнзгийрүүлэн бататгах боломж олгох
3. ХСИС-н шийдвэр гүйцэтгэлийн судлалын төвийн үйл ажиллагааг өргөтгөх
4. Гэмт орчин судлал буюу “хорих газар” , “ялтан” судлалыг бий болгох
5. Хорих байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэх онолыг заахын зэрэгцээ хорих байгууллагын ажилтны ур чадварыг нэмэгдүүлэхийн тулд ажил үүрэг гүйцэтгэх аргуудад сургах, тусгай хичээл, гарын авлага, үзүүлэн таниулах материал бэлтгэх, дадлага, сургалт зохион байгуулах буюу онол практикийг хослуулах. Жишээ нь дээр дурдагдсан”хойшлуулшгүй ажиллагаа явуулах” тухай асуудал юм. Мөн хорих ангид хэрэг учрал үйлдэгдсэн тохиолдолд хэрхэн ажиллах, гэмт хэргийн газрыг хамгаалах, гэмт хэргийн ул мөрийг баллуулахгүй байхын тулд яаж ажиллах, ул мөрийг хэрхэн бэхжүүлэх, тухайн үйлдэл гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй эсэх, иргэд, албан хаагч, ялтнаас ирүүлсэн гомдол, мэдээлэл нь гэмт хэргийн шинж чанарыг зааж байгаа эсэх, алба хаагч, ялтнууд гэмт хэргийн хохирогч, гэрч болсон тохиолдолд яаж хамгаалалтад авах, ялтны бие, байр, эд зүйл, обьект, тээврийн хэрэгсэлд үзлэг нэгжлэг хийх аргачлал, бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх аргачлал, гяндан, цагдан хорих байранд ажиллах онцлог, чанга онцгой дэглэмийн хорих ангид ажиллах онцлог, байгалийн хүнд нөхцөлийг даван туулах арга, цэргийн байр зүйн мэдлэг, галт зэвсгээр хөдөлгөөнтэй үед буудлага үйлдэх, галт зэвсэг, хутга мэс бусад зүйлийг зэвсгийн чанартай ашиглан довтолсон үед биеэ хамгаалах,дохиолол хамгаалалтын инженер техникийн хэрэгслүүдийг ажиллуулах, ялтан бие хүний онцлог, сэтгэл зүйн бэлтгэл, ялтан хооронд болон албан хаагч ялтны хооронд үүссэн тааламжгүй харьцааг зохицуулах гэх мэт олон төрлийн практик арга ажиллагааг сонсогч нарт заан сургах шаардлагатай байгаа юм.



Д.БАТГЭРЭЛ

Хорих 401 дүгээр ангийн ерөнхий жижүүр, ахмад

ЯЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙГ ГАДААДЫН ЗАРИМ ОРОНД ЗОХИОН БАЙГУУЛЖ БУЙ ПРАКТИК

Ялтныг засан хүмүүжүүлэх тэднийг ял эдлээд гарсны дараах чөлөөт амьдралд бэлтгэхэд ялтны хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловрол олгох болон чөлөөт цагийг зохистой ашиглах зэрэг ажлыг зөв зохион байгуулах явдал чухал. Албан хүчээр бий болсон хэт их чөлөөт цагийг өнгөрөөх нь ялтнуудын хувьд болон ял эдлүүлэх байгууллагын хувьд маш хүнд асуудал юм. Ял эдлэх хугацаа ялтны цагийг үр ашигтай ашиглахад дараах гурван хүчин зүйл гол үүрэгтэй.

- Ялтны үр ашигтай хөдөлмөрөөр хангах
- Хорих байгууллагын дэргэд ерөнхий болон мэргэжлийн боловсрол олгох боломжийг бүрдүүлж, боловсрол олгохийг хүссэн ялтнуудыг сургах
- Чөлөөт цагийг үр ашигтай өнгөрөөх ажлыг зохион Ялтнуудын байгуулах олон нийт, шашин, урлагийн зэрэг үйл ажиллагаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэх зэрэг болно.

Эдгээрээс хамгийн гол нь ялтны хөдөлмөр эрхлэлт юм. Ялтны хөдөлмөр эрхлэлтийн талаар улс бүр ялгаатай ханддаг байна. Жишээлбэл: ОХУ нь Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх хуулиар бүх ялтан албадан хөдөлмөр хийх ёстой байдаг бол Европын орнууд АНУ, Япон зэрэг улсуудад хоригдлын хөдөлмөр бол албадан хөдөлмөр гэсэн логикоор ханддаг байна. Олон улсын эрх зүйн нормоор ялтны албадан хөдөлмөрийг тодорхой нөхцөлтэйгээр байж болохыг үгүйсгэдэггүй. Тухайлбал ялтны эрхлэх хөдөлмөр нь түүний мэргэжил чадварыг тоочсон байх ёстой. Хэрэв ингэх бололцоогүй бол уг хөдөлмөр нь ашигтай бөгөөд нийгмийн ач холбогдолтой байх ёстой гэх мэт төрөл бүрийн нөхцөл байна. Харин улсуудын хуулийн практикт бол ихээхэн ялгаатай байна. Зарим улсуудад албан хөдөлмөрийг хуулиараа зөвшөөрдөг бол зарим улсад тэдний хөдөлмөрийг хөдөлмөрийн эрх чөлөөний зарчимд нийцэх ёстой гэж үздэг. Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой эрүүгийн гэмт хэргийн шийтгэл нь албадан хөдөлмөрлүүлэх ба шоронд хориод албадан хөдөлмөр эрхлүүлэх гэж 2 хуваагдана. Мөн хөдөлмөр эрхлүүлэхээр эрүүгийн шийтгэл оноогоод шорон аюулгүй хөдөлмөрлөхөд ашиглах болон ялтныг ялын хугацаандаа ямарваа нэгэн зүйл эрхэлсэн байлгахын тулд хөдөлмөрлүүлэх / албадан хөдөлмөр биш / гэж ангилах ч бий. Энэ ангилалыг тодруулбал:

- Шоронгийн албадан хөдөлмөр. Энэ нь чөлөөт бус хөдөлмөрийн нэг хэлбэр бөгөөд шоронд хорих ял дээр нэмэлт шийтгэл маягаар эртнээс хэрэглэж ирсэн, одоо ч ОХУ гэх мэт зарим оронд хэрэглэсээр байгаа шийтгэл юм. Ийм хөдөлмөр нь тодорхой үр дүн бүхий үйлдвэрлэлийн Юуны өмнө ялтан үр ашигтай хөдөлмөр эрхэлж, тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалтай болох нь эргэн нийгэмшихэд нь чухал үүрэгтэй. Ялтан чөлөөлөгдсөнийхөө дараа ажил олоход нь тус болох чадвар эзэмших боломжтой.
- Мөн засан хүмүүжүүлэх маш чухал ач холбогдолтой. Шоронгийн ялтны амьдралын харгис хатуу нэгэн төрлийн уйтгартай байдлыг нь зөөллөнө. Ажил хөдөлмөр эрхлэн завгүй байснаар ялтан ямарваа нэгэн хүчирхийлэлийн юмуу нийгмийн эсрэг үйл ажиллагаанд татагдан орохгүй байх талтай. Суугаа амьдралаар

байнга байхгүй нь тэдний эрүүл мэндэд ч зохих нөлөөтэй.

1. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-д ялтны хөдөлмөр эрхлэх асуудлыг 1973 оны 11755 / 1987 онд 12608 дугаар хулийн дэд актаар нэмэлт оруулсан/ , 1994 оны 12943 дугаар хуулийн дэд актуудаар зохицуулсан байдаг. Эдгээр актанд "Ялтнуудын мэргэжлийн болон боловсролын чадварыг хөгжүүлэх нь тэдний засран хүмүүжих болон эргээд чөлөөт нийгэмд очиж амьдрахад нь зайлшгүй чухал шаардлагатай. Учир утгатай хөдөлмөр эрхлэлт тэдний эдгээр чадварыг хөгжүүлэх ач холбогдолтой. Гэхдээ хоригдлуудын хөдөлмөрийг мөлжих болон бараа таваар үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх зэрэгт хоригдлуудын хөдөлмөр ба чөлөөт хөдөлмөрийн хооронд эрүүл бус өрсөлдөөн үүсэхээс сэргийлэн болгоомжтойгоор зохион байгуулах ёстой" гэж заасан байна. Энэ хуулийн дэд актаар ажил олгогч доор дурьдсан этгээдүүдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулахыг хориглоогүй. Үүнд:

1. Хугацаанаас өмнө суллагдсан болон туршилтын хугацаанд байгаа этгээд
2. Өршөөгдсөн болон хугацаат ялаа эдлээд гарсан этгээд
3. Холбооны шоронд ял эдлэгч
4. Холбооны биш шоронд ял эдлэгч зэрэг хүмүүс цалин хөлстэй хөдөлмөр эрхлэхийг хуулийн дэд актанд заасан дор дурьдсан хууль эрхийн орчинд зөвшөөрнө. Үүнд:

a) Ажиллагч хөдөлмөрийн хөлс авдаг юмуу батлагдсан хөдөлмөрийн сургалтанд сайн дурын үндсэн дээр хамрагдах

b) Үйлдвэрчний төв байгууллагын тухайн нутаг дахь төлөөлөгч юмуу адил төстэй үйлдвэрчний байгууллагатай зөвшилцсөн

c) Хөдөлмөрийн хөлс төлөх ажил нь а. Хөлсний ажилчдыг өөр газар руу аваачихгүй байх, б. Тухайн нутагт илүүдэлтэй байгаа үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд оролцохгүй байх болон, в. Үйлчилгээний ажлын гэрээг дордуулахгүй байх.

d) Хөдөлмөрийн хөлс болон хөдөлмөрийн бусад нөхцөл нь тухайн орон нутаг дахь адил төстэй хөдөлмөрийнхөөс доошгүй байх.

e) Ажил эрхлэхтэй холбоотой хуулиуд болон бусад зохицуулах дүрэм журам нь 11755 дугаар хуулийн дэд акт ба түүнд оруулсан нэмэлтүүдийн шаардлагад нийцсэн байна гэдгийг АНУ-ын Ерөнхий прокурор батласан байх.

Federal Prison Industries, Inc., буюу UNICOR нэрээр нийтэд танигдсан байгууллага нь 1934 онд холбогдох хууль тогтоомж болон Executive Order-ийн дагуу байгууллагдсан төрийн өмчит корпораци бөгөөд Холбооны шоронгийн товчооны ялтнуудын хөдөлмөрийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг юм. Executive order гэдэг нь АНУ-ын ерөнхийлөгч холбооны гүйцэтгэх засгийн тэргүүний хувьд гаргадаг зарлиг юм. Executive order нь гүйцэтгэх засгийн албан хаагчдын хэрэгжүүлэн ажиллах журмыг тогтоох бөгөөд иргэдэд ямар нэг үүрэг оноохгүй. АНУ-ын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн хэсэгт Төлөөлөгчдийн танхим ба сенатаас бүрдэх Нэгдсэн улсын Конгресс энд тогтоосон хууль тогтоох бүрэн эрхийг эдэлнэ" гэж заасан байдаг. Конгрессоос гаргасан хуулийн актаар ерөнхийлөгчид шилжүүлсэн бүрэн эрхийн хүрээнд тодорхой хуулийг хэрэгжүүлэхийн тулд гаргасан Executive order нь хуулийн бүрэн чадамжтай байна.

Уг корпорацийн гол зорилго нь ялтнуудад ажил олгох, мэргэжлийн дадлага олгон бэлтгэх, ялтнуудыг ажилтай байлгаснаар засан хүмүүжүүлэх байгууллагуудын аюулгүй байдлыг хангах, зах зээлийн үнээр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бие даан ажиллах юм. UNICOR нь ялтныг хөдөлмөр хийлгэхээр албадаж болохгүй бөгөөд хөдөлмөр эрхлэх эсэх нь зөвхөн сайн дурын үндсэн дээр байна. Мэргэжлийн бэлтгэл хийлгэхэд ч мөн адил.

Ажлын сайн чадвар эзэмшсэн, сайн ажилласан ялтанд шоронгоос гарахад нь UNICOR –ийн зүгээс дэмжлэг үзүүлдэг. UNICOR нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ зөвхөн холбооны засгийн газрын байгууллагуудад зарах бөгөөд шууд зах зээлд гарах эрхгүй. UNICOR нь холбооны шоронгуудад 109 үйлдвэртэй, 175 орчим бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг байсан байна. UNICOR нь эдийн засгийн хувьд бүрэн бие даасан байгууллага бөгөөд улсаас ямар нэгэн санхүүжилт авдаггүй. Ялтнуудын хөдөлмөрөөр бүтсэн бүтээгдэхүүнийг Холбооны засгийн газрын байгууллагууд худалдан авахдаа Холбооны худалдан авалтыг зохицуулах системийн журмыг баримтлана.

2. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС.

Ялтныг хөдөлмөр эрхлүүлэх асуудлыг Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Тахир дутуу хүний нийгэм хамгааллын тухай хуулиар тус тус зохицуулдаг байна.

ОХУ-ын Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийн 14-р бүлэгт Хорих ял эдэлж буй ялтнуудыг хөдөлмөр, мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтанд хамруулах талаар зохицуулалтуудыг заасан байна.

103 дугаар зүйл. Ялтныг хөдөлмөр эрхлүүлэх

1. Бүх ялтнууд хоригдож байх хугацаандаа засан хүмүүжүүлэх байгууллагын захиргаанаас тодорхойлсон ажлын байранд хөдөлмөр эрхлэх үүрэгтэй. Засан хүмүүжүүлэх байгууллагын захиргаа нь ялтнуудын нас хүйс, хөдөлмөр эрхлэх чадвар, эрүүл мэндийн байдал, ажлын байрнаас хамаарч тэднийг хөдөлмөр эрхлүүлэх үүрэгтэй.
2. 60-аас дээш насны эрэгтэй, 55-аас дээш насны эмэгтэй мөн тахир дутуугийн 1,2 дугаар групптэй ядтнуудыг өөрсдийнх нь хүсэлтээр холбогдох хууль тогтоомжийн дагуу хөдөлмөр эрхлүүлнэ. / Хөдөлмөрийн хууль, Тахир дутуу хүний нийгэм хамгааллын тухай /

Насанд хүрээгүй ялтнуудыг мөн ОХУ-ын хөдөлмөриын хуульд заасны дагуу хөдөлмөр эрхлүүлнэ.

3. Шоронд хорих ял эдэлж буй ялтнуудыг энэ хуулийн 74-р зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу шоронгийн газар нутаг дээр хөдөлмөрлүүлнэ.
4. Хоригдлуудын ажиллахыг хориглох ажлын жагсаалтыг засан хүмүүжүүлэх байгууллагын дотоод журмаар тогтооно.
5. Хоригдлуудын хөдөлмөрлөх цаг нь засан хүмүүжүүлэх байгууллагын үндсэн зорилт болох засан хүмүүжүүлэх үйл ажиллагаатай давхцаж болохгүй.
6. Ажлаас татгалзах, эсвэл ажлыг зогсоовол тогтоосон журмыг санаатай зөрчсөн гэж үзэж шийтгэлийн арга хэмжээ, хариуцлага хүлээлгэнэ.

104 дүгээр зүйл Ялтнуудын хөдөлмөрийн нөхцөл

1. Ялтны ажиллах хугацаанд хөдөлмөр хамгааллын, техникийн аюулгүй байдал болон ариун цвэрт холбогдох дүрмийг ОХУ-ын хөдөлмөрийн тухай хууль тогтоомжинд нийцүүлэн тогтооно. Ажлын эхлэх болон дуусах цаг нь ээлжийн графикаар тодорхойлогдоно.
2. Засан хүмүүжүүлэх болон шоронд ял эдэлж буй хоригдлуудын гүйцэтгэж байгаа ажлууд нь ажлын цагийг уртгасан хэлбэрт ордог. / Өдөр болгон тогтмол цагаар ажилладаггүй. Нэг өнжөөд 24 цаг цаг ч юм уу ажилладаг гэсэн утгатай/
3. Ялтнуудын цалинтай ажил хийлгэхэд цаг нь нийт ажлын цагаар тооцогдоно. Засан хүмүүжүүлэх байрны захиргаа нь ажлын цагийг тооцож гаргана. Хэрэв ажил гүйцэтгэхээс байнга зайлсхийвэл, засан хүмүүжүүлэх байгууллагын захиргааны шийдвэрээр ялтны нийт ажлын цагаас хасна. Засан хүмүүжүүлэх байгууллагын шийдвэр нь шүүхэд гомдол болон очиж болно.

4. Ажил хийдэг хоригдлууд жил бүр төлбөртэй амралт авна. Хүмүүжүүлэх колонид хорих ял эдэлж буй ялтан ажлын 18 өдөр, засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож буй ялтан 12 ажлын өдрийн амралт / төлбөртэй / авах эрхтэй.

108 дугаар зүйл

1. Мэргэжилгүй ялтнуудад анхан шатны мэргэжлийн боловсрол, мэргэжлийн бэлтгэл олгох ажлыг засан хүмүүжүүлэх газар зохион байгуулна. Мэргэжил эзэмшсэн ялтнууд засан хүмүүжүүлэх байранд болон суллагдсаныхаа дараа ч тэндээ ажиллаж болно.

2. Тахир дутуугийн 1, 2 дугаар группт байдаг ялтнууд 60-аас дээш насны эрэгтэй мөн 55-аас дээш насны эмэгтэй ялтнуудыг өөрсдийнх нь хүсэлтээр холбогдох мэргэжлийн сургалтанд хамрагдуулж болно.

3. Ялтнуудыг анхан шатны мэргэжлийн боловролын сургалтанд хамруулахдаа тэдний хүмүүжиж буй зэргийг харгалзан үзнэ.

4. Анхан шатны мэргэжлийн боловсрол олгох мэргэжлийн сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас тогтоосон журмын дагуу явуулна. Засан хүмүүжүүлэх байгууллага нь ялтнуудын дээд мэргэжлийн боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

5. Бүх насаараа хоригдож буй ялтнууд шууд үйлдвэр дээр мэргэжил эзэмшинэ.

3. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

БНСУ –ын хорихын байгууллагуудыг Хууль зүйн яам мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилладаг. БНСУ-ын Эрүүгийн хуулийн 3-р бүлэгт ял шийтгэлийн талаар хуульчилсан байдаг. Хуулийн 41-р зүйлд дараах ял шийтгэлийн төрлүүдийг хуульчилсан байна. Үүнд:

1. Цаазаар авах
2. Хорих
3. Ажил хөдөлмөр хийлгэхгүйгээр хорих
4. Зэрэг дэв хасах
5. Мэргэжлийн зэрэг хасах
6. Торгууль
7. Албадан саатуулах буюу баривчлах
8. Бага хэмжээний торгууль ногдуулах
9. Анз төлөх

Хорих болон ажил хөдөлмөр хийлгэхгүйгээр хорих, бүх насаар нь хорих, тодорхой хугацаагаар хорих зэрэг ял нь 1 жилээс 30 хүртэл байдаг. БНСУ –ын ялтны эрх зүйн байдал болон хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг эрүүгийн хууль болон шүүхийн шийдвэр үйцэтгэх тухай хуулиараа нарийвчлан зохицуулсан байдаг. Ерөнхийдөө хорих байгууллага болон хоригдлуудын эрх зүйн байдлыг дараахь хууль тогтоомжуудаар зохицуулдаг. Үүнд:

1. Хууль зүйн яамны тухай хууль
2. Цагдаагийн байгууллагын тухай хууль
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль
4. Ялын гүйцэтгэл болонялтны эрх зүйн байдлын хууль
5. Хорих байгууламжийн тухай журам
6. Харгалзагчийн үзлэг шалгалт хийх журам
7. Ялын гүйцэтгэл болон ялтны эрх зүйн байдлын хуулийг хүчин төгөлдөр болгох зарлиг
8. Ялын гүйцэтгэл болон ялтны эрх зүйн байдлын хуулийг хэрэглэх журам /2010-05-31/

Ялын гүйцэтгэл болон ялтны эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлд *ялтан гэж* "хорих, цагдан хорих болон ажил хөдөлмөр хийлгэхгүйгээр хорих, урьдчилан хорин шүүхийн шийдвэр авсан тэрхүү ял нь батлагдсан хүн болон мөнгөн торгуулиа төлж дуусаагүй ажлын байранд ажиллах шийдвэр хүлээн авсан этгээдийг хэлнэ" гэж тодорхойлсон байна.

Шүүгдэж буй этгээд гэж гэмт хэрэгт сэжиглэгдсэн болон шүүгдэгчээр

баривчлагдсан эсвэл цагдан хорих шүүхийн шийдвэр хүлээн авсан этгээдтйг хэлнэ гэжээ.

Тус хуулийн 2 дугаар бүлгийн 11 дүгээр зүйлд зааснаар ялтнуудыг дараах төрлийн хорих байгууламид хорих ял эдлүүлнэ.

1. 19-с дээш насны ялтан: Шорон
2. 19 нас хүрээгүй ялтан: Хүүхдийн хорих
3. Шийдэгдээгүй хоригдол: Саатуулах төв
4. Цаазаар авах ял авсан этгээд: Шорон болон саатуулах төвд

Энэ тохиолдолд тодорхой ангиллын стандартыг хууль зүйн яамны дүрэм,журмаар зохицуулна.

Ялтны хөдөлмөр эрхлэлт

Ялын гүйцэтгэл болон ялтны эрх зүйн байдлын хуулийн 4-р бүлэгт ялтны хөдөлмөр эрхлэлтийн талаар зохицуулсан байдаг. Ялтанд ногдуулах ажил нь эрүүл чийрэг амьдралд эргэж очиход туслах зорилгоор ур чадварыг сайжруулах,ажиллах хүсэл сонирхлыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна. Хорихын дарга ялтанд хийх ажлыг оноохдоо нас,ялын хугацаа,эрүүл мэндийн байдал,ур чадвар,зан ааш,сонирхол,ажил байдлын намтар, ирээдүйн амжиргаа болон ялтны нөхцөл байдлыг харгалзан үзэх ёстой.Ялтан нь өөрт ногдох ажил үүргийг гүйцэтгэх үүрэгтэй. Хорихын дарга нь ажил хөдөлмөр хийлгэхгүйгээр хорихболон урьдчилан хорих шүүхийн шийдвэртэй этгээдэд өргөдөлд заасан ажлыг ногдуулж болно.Хорихын дарга нь ялтны эрүүл амьдралд эргэж орход ур чадвараа сайжруулахыг хөхүүлэн дэмжих зорилгоор шаардлагтай гэвэл гадны үйлдвэрт ажилуулах эсвэл хорих байгууламжийн дотор зохион байгуулж гадны үйлдвэрийн ажлыг хийж болно.Энэхүү гадны үйлдвэрийг сонгон авах стандартад холбогдох шаардлагтай зүйлийг хууль зүйн яам шийдвэрлэнэ.Мөн хорихын дарга ялтны ур чадварыг сайжруулах ,дээшлүүлэх үүднээс хөдөлмөрийн мэргэжлийн сургуулийг байгуулж болно.Хорихын дарга ялтны мэргэжлийн сургуульд шаардлагтай гэж үзвэл гадны байгууллага, үйлдвэрт мэргэжлийн сургалтыг хийлгэж болно. Мэргэжлийн сургуульд холбогдох шаардлагтай зүйлийг хууль зүйн яам шийдвэрлэнэ.Ялтан нь амралтын өдөр болон олон нийтийн амралтын өдөр ажиллахгүй. Ялтныг дараах тохиолдолд ажлаас чөлөөлнө.

- Гэр бүлийн болон хань ижлийн хамаатан, ойр дотны хүн нас барвал 2 хоног
- Аав ээж болон хань ижлийн нас барсан өдөр 1 өдөр /Хэрэв ялтан ажлаа хийхийг хүсвэл ажллуулж болно./
- Гэмтэл бэртэл, өвчин, ажлаа хийхэд саад болхуйц нөхцөл байдал үүсвэл түүнийг арилгах хүртэл ажлаас чөлөөлж болно.

Ялтны хийсэн ажлын хөдөлмөрийн хөлс нь улсад орно. Хорихын дарга ялтны ажиллах хүсэл сонирхлыг хөгжүүлэх, эрүүл амьдралд эргүүлэн оруулах зорилгоор хууль зүйн яамны сайдын тогтоосны дагуу ажлыг дуусгах, ажлын үр дүн, хүмүүжлийн үзүүлэлт болон бусад нөхцөл байдлыг харгалзан ялтанд ажлын шагнал урамшуулалыг олгож болно.

Ажлын шагнал урамшууллыг суллахад нь өгч болно. Ялтан өөрөө гэр бүлийн амьдралаа тусламж дэмжих, соён гэгээрэх эрүүл амьдралд эргэн орох зорилгоор шаардлагатай гэвэл суллахын өмнө бүгдийг болон зарим хэсгийг авч болно. Хэрэв ялтан нь ажлын байр мэргэжлийн сургалтын явцад түүний улмаас нас барвал ялтны хөдөлмөрийн шагнал ура мшууллаар авсан мөнгийг өв залгамжлагчид нь өгнө.

Судалгаанаас дүгнэж үзэхэд судалж үзсэн гадаадын улсуудад :

- Хорих байгууллагаас гадуур хөдөлмөр эрхлэх
- Хорих байгууллага дотор буюу суллагдахаас өмнө хөдөлмөр эрхлэх
- Гэрээгээр хөдөлмөр эрхлэх гэх мэтчилэн тусгаж өгсөн нь ажил хийлгэх, хөдөлмөр эрхлэх, эргэн

нийгэмших эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.

Мөн эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх, хорих ял эдлүүлэх байгууллагын тухай хууль тогтоомжид өөрчлөлт хийх, хоригдлын ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай баримт бичиг гаргах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд ялтны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажиллах боломж нөхцлийг бий болгох, хөдөлмөрийн үр нөлөөгөөр хүмүүжлийн түвшинг дээшлүүлэх нь ялтны дундаас гарах зөрчил, гэмт хэргийг бууруулах, тэднийг нийгэмд эргэж ороход бэлтгэх, амьдрах зөв арга барилд сургах, ухамсрыг нь өөрчлөхөд чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болох нь гадаадын аль ч улс орны эрх зүйн зохицуулалтаас харагдаж байна.



С.БАЯСГАЛАН

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын ерөнхий жижүүр, ахмад

ХОРИХ АНГИЙН ХАРУУЛ ХАМГААЛАЛТ, ЭЭЛЖИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Монгол Улс нийгмийн хөгжлийн замаар төрт ёс хууль цаазаа хөгжүүлэн бэхжүүлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгож, ардчилсан Үндсэн хуулиа тунхагласан тэр цагаас хойш хүний амьдралын бүхэл бүтэн нэгэн мөчлөг улиран өнгөрч, ард түмний маань амьдралын хэвшил, оюун сэтгэлгээнд агуулга чанарын мэдэгдэхүйц өөрчлөлт гарсаар байна. Үүнтэй уялдан хорих ангийн үүрэг зорилгод ч мөн адил чанарын өөрчлөлт гарч эхлэж байна.

Хорих байгууллагын нэг онцлог нь ял шийтгэлийг тодорхой хугацаанд хуулиар тогтоосон тусгай дэглэмтэй хорих анги, гянданд төрийн албадлагаар олон нийтээс тусгаарлан шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялын хугацааг дуусгах хүртэл тодорхой хугацаанд ялтан бүрийг тогтоосон дэглэмд хууль ёсыг хүндэтгэн сахидаг үнэнч шударга иргэн болгон төлөвшүүлэх зорилгыг агуулж байдаг.[13]

Хорих анги бол хүн амьдардаг газар тул тэнд тайван амьдрах орчныг бүрдүүлж болох хэдий ч ингэхийн төлөө харуул

[13] Ю. Сэрсэнжав"Засан хүмүүжүүлэхүй" УБ. 2001 5 дахь тал.

нийгэмших эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.

Мөн эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх, хорих ял эдлүүлэх байгууллагын тухай хууль тогтоомжид өөрчлөлт хийх, хоригдлын ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай баримт бичиг гаргах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд ялтны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажиллах боломж нөхцлийг бий болгох, хөдөлмөрийн үр нөлөөгөөр хүмүүжлийн түвшинг дээшлүүлэх нь ялтны дундаас гарах зөрчил, гэмт хэргийг бууруулах, тэднийг нийгэмд эргэж ороход бэлтгэх, амьдрах зөв арга барилд сургах, ухамсрыг нь өөрчлөхөд чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болох нь гадаадын аль ч улс орны эрх зүйн зохицуулалтаас харагдаж байна.



С.БАЯСГАЛАН

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын ерөнхий жижүүр, ахмад

ХОРИХ АНГИЙН ХАРУУЛ ХАМГААЛАЛТ, ЭЭЛЖИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Монгол Улс нийгмийн хөгжлийн замаар төрт ёс хууль цаазаа хөгжүүлэн бэхжүүлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгож, ардчилсан Үндсэн хуулиа тунхагласан тэр цагаас хойш хүний амьдралын бүхэл бүтэн нэгэн мөчлөг улиран өнгөрч, ард түмний маань амьдралын хэвшил, оюун сэтгэлгээнд агуулга чанарын мэдэгдэхүйц өөрчлөлт гарсаар байна. Үүнтэй уялдан хорих ангийн үүрэг зорилгод ч мөн адил чанарын өөрчлөлт гарч эхлэж байна.

Хорих байгууллагын нэг онцлог нь ял шийтгэлийг тодорхой хугацаанд хуулиар тогтоосон тусгай дэглэмтэй хорих анги, гянданд төрийн албадлагаар олон нийтээс тусгаарлан шүүхийн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялын хугацааг дуусгах хүртэл тодорхой хугацаанд ялтан бүрийг тогтоосон дэглэмд хууль ёсыг хүндэтгэн сахидаг үнэнч шударга иргэн болгон төлөвшүүлэх зорилгыг агуулж байдаг.[13]

Хорих анги бол хүн амьдардаг газар тул тэнд тайван амьдрах орчныг бүрдүүлж болох хэдий ч ингэхийн төлөө харуул

[13] Ю. Сэрсэнжав"Засан хүмүүжүүлэхүй" УБ. 2001 5 дахь тал.

хамгаалалт, дэг журмыг алдагдуулж болохгүй билээ.

Хорих байгууллагын ажилтан, ялтан хоёрын хоорондын эерэг харилцаа нь харуул хамгаалтанд сайнаар нөлөөлдөг бөгөөд идэвхитэй, зөв дэглэм хорих ангид дэглэм журмыг сахиулахад чухал хэрэгсэл болдог. Хорих ангийн ажилтан, ялангуяа харуул хамгаалалтын ээлжийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэж буй офицер, ахлагч нар таагүй харилцаа, зөрчлөөс зайлс хийх арга замыг ямагт эрэлхийлсээр ирсэн боловч хорих ангийн ажилтан, ялтан хоёрын хоорондын харилцааны явцад байнга илэрч байдаг зүйл юм. Гагцхүү гаргасан зөрчлийн шалтгаан нөхцлийг зөв тодоруулан гаргасан зөрчил тухайн нөхцөл байдалд нь тохирсон оновчтой арга хэмжээ авсаны үндсэн дээр гарах хор уршгийг багасган харин ч үр ашигтай хэлбэрээр шийдвэрлэх боломжтойг докторант Ю. Сэрсэнжав нэгэн илтгэлдээ дурдсан байна.[14] Хорих ангийн харуул хамгаалалтын ажилтан нь хуулийн хүрээнд өөрийн албан үүргийг зохих журмаар хүнлэгээр гүйцэтгэж байна гэдгээ үзүүлэх учиртай. Хэрэв тэгэж чадвал дийлэнх ялтан эерэгээр хүлээж авдаг билээ.[15]

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын гол үүргүүдийн нэг бол шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн ял шийтгэлийг нь зохих хууль журмын дагуу эдлүүлэх явдал юм. Энэ үүргийг хэрэгжүүлэн гүйцэтгэх гол хүч нь Тогтоол гүйцэтгэх газрын харуул хамгаалалтын албаныхан билээ. Шүүхийн шийдвэрийг ямар нэгэн хэмжээгээр хүлээн зөвшөөрдөггүй, зөвшөөрч байгаа хэдий ч ял шийтгэл эдлэхээс ямар ч аргаар хамаагүй зайлсхийх сиймхийг байнга хайж эрэлхийлж байдаг ялтнуудыг харгалзах нь амаргүй бөгөөд харицуцлагатай ажил юм. Иймд энэ албыг үүргээ гүнээ ухамсарласан, үнэнч шударга, хатуужил тэвчээртэй ажилтнууд л нэр төртэй хашиж чадна.[16] Өндөр хана хэрэм, өргөст торны цаана шүүх эрх мэдлийн байгууллагын нэрийн өмнөөс нэг хэсэг хүн ажиллаж, өөр нэг хэсэг хүний эрх чөлөөг хязгаарлаж байдаг. Хоёр дахь хэсгийн буюу ялтнуудын ихэнх нь хорих ангийг сиймхий гарч боломж олдох бүрийд орхих эрмэлзэлтэй байдаг бол эхний бүлэг хүмүүс буюу ээлжийн бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэдэг офицер, хянагч нар нь үүнээс урьдчилан сэргийлж хамгаалалтын хязгаарлалт тогтоож байдаг.[17] Харуул хамгаалалтын үзэл баримтлал нь ялтан оргон зайлахад бодитой саад учруулахаас ихийг агуулдаг билээ. Харуул хамгаалалт нь ялтнуудтай ажиллах хорих ангийн нийт бүрэлдэхүүн, тэр дундаа ээлжийн үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүн офицер болон хянагчийн мэдрэмж дээр тулгуурлах бөгөөд, үүрэг гүйцэтгэж буй ээлжийн бүрэлдэхүүнээс хорих ангид юу болж байгааг мэдэж болохын хамт ялтнуудыг зохих хэлбэрээр идэвхитэй ажиллуулж байх хэрэгтэй. Үүнийг ихэвчлэн хөдөлгөөнт хамгаалалт гэж нэрэлдэг тухай Хорих байгууллагын ажилтнуудад зориулсан хүний эрхийн сургалтын гарын авлагад тусгасан байна.[18] Гадна харуул хамгаалалтын хяналтын цамхаг дээр үүрэг гүйцэтгэж байгаа хянагч нь ялтны оргон зайлах оролдлогыг зөвхөн эхэлснийх нь дараа

[14] "Эрх зүй, албаны мэдээлэл" сэтгүүл. УБ. 1998. №2. 49 дэхь тал.
[15] "Хүний эрх ба хорих байгууллага" сэтгүүл. Женев. 2002. №9.52 дахь тал.
[16] "Эрх зүй, албаны мэдээлэл" сэтгүүл. УБ. 1998. №2. 50 дахь тал.
[17] "Хүний эрх ба хорих байгууллага" сэтгүүл. Женев. 2002. №9. 54 дэхь тал
[18] "Хүний эрх ба хорих байгууллага" сэтгүүл. Женев. 2002. №9. 51 дэхь тал

мэдэх боломжтой байдаг бол хамгаалалтын бүс дотор болон даалгавар гүйцэтгэгч хянагч нь ялтнуудын юу хийж байгаа мэддэг бөгөөд харуул хамгаалалтанд учирч болох аюулыг урьдчлан мэдэх илүү боломжтой байдаг.

Иймээс харуул хамгаалалтын ажилтнууд, нэн ялангуяа үүрэг гүйцэтгэж байгаа ээлжийн бие бүрэлдэхүүн харуул хамгаалалт гэдэг бол дан ганц хэрмэн хашаа, өргөст тор, автомажуулсан хяналтын хэрэгслэл биш гэдэг талаар мэдэрч бэлтгэгдсэн байх учиртай. Эдгээр нь харуул хамгаалалтын нэг биет зүйл юм. Тухайлбал хэрмэн хашаа, өргөст тор, хашлага саад, цоожтой хаалга юм. Өөр нэг элемент нь хөдөлгөөнт хамгаалалт гэж дүрсэлдэг ээлжийн бүрэлдэхүүний ажилтнуудаас ялтнуудын дунд холхих зэргээр танин мэдэж эрсдлийг үнэлэх явдал юм.

Харуул хамгаалалтын албаны ажил ямар хэмжээнд байгааг харуулах үндсэн үзүүлэлтийн нэг нь оргодлын асуудал юм. 1996-2000 он хүртлэх хугацаанд төвлөрсөн болон орон нутгийн нийт хорин найман хорих ангид давхардсан тоогоор 40205 хүнийг хорих ял эдлүүлсэн ба энэ хугацаанд байгууллагын хэмжээнд нийт 1508 оргосон нь нийт ялтны 3.5%-ийг эзлэж байсан. Тэдгээрийн 99.2%-ийг эрэн сурвалжилж баривчисан бол 2001-2005 он хүртлэх хугацаанд нийт 347 ялтан оргосноос 94.2% -ийг, 2006-2011 он хүртлэх хугацаанд нийт 24 ялтан оргосон нь сүүлийн 5 жилийн хугацаанд оргодлын тоо эрс буурсан үзүүлэлт гарсан нь нийгмийн амьдралын төлөвшилт болон шинэ эрүүгийн хуулиар оргох гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгасан, хорих ангийн албан хаагчдын ажилдаа хандах хандлага, ухамсар, хариуцлага өндөржсөн зэрэг олон нөхцөл байдлуудтай холбон тайлбарлаж болох юм.

Хорих ангиас оргох явдал нь манай нийгмийн хөгжлийн өмнөх үеүдэд байсан нь тодорхой бөгөөд, энэ гэмт хэрэг нь эрт цагаас хэлбэршлээ олж өөрийн түүхэн ул мөрөө үлдээсэн нийгмийн сөрөг үзэгдэл гэж үзэж болхоор байна. Энэ гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 261 дүгээр зүйлд хуульчилж өгсөн бөгөөд олон ноцтой уршгийг өөртөө агуулсан нийгмийн хор аюулаар бага бус гэмт хэрэг юм. Энэ гэмт хэргийг гарах шалтгаан нөхцлийг Тогтоол гүйцэтгэх газраас гаргасан судалгаанд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Бусад ялтнуудын ятгалгаар оргох 12%
2. Ялтнуудын дарамт шахалтнаас болж 18%
3. Хорих ангийн нөхцөл байдалд дасахгүй байгаагын улмаас 10%
4. Архи болон согтууруулах ундааны зүйл хэрэгэлэсний улмаас25%
5. Ар гэрт нь тохиолдсон таагүй байдлын улмаас /ойр дотны хүн хүндээр өвдсөн болон нас барсан, гэр бүлийн хүн нь салсан гэх мэт/ 24%
6. Бусад шалтгаанаар 11%

Дээрх шалтгаануудаас болж ялтнууд дараах байдлаар оргодог байна.

- Зоонны хашаа давах буюу ухаж гарах
- Гадуур заалтанд болон гэрээгээр аль нэгэн байгууллага, албан газар ажиллаж байгаад
- Хорих ангийн харуул хамгаалалтын сул байдлыг ашиглан оргох
- Ялтнууд албан хаагчийн итгэлийг ямар нэгэн байдлаар олж байгаад хяналт суларсан байдлыг ашиглан
- Эргэлтийн байрнаас эргэлтээр ирсэн ар гэрийнхэнтэйгээ хуйвалдаж
- Хорих ангийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаа,шийдвэрийн

улмаас гэх мэтийн байдлаас болж оргож байна.

Мөн Тогтоол гүйцэтгэх газрын хэмжээнд оршиж байгаа нэг дутагдал бол хорих ангийн албан хаагчид ялтанд тал засах, ялтны ар гэрийнхэнтэй хувийн харилцаа тогтоох, гаргасан зөрчлийг нь нуун дарагдуулах, хууль зөрчсөн гуйлт, шахалтаар ялтныг эмнэлэгт хэвтүүлж эмчлүүлэх нэрээр ял эдлэх нөхцлийг нь сайжруулах, шагналын хоног олгох, ялын тооцоог буруу хийж хугацаанаас өмнө суллах зэрэг хуулинд харшлах ноцтой дутагдал арилахгүй байна.[19] Хорих анги дахь хяналт, харуул хамгаалалтын ажилд ахиц амжилт гаргах нэг үндэс бол дотоодын хяналт шалгалт бөгөөд дотоодын хяналт шалгалтыг зөв зохистой үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай юм.

Цаашид хорих анги дахь хяналт харуул хамгаалалтыг боловсронгуй болгоход дараах хүчин зүйлүүдэд анхааралаа хандуулах нь зүйтэй байна.

1. Хорих ангийн харуул хамгаалалтын ажилтнуудыг аль болох ажлаас нь хөндийрүүлэхгүйгээр мэрэгжлийн чиг баримжааг нь дээшлүүлэх зорилгоор зохих сургалтыг үр дүнтэй явуулж байх ёстой. Ингэхдээ сургалтандаа шинээр гарсан хууль тогтоомж, сэтгэл судлал нэн ялангуяа ялтнуудын зүгээс бослого, үймээн самуун, хямралт байдал үүсэх үед хамгийн түрүүнд нүүр тулаж гардаж ажилладаг гэдэг үүднээс ээлжийн бүрэлдэхүүнд гардаг албан хаагчдад бие хамгаалах урлаг, бэртэж гэмтсэн өвчтөнд үзүүлэх анхан шатны сургалтыг түлхүү оруулах.
2. Хорих ангийн харуул хамгаалалтанд хэрэглэж байгаа холбоо дохиолол, техник хэрэгслэлийг боловсронгуй болгох, шинээр нэвтэрч байгаа технилогийг амьдралд нэвтрүүлэх /энгэрийн камер, зоонд үүрэг гүйцэтгэж байгаа хянагч нарийн байршил тогтоох чип гэх мэт/ эвдрэл гэмтэл гарсан үед засах арга хэмжээг алгууралгүйгээр түргэн шуурхай авч хэрэгжүүлж байх.
3. Шинээр албан хаагчдыг ажилд авахдаа боловсрол, ар гэр, амьдралын нөхцөл байдал, ааш зан зэргийг судлаж байж авхад онцгой анхаарах шаардлагатай байна.
4. Хөгжиж буй орнуудын жишиг, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Ялтантай харьцах наад цахын жишиг дүрэм зэрэгт тулгуурлан тэдний оюун ухаан, сэтгэл зүйтэй ажиллахын чухлыг ээлжийн бие бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдад сайтар ойлгуулж ийм чадварыг тэдэнд эзэмшүүлэх, мөн эрэгтэйчүүдийн хорих ангид эмэгтэй хүн ажиллахад тухайн хорих ангийн уур амьсгал ихээхэн өөрчлөгддөг байна. Жишээлбэл: Ялтнуудын сэтгэл санаа тайван байж, бие биетэйгээ зөв боловсон харьцаж, хувцас хунараа цэвэрхэн өмсөж өөртөө тавих анхаарал нь нэмэгддэг гэсэн судалгаа гарчээ. Иймээс эмэгтэй албан хаагчид хорих ангийн орчныг бүрэн өөрчилж чаддаг байна. Манай орны хорих ангиудын харуул хамгаалалтын ажилтнуудын нийгмийн асуудал болон амь нас, эрүүл мэнд, нэр төрийг хамгаалах асуудалд онцгой анхаарах нь чухал юм. Сүүлийн жилүүдэд төрийн болон төрийн бус байгууллагууд ялтны эрх ашиг, ахуй нөхцлийг сайжруулах талд ихээхэн анхаарал тавьж байгаа нь саашаалтай хэдий боловч юуны түрүүнд Тогтоол гүйцэтгэх газрын харуул

[19] "Эрх зүй, албаны мэдээлэл" сэтгүүл. 2011. №1. 24 дэхь тал

хамгаалалтын ажилтнууд үүний дотроос хоногийн 24 цагын турш ялтнуудтай харьцаж байдаг ээлжийн бүрэлдэхүүний албан хаагчдын амь нас, эрүүл мэнд, нэр төр, эрх ашгийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ дутмаг байгаа зэргийг чухалчлан үзэж холбогдох арга хэмжээ авах шаардлагатай байна.



Т.ЕРКЕБУЛАН

Баян-Өлгий аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны ээлжийн дарга, ахлах дэслэгч

ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХЭД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ

Хүний эрх гэдэг бол хүнээс салшгүй бөгөөд түүний амьдралын зайлшгүй шаардлагатай арга, нөхцөл болдог, хувь хүн нийгэм, төр, бусад бодгалиуд хоорондын харилцаа хийгээд түүний эрх чөлөөг илэрхийлдэг оршихуйн хэм хэмжээгээр байгуулагдсан (бүтээгдсэн) хувь хүний тодорхой чанар, онцлог мөн. Хүний эрх нь бодгалиудын оршихуйн арга, түүний нийгмийн үйл ажиллагаа, нийгмийн харилцаатай амьд барилдаатай сүлжилдсэн байдаг.

Хүний эрх гэдэг нь хүнээс салшгүй байдаг чанар. Хүнээс жам ёсны, төрөлхийн эрх болох амьд явах, халдашгүй дархан байх, өөрийн амьдрах аргаа чөлөөтэй сонгох эрх, шүтэж бишрэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө, хувийн амьдралын бие даасан байдал болон бусад эрхийг хэн ч хасах эрхгүй бөгөөд төр тэдгээрийг дуугуй хүлээн зөвшөөрч зохих ёсоор хангах, хамгаалах үүрэгтэй. Орчин үеийн нийгмийг эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны зарчим дээр үндэслэсэн хүний эрхгүйгээр төсөөлөх боломжгүй юм.

Нэгэнт хүн бүр эрх зүйн этгээд байхын дээр Монгол улсын төртэй харилцан эрх эдэлж, үүрэг хүлээх байдлаар эрх зүйн

хамгаалалтын ажилтнууд үүний дотроос хоногийн 24 цагын турш ялтнуудтай харьцаж байдаг ээлжийн бүрэлдэхүүний албан хаагчдын амь нас, эрүүл мэнд, нэр төр, эрх ашгийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ дутмаг байгаа зэргийг чухалчлан үзэж холбогдох арга хэмжээ авах шаардлагатай байна.



Т.ЕРКЕБУЛАН

Баян-Өлгий аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны ээлжийн дарга, ахлах дэслэгч

ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЛЭХЭД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ

Хүний эрх гэдэг бол хүнээс салшгүй бөгөөд түүний амьдралын зайлшгүй шаардлагатай арга, нөхцөл болдог, хувь хүн нийгэм, төр, бусад бодгалиуд хоорондын харилцаа хийгээд түүний эрх чөлөөг илэрхийлдэг оршихуйн хэм хэмжээгээр байгуулагдсан (бүтээгдсэн) хувь хүний тодорхой чанар, онцлог мөн. Хүний эрх нь бодгалиудын оршихуйн арга, түүний нийгмийн үйл ажиллагаа, нийгмийн харилцаатай амьд барилдаатай сүлжилдсэн байдаг.

Хүний эрх гэдэг нь хүнээс салшгүй байдаг чанар. Хүнээс жам ёсны, төрөлхийн эрх болох амьд явах, халдашгүй дархан байх, өөрийн амьдрах аргаа чөлөөтэй сонгох эрх, шүтэж бишрэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө, хувийн амьдралын бие даасан байдал болон бусад эрхийг хэн ч хасах эрхгүй бөгөөд төр тэдгээрийг дуугуй хүлээн зөвшөөрч зохих ёсоор хангах, хамгаалах үүрэгтэй. Орчин үеийн нийгмийг эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны зарчим дээр үндэслэсэн хүний эрхгүйгээр төсөөлөх боломжгүй юм.

Нэгэнт хүн бүр эрх зүйн этгээд байхын дээр Монгол улсын төртэй харилцан эрх эдэлж, үүрэг хүлээх байдлаар эрх зүйн

харилцаанд оролцох болсон учраас Үндсэн хуульд тусгагдсан эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх ёстой.[201] Г.Эрдэнэбат "Хүний халдашгүй эрх" УБ хот, 2002 он хуудас 9, Энэхүү асуудлын хүрээнд хүний халдашгүй эрхийн асуудал зүй ёсоор багтана.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь бүхэлдээ хүний эрхийг хөндсөн байдлаар хэрэгждэг төрийн онцгой ажиллагаануудын нэг учраас хүний эрхийн хууль зүйн баталгаа байх учиртай. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хуульд заасан үндэслэл байгаа бол эрх бүхий тодорхой албан тушаалтнуудад хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу хүний эрхийг хөндөх, албадлага хэрэглэх эрх олгогдсон байдаг.

Цагдан хорих ТСАХ-г хэрэглэх явцад хүний эрхийг хангах зорилгоор олон улсын гэрээ, хэлэлцээр, коньвенцуудад болон дотоодын хууль тогтоомжуудад хэрхэн ямар зүйл,заалтууд тусгагдсан байдгийг авч үзье.

1948 оны 12 сарын 10-нд НҮБ-н Ерөнхий ассамблейгээс баталсан **"Хүний эрхийн түгээмэл тунхаглал"**-ын 3-р зүйлд зааснаар < Хүн бүр ... эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй>[2], 9-р зүйлд < Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй >[3], уг тунхаглал...

1966 оны 12 сарын 16-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаар батлагдаж, 1976 онд 35 улс нэгдэн орсноор хүчин төгөлдөр болсон. Монгол улс 1974 онд нэгдэн орсон."Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"-ын 9-р зүйлд:

1.Хүн бүр эрх чөлөөтэй байх болон халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчилж буюу цагдан хорьж болохгүй. Хуулиар тогтоосон үндэслэл, журмаас бусад аль ч тохиолдолд хэнийг ч хорьж болохгүй.

2. Баривчлагдсан хүн бүрт баривчлах үед баривчилсан шалтгааныг мэдэгдэхийн дээр түүнд тулгаж байгаа аливаа ялыг даруй мэдэгдэнэ.

3. Эрүүгийн хэргээр баривчлагдсан буюу саатагдсан хүн бүрийг шүүгчид буюу хуулийн дагуу шүүн таслах эрх бүхий өөр албан тушаалтанд нэн даруй шилжүүлнэ. Уг хүн хэргээ аль болохуйц ахар хугацаанд шүүхээр хэлэлцүүлэх буюу суллуулах эрхтэй. Хэргийг нь шүүхээр таслан шийдвэрлэх хүнийг цагдан хорих явдал нийтлэг журам байх ёсгүй бөгөөд шүүхэд ирж байх, ...шаардлагатай нөхцөлд таслан шийдвэрлэх тогтоол гүйцэтгэхэд ирэх баталгаа гаргасан нөхцөлд уг хүнийг чөлөөтэй байлгаж болно.

4. Баривчлагдаж буюу цагдан хоригдож, эрх чөлөөгөө хасуулсан хүн бүр түүнийг хорьсон хууль эрхийн үндэслэлийн талаар шүүхийн тогтоол нэн даруй гаргуулах, хэрэв хууль бусаар хоригдсон бол, суллуулах шийдвэрийг шүүхээр гаргуулах эрхтэй.

5.Хууль бусаар баривчлагдаж буюу цагдан хоригдож, хэлмэгдсэн хүн бүр хохирлоо нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргуулах эрхтэй.[4] ? уг пакт? Эндээс харахад манай улсын шинэ ЭБШ хуулиар баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгох эрхийг шүүхэд өгсөн явдал нь зүйд нийцэж байгаа юм.

УИХ-аас 2000 онд соёрхон баталсан " Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц"-ийн 10-р зүйлийн 1-д < ... эрүүдэн шүүхийг хориглох тухай сургалтын материал, мэдээллийг ямар нэгэн хэлбэрээр баривчлагдсан, албадан саатуулагдсан, шоронд хоригдсон этгээдийг цагдан хорих, байцаах болон түүнтэй харьцаж болох хууль сахиулах байгууллагын энгийн буюу цэрэгжсэн ажилтан, эмнэлэгийн ажилтан, төрийн албан тушаалтан болон бусад хүнийг бэлтгэх сургалтын хөтөлбөрт бүрэн тусгана.>, 2-д <...ийнхүү хориглосон заалтыг эдгээр этгээдийн дүрэм зааварт тусгана> гэж заажээ. Гэтэл манай улсад одоо болтол ийм зүйл хийгдээгүй, сургалтын хөтөлбөрт оруулаагүй. Хуулийн

[20] Монгол Улсын Их хурлаас 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан "Эрүүгийн байцаан шийтгэх хууль"-ийн 206 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

байгууллагын ажилтнуудын ажлыг дүгнэх журам шалгуурт тусгагдаагүй.

Мөн 11-р зүйлд <... эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зорилгоор нутаг дэвсгэртээ ямар нэгэн хэлбэрээр баривчлагдсан, саатуулагдсан, шоронд хоригдсон хүмүүсийг байцаахтай холбогдсон дүрэм заавар, аргачлал, үйл ажиллагаа, түүнчлэн хорих нөхцөл болон тэдгээрт харьцаж буй байдалд тогтмол хяналт тавьж байна. > гэж заажээ. Манай улсад энэ зүйлийн 1 дэх хэсэгтэй холбогдолтой хяналт байхгүй. Хорих байрны нөхцөлийн талаар зарим нэг хяналт шалгалт байгаа боловч хуулийн шаардлагад хүргэх арга хэмжээ авагдахгүй байна.

37-р зүйлд: <1. .... нэг ч хүүхдийн эрх чөлөөг хууль бусаар буюу дур мэдэн хасч болохгүй.

Манай ЭБШ хуулийн 366-р зүйлд насан хүрээгүй этгээдийг баривчлах ба цагдан хориход анхаарах тусгайлсан заалтыг оруулж өгсөн боловч уг этгээдийг цагдан хорих үндэслэл, журам нь насанд хүрэгчдийнхээс ялгагдах зүйл байхгүй байна. Тухайлбал: ЭБШ хуулийн 366.1-д < ...насанд хүрээгүй хүүхдийг ... 68-р зүйлд заасан онцгой тохиолдолд цагдан хорьж болно >[6] ЭБШ хуулийн 366.1-т заасан. Гэтэл энэ онцгой тохиолдол гэдэг нь: өмнө авсан ТСАХ-г зөрчсөн, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж *болзошгүй*, эсхүл оргон зайлсан тохолдолыг авч үзэж байна. Насанд хүрээгүй хүүхдийг ийм онцгой тохиолдолд хөнгөн, хүндэвтэр хэрэгт цагдан хорьж байгаа нь маш учир дутагдалтай юм. Харин насанд хүрээгүй этгээдийг баривчилсан, цагдан хорьсон тухай түүний эцэг, эх, хууль ёсны бусад төлөөлөгчид, өмгөөлөгчид нь 12 цагийн дотор мэдэгдэнэ гэж заасан байдаг боловч энэ заалт нь практикт насанд хүрэгчдийнхтэй адил хэрэгждэг. Мөн насанд хүрээгүй этгээдийг хорьж мөрдөх үндсэн хугацаа нэг сар байх бөгөөд хорьж мөрдөх нийт хугацааг 18 сараас хэтэрч болохгүй гэж зааж өгсөн нь "Хүүхдийн эрхийн коньвенц"-д заасан аль болохуйц богино хугацаагаар баривчилж, хорино гэсэн заалттай зөрчилдөж байна. Мөн 1994 онд батлагдсан " Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль"-нд < хаяг, эцэг, эх, харгалзан дэмжигч нь тодорхойгүй хүүхдийг цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан 7 хүртэл хоногоор түр саатуулж болно >[6] уг хуульд заасан. Түр саатуулах нь албадлага бөгөөд мөн чанартаа хоригдоно гэсэн үг. Гэм буруутай үйлдэл хийгээгүй байхад хүүхдийг хорьж буй нь эрхийн том зөрчил.

Монгол улс нь олон улсын эрх зүйн харилцаанд дээрх пактаар үүрэг хүлээж оролцдог учраас энэхүү эрхийг хангах талаар хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаагаар олон улсын харилцаан дахь нэр хүндийг тодорхойлох нэг шалгуур болдог. Ийм ч учраас олон улсын хэм хэмжээний энэхүү заалтуудыг иш үндэс болгон тус улсын "Үндсэн Хууль"-н 16-р зүйлийн 13-р хэсэгт заахдаа:

<...Иргэн бүр халдашгүй чөлөөтэй байх эрхтэй ,

Хуулинд заасан заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, мөрдөн мөшгөхийг хориглоно. Баривчлагдсан шалтгаан үндэслэлийг түүний ар гэр, өмгөөлөгчид заавал мэдэгдэнэ.>[721] МУ-ын Үндсэн хууль 1992 он.....

Аль ч улс орны ЭБШ ажиллагааны хуулийн зарчим, гол үзэл санаа, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн эрх ашгийг хамгаалах баталгаа, хяналтын механизм, процессийн ажиллагааны нээлттэй байдал зэрэг нь тухайн улсын ардчилсан байдал, хүний эрхийн байдлын нэг чухал хэмжүүр байдаг.

Хүнийг эрхийг хамгийн ихээр хөндөж байдаг харилцааг зохицуулдаг ЭБШ хуулийг УИХ-с 2002 онд шинэчлэн баталсан бөгөөд уг хуульд ололт, дэвшилттэй, шинэлэг, хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн олон чухал заалтууд орсон. Үүний нэг тод жишээ нь

[21] Монгол Улсын Их хурлаас 1993 оны 12 дугаар сарын 02-ны өдөр баталсан "Цагдаагийн байгууллагын тухай хууль"-ийн 27 дугаар зүйлийн 1-3 дахь заалт

сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгох эрх шүүхэд шилжсэн явдал юм. Баривчлах, цагдан хорих зөвшөөрлийг гэмт хэргийг илрүүлэх үүрэг хүлээсэн субьект бус харин шүүх яллагч болон өмгөөлөгч талын байр суурь, хэргийн талаархи мэдээ баримтыг харьцуулан авч үзэж мэтгэлцээний үр дүнг харгалзан олгох нөхцлийг бүрдүүлсэн. Энэ нь яах аргагүй хүний эрхэд эерэг нөлөө үзүүлэх нь дамжиггүй бөгөөд манай улс нэгдэн орсон олон улсын гэрээ коньвенцид бүрнээ нийцэж байгаа билээ.

Шинэ ЭБШ хуулийн нэгдүгээр бүлгийн 1О-р зүйлд " Хүний халдашгүй байх эрхийг хангах" гэсэн зүйлд хүнийг баривчлах, цагдан хорих үед эрхийг зөрчүүлэхгүй байх дараах заалтууд оржээ.<

- Энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч гэмт хэрэгт сэрдэн баривчилж болохгүй
- ... шүүгчийн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч цагдан хорихыг хориглоно.
- Прокурор нь хууль бусаар баривчилагдсан, цагдан хоригдсон, ...эсхүл хууль болон шүүхийн шийдвэрт зааснаас илүү хугацаагаар хоригдож байгаа этгээдийг нэн даруй суллах үүрэгтэй.
- Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй.
- Сэжигтнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өорийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг заавал сануулна.>[8] ЭБШХ

Мөн уг хуулийн хоёрдугаар бүлэгт заасан байцаан шийтгэх ажиллагааны гол зарчим, зорилтууд гэмт хэрэг нэг бүрийг бүрэн илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий харгис, нэр төрийг нь доромжлохгүй байх, сэжигтэнийг баривчлах үед өмгөөлөгч авах, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг заавал сануулах, эрүүгийн хууль болон байцаан шийтгэх хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэх зэрэг нь хүний эрхийг баталгаатай болгох, хилсээр хуулийн үндэслэлгүйгээр хүнийг шүүж шийтгэхээс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн байцаан шийтгэх ажиллагааг эсрэг тэсрэг нотлох баримтуудыг зэрэгцүүлэн авч үзэж, зөвхөн эрх тэгш бүхий яллагч, өмгөөлөгч (шүүгдэгч) талуудын мэтгэлцээний үндсэн дээр явуулахаар заасан.

Эдгээрээс гадна ЭБШ хуульд тусгагдсан хүний эрхийг хангахад чиглэгдсэн яах аргагүй дэвшилттэй, энэрэнгүй гэж зүй ёсоор үнэлэгдэх нэг хэсэг бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах тухай дөчин дөрөвдүгээр бүлэг юм. Уг бүлэгт < ЭБШ ажиллагааны явцад иргэнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгах, тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон нь хохирол нөхөн төлүүлэх эрх үүсгэх>[9] .... ЭБШ хуулийн 389-р зүйл ....ээр тогтоож өгсөн нь уг эрхийг баталгаатай болгоход чухал ач холбогдолтой. Харин < хууль бус ажиллагаатай холбогдож гарсан шууд бус хохирлыг төр хариуцахгүй > [10] ? ЭБШ хуулийн 389.4 ? гэсэн заалт Үндсэн хуулийн < учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх болон хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах төрийн үүрэг > ? 1992 оны Үндсэн хуулийн 16.16, 19.1 ? тэй нийцэхгүй байгаа юм.

ЭБШ хуульд тусгагдсан дээрх заалтууд болон бусад ололттой, хүнлэг, зөрөнгүй олон зүйл хэсгийг бүхэлд нь авч үзэж дүгнэвэл, байцаан шийтгэх өмнөх хуулиудаасаа илүү дэвшилттэй, мөрдөж мөшгих, байцаан саатуулах, хэргийн үндэслэлгүй сэрдлэг хардлагаас гэм буруугүй хүнийг эль болох хамгаалахад чиглэгдэж чадсанаараа ялгарч буй гэж хэлэх үндэслэлтэй,

Бид ОУ-ын эрх зүй, манай дотоодын хууль тогтоомжид цагдан хорих, баривчлах арга хэмжээний талаар ямар заалт байдгийг авч үзлээ. Харин энэ ОУ-ын эрх зүй болох ИУТЭТОУП болох бусад гэрээ, коньвенцтэй манай улсын хууль тогтоомж хэрхэн нийцэж зөрчилдөж байгаа байдлыг авч үзье[22].

1.Эрүүгийн хэргээр баривчлагдсан буюу саатуулагдсан этгээдийг шүүгчид буюу шүүн таслах эрх бүхий этгээдэд нэн даруй шилжүүлнэ гэж ИУТЭТОУП-д заасан. Монгол улсын ЭБШ хуулийн заалт шаардлагыг энэ хуульд нийцүүлж, баривчлах, цагдан хорих зөвшөөрлийг шүүгч шийдвэрлэдэг болсноор манай хууль тогтоомж үндсэндээ Пактын заалтад нийцэж байгаа юм.

2.Хэргийг нь шүүхээр таслан шийдвэрлэх хүнийг цагдан хорих явдал нийтлэг журам байх ёсгүй. Өөрөөр хэлбэл цагдан хорих явдлыг гагцаагүй тохиолдолд бага хэрэглэж байхыг энэ заалт анхааруулсан байна. Цагдан хорих асуудлыг хэрэглэхэд үндэслэл, журам гэсэн 2 шаардлага байдаг. Манай ЭБШ хуульд цагдан хорих үндэслэлийг заасан нь энэ зарчимтай хэрхэн нийцэж байгааг авч үзье. Цагдан хорьж болох ЭБШ хуульд заасан үндэслэл:

а) Эрүүгийн хуульд заасан онц хүнд, хүнд гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч

- удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд
- онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн, Үүнээс харвал онц хүнд, хүнд гэмт хэргийнх нь зарим торлийн субьектуудад шууд хэрэглэж болно гэсэн үг.

б).Хүндэвтэр гэмт хэргийн яллагдагч, шүүгдэгч, сэжигтэнд дор дурьдсан нөхцөл байвал хорьж болно.

- өмнө авсан ТСАХ-г зөрчсөн
- оргон зайлж болзошгүй эсвэл оргон зайлсан.

в) Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг

- урьд авсан ТСАХ-г зөрчсөн
- оргон зайлж болзошгүй, оргон зайлсан бол хорьж болохоор заажээ.

Энэ байдлаас дүгнэлт хийж үзэхэд гэмт хэргийн төрлийн (онц хүнд, хүнд, хүндэвтэр, хөнгөн) бүх ангилалд хэнийгч хорьж болохоор байна. Иймээс цагдан хорих ТСАХ-г нийтлэг хэрэглэх боломжийг ЭБШ хууль олгосон хэвээр байна. Иймд энэ ТСАХ-г хэрэглэхэд шүүгчийн байр суурь хандлагыг төлөвшүүлэх асуудал маш чухал байна. Энэ Цагдан хорих ТСАХ-г 2001-2004 онд хэрэглэж байсан байдлыг статистик үзүүлэлтээс сонирхъё.

2001 оны бүтэн жилд Улсын хэмжээнд 4934 хүн, 2002 оны эхний 8 сард 3353 хүн, сүүлийн 4 сард 1442 хүн, 2003 оны бүтэн жилд 2710 хүн, 2004 оны эхний хагас жилд 2880 хүн цагдан хоригдсон байна. (уг тоон үзүүлэлтийг аймаг нийслэлээр тус тусад нь гаргасан байдлыг мөн Цагдан хорих ТСАХ-ны талаархи бусад тоо баримтыг хавсралтаас харна уу) Үүнээс дүгнэлт хийж үзэхэд цагдан хорих явдлыг нилээд нийтлэг хэрэглэж байна.

[22] Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-д

Ялангуяа цагдан хорих, баривчлах зөвшөөрлийг шүүгчээс авдаг болсноос өмнөх үе буюу 2002 оны 9 сарын 1-нээс өмнө цагдан хорих ТСАХ-г ямар их хэмжээгээр хэрэглэж байсан нь харагдаж байгаа юм. Мөн хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настаны хувьд ялгамжтай хандаж байсан зүйл байхгүй гэж хэлж болно.

Хуульд хорих үндэслэлийг заасан хэдий ч практик дээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчдын хорих шийдвэр гаргах үндэслэл нь сэжигтэн, яллагдагч хэргээ хүлээхгүй, учруулсан хохирлоо төлөхгүй байх явдал юм. Гэтэл ЭБШ хуулийн цагдан хорих зорилго нь өөр юм.

1. Баривчлагдсан буюу саатуулагдсан этгээд хэргээ аль болох ахар богино хугацаанд шүүхээр хэлэлцүүлэх, суллуулах эрхтэй. Цагдан хорих ТСАХ-г аль болох богино хугацаагаар хэрэглэж, шүүхээр хэргийг шийдүүлэхийг энэ заалт санал болгож байна. Манай хуульд цагдан хорьж мөрдөх ерөнхий хугацаа 2 сар гэж заасан. Хүндэвтэр, хүнд, онц хүнд хэргийн холбогдогчдийг шаардлагатай бол 24 сар хүртэл сунгаж болно. Бүр онц хүнд хэрэгт 30 хүртэл сар байж болохоор асар урт хугацааг заасан.

Нийслэлийн хэмжээнд 2003 онд 1613 хүний хорьж мөрдөх хугацааг 3061 удаа сунгажээ. Хүүхдийг 18 сар хүртэл хорьж болохоор байна. Энэ нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийн < хүүхдийг баривчлах, албадан саатуулах, гянданд хорих явдлыг хуулийн дагуу гүйцэтгэх бөгөөд гагцхүү эцсийн арга хэмжээ болгож аль болохуйц богино хугацаагаар хэрэглэх > гэсэн заалтыг зөрчиж байгаа юм.

4. Иргэн хүн өөртэй нь холбоотой асуудлыг шүүхээр хянан хэлэлцэхэд өөрөө биечлэн болон сонгон авсан өмгөөлөгчөө оруулах эрхтэй.(ИУТЭТОУП). Манай ЭБШ хуулийн баривчлах, цагдан хорих тухай заалтуудад баривчлах буюу цагдан хорих зөвшөөрөл өгөх тухай шүүгчийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулаагүй байна. Бидний үзэж байгаагаар тухайн этгээдийг болон түүний өмгөөлөгчийг Цагдан хорих ТСАХ-г авах асуудлыг шийдвэрлэхэд оролцуулах явдал чухал байна. Хэргийн материалаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын танилцуулснаар бүхнийг шийдэх нь өрөөсгөл юм.

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрийн шугамаар хийж буй журамд энэ асуудлыг шийдэхэд яллагдагч, шүүгдэгч, өмгөөлөгчийг оролцуулж тайлбарыг нь сонсохоор тусгагдсан байна. Ер нь зөвхөн нэг талын тэр тусмаа хорих сонирхолтой этгээдийг нь оролцуулах учир дутагдалтай. Ялангуяа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт холбогдсон болон хүүхэд, эмэгтэйчүүдэд уг арга хэмжээг хэрэглэхдээ тэднийг оролцуулах шаардлагатай. Цагдан хоригдсон этгээдийн хүүхэд (бага насны), өндөр настан эцэг, эх, асруулагчийг харгалзан дэмжүүлэхээр төрөл садны буюу бусад хүмүүс зохих байгуулагад хүлээлгэн өгөх тухай тогтоол шийдвэр гаргаж байх тухай ЭБШ хуульд тодорхой заасан. Түүнчлэн хуульд заагаагүй ч гэсэн цагдан хоригдсон этгээдийн ажил төрөлтэй холбоотой бусад асуудлыг анхаарч үзэх нь хүнлэг, энэрэнгүй ёсны баталгаа болно.

Хуулийн зарим байгууллагаас Цагдан хорих ТСАХ-г хууль бусаар хэрэглэж хүний эрхийг зөрчиж байсан зарим нэг жишээ баримтыг үзэхэд дараах зөрчил дутагдал илэрч байжээ.

Шүүх нь хүний эрх, эрх чөлөө шударга ёсны баталгаа мөн.[9] ?Шүүхийн тухай хуулийн

3.2? Энэ талаар тодорхой заасан байдаг. Гэтэл Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын нутагт гарсан хүн амины хэрэгт анх 1995 оны 12 сарын 31-ны өдрөөс эхлэн эрүүгийн хэрэг үүсгэж иргэн Э-г уг хэрэгт холбогдуулан 7 жил шалгаад эцэст нь шүүх гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдоогүй гэж сулалсан / 609003 дугаарын эрүүгийн хэрэг/ Энэ 7 жилийн хугацаанд түүнийг анхан шатны шүүхээс 3 удаа цаазаар авах ял, 3 удаа 25 жилийн хорих ялаар шийтгэж байсан бөгөөд тэрээр шүүхийн тогтоолоор 5 жил гянданд хоригдсон байна. Энэ хэргийг цагдаагийн байгууллага шалгахдаа анхнаасаа хариуцлагагүй хандсан, шүүх 6 удаа ял оноож байсан нь шүүгч нарын ажлын хариуцлага, хууль хэрэгжүүлэх ёс суртахуун, хүний хувь заяанд хандах хандлага ямар түвшинд байгааг харуулсан аймшигт баримт юм.[9] Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл 2004он УБ хууд 43 Харамсалтай нь энэ зөвхөн ганцхан баримт биш юм.

Цагдаагийн байгууллага нь нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүрэгтэй, нэгдмэл төвлөрсөн удирдлагын зарчимтай бүх шатны удирдлагыг дээд шатны байгууллагаас томилдог, үйл ажиллагааны онцгой нөхцөл байдалтай байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт нь хүний эрхийн асуудалтай шууд холбоотой. Цагдаагийн байгууллагын харъяанаас урьдчилан хорих, албадан саатуулах байрыг гаргаж, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад шилжүүлсэн нь хүний эрхийг хангах нэг зөв халхам болсон гэж үзэж болно.

ХЭҮК-с УМБГ, нийслэлийн бүх дүүргүүд болон Төмөр зам, ЗЦГ, 18 аймгийн мөрдөн байцаах тасагт 2001 он болон 2002 оны эхний улиралд хэрэгсэхгүй болгосон 4236 хэрэгт холбогдогсдын хуульд заасан эрхийн хэрэгжилтийг судалж үзэхэд, хэрэгсэхгүй болгогдсон хэрэгт холбогдсон дөрвөн хүн тутмын нэгийг нь 3-1О47 хоногоор баривчилж, цагдан хорьсон байна. Үүнтэй холбогдуулж, хэрэгт холбогдогчдыг хууль бусаар хорьдог, эрх мэдлээ хэтрүүлэн дураараа аашилдаг алба хаагчидтай хариуцлага тооцуулах шаардлагыг ХЭҮК-с тавьсаны дагуу ЦЕГ-с 52 хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид “процессийн зөрчил гаргасан” гэж сахилгын арга хэмжээ авахуулсан байна.[10] ....ЦЕГ-н 2002.10.10-ны өдрийн 2/222 тоот танилцуулга?

Төв аймгийн Цагдаагийн хэлтсийн ажилтан А гэгч иргэн Б-г цагдан хорьж, айлган сүрдүүлж, дарамталж байгаад бусдын хөөрөг хулгайлсан гэж хэрэг хүлээлгэн шүүхэд шилжүүлсэн байна ба шүүх түүнийг 1 жилийн хугацаагаар хорих яло шийтгэжээ. Гэтэл хөөргөө алдсан гэх айлыг нүүх үед хөөрөг нь номын тавиур дооронос нь гарч ирсэн бөгөөд иргэн Б нь ялаа эдлээд дууссан байсан. Цагдаагийн байгууллагаас А-д цалинг нь 20 хувиар хасч, сахилгын шийтгэл оногдуулсан байна.[11] ....ЦЕГ-н 2002 .08. 08-ны өдрийн 2/172 тоот танилцуулга?

Бусдын олон тооны адуу хулгайлсан хэрэгт Г гэгч хүнийг Төв аймгийн Цагдаагийн хэлтсийн ажилтнууд 11 сарын хугацаагаар хорьж хэргийг шүүхэд шилжүүлжээ. Энэ хугацаанд яллагдагч Г-г 9 удаа байцаасан байх бөгөөд үүний 7-д нь тэрээр “миний бие муу байна”гэж мэдүүлжээ. Эцэстээ тэрээр шүүхийн тогтоол гарсны дараа сүрьегийн хүндрэлээр нас барсан байна.Энэ хэргийг гардан шалгасан цагдаагийн ажилтны цолыг нэг шатаар бууруулж арга хэмжээ авчээ.

Булган аймгийн Цагдаагийн хэлтсийн ажилтан М нь иргэн Ш-г хэрэгт холбогдуулан шалгахдаа сумын уурын зууханд 2 хоног

гавтай хорьсон байна.Түүний энэ үйлдэлд сарын үндсэн цалинг 2 сарын хугацаагаар хорьж сахилгын шийтгэл ноогдуулжээ.[12] ?УЕПГ-н дэргэдэх Мөрдөн байцаах албаны 2002.12.31-ны өдрийн 224 тоот....[23]

2003 онд Төв аймагт Г гэгч нь 60 хоног Цагдан хоригдоод хэрэг нь шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Тэрээр үндэслэлгүйгээр хоригдсон гэж Төв аймгийн хуулийн байгууллагуудаас 40 сая төгрөг нэхэмжилсэн тохиолдол гарчээ.

Цагдан хорих ТСАХ-г хэрэглэхдээ хорих арга хэмжээг эдлүүлж буй ахуй нөхцөл ямар байгааг бодолцох хэрэгтэй болох нь дээрх жишээ баримтаас харагдаж байгаа юм. Хорих байрны нөхцөл журмыг 1999 онд "Сэжигтэн,яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай" хууль гаргаж баталгаажуулсан боловч хуульд заасан болзол, шаардлага огт биелэхгүй байна.

Манай хорих байрны ахуй нөхцөл туйлын муу жинхэнэ шорон, гяндангийн хэлбэртэй, хүний эрүүл ахуйн шаардлагыг огт бодолцоогүй баригдсан. Хорих байр нь залхаах, бие сэтгэл санааны дарамт учруулах, хэрэг хүлээлгэх арга хэрэгсэл болж байна.

Гэхдээ Цагдаагийн ажилтнуудаас ГА-г хэрэглэхийн тулд, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын тактик, аливаа сөрөл нөлөө үзүүлэхгүй үүднээс сэжигтэн яллагдлагчийг хорих, нэг газраас нөгөө газарт шилжүүлэн хорих зайлшгүй шаардлага гардаг боловч үүнийг аль болох бага хийх хэрэгтэй. Жишээ нь: Увс аймагт банкнаас 38 сая төгрөг залилан авсан 2 эмэгтэйг Цагдан хориход хоорондоо үгсээд хэргийн бодит үнэнийг тогтооход саад учруулж байсан тул Баянөлгий аймагт нэг эмэгтэйг нь хорьсон. Говьалтай аймагт ченж алсан Увсын иргэн Б-г Баян-өлгийд Цагдан хорьсон нь залхаан цээрлүүлэлт биш тактикийн асуудал юм. Иймд Цагдан хорих зөвшөөрөл олгодог шүүгч нь энэ талаар толорхой мэдлэгтэй байх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

Санал:

ЭБШ хуульд бүх шүүгч нар баривчлах цагдан хорих зөвшөөрөл өгөхөөр заасан байна. Энэ нь учир дутагдалтай хүний эрхийг зөрчихөд нөлөөлдөг тул хуульд Цагдан хорих зөвшөөрөл олгодог *дагнасан нэг шүүгчтэй* байх талаар тусгайлсан заалт оруулах

Хөнгөн гэмт хэрэгт сэрдэгдсэн буюу хүнд өвчтэй, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй, насанд хүрээгүй хүүхэд, жирэмсэн эмэгтэйг 68-р зүйлийн 2-д заасан үндэслэлээр цагдан хорих явдлыг таслан зогсоож энэ талаар хуульд байгаа 68-р зүйлийн 8, 68-р зүйлийн 9-г хуулиас хасах талаар уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төсөлд санал оруулах

ЭБШ хуулийн 68-р зүйлийн 6-д шүүгдэгчийг шүүгч захирамж гарган цагдан хорьж болохоор заасан боловч, шүүгч нь шүүгдэгчид Цагдан хорих ТСАХ-г авсан талаар 24 цагийн дотор түүний ар гэрт мэдэгдэх талаар зааж өгөөгүй, энэ арга хэмжээг авахдаа ямар хугацаатай байхыг тодорхой заагаагүй тул энэ талаар тодорхой зааж өгөх

1. Шүүгчийн шүүгдэгчид авсан Цагдан хорих ТСАХ-нд ямар албан тушаалтан хяналт тавих, түүний авсан арга хэмжээ нь хууль бус байвал уг арга хэмжээг ямар албан тушаалтан өөрчлөх талаар хуульд тусгайлан заалт оруулах

2. ЭБШ хуульд хорьж мөрдөх хугацаа 24 сараас хэтэрч болохгүй, ...

[23] Б.Бат-Эрдэнэ "Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй" УБ. 1999. 135 дахь тал
Монгол улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 1-ийн 2 дахь заалт

шаардлагатай бол 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно гэж заасан нь ИБУТЭТОУП-д "ахар богино хугацаагаар хорих" талаар заасан заалттай харьцуулахад дэндүү их хугацаа тул Цагдан хорих хугацааны талаар хуульд өөрчлөлт оруулах.

3. Хорих хугацааг сунгахад тавьж буй прокурорын хяналт хангалтгүй байгаа тул энэ талаар тодорхой арга хэмжээ авахуулах.

4. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар нь Цагдан хорих ТСАХ-г хэрэглэхэд бүгд оролцож байдаг тул энэ арга хэмжээг хууль бусаар хэрэглэж хүнийг хууль бусаар хорьсон тохиолдолд дээрхи алба хаагчдад хэрхэн яаж ямар арга хэмжээ авах талаар тушаал,заавар гаргах .

5. Цагдан хорих ТСАХ-г хавтгайруулан хэрэглэж хүнийг залхаах, дарамтлах улмаар хэрэг хүлээлгэх арга хэрэгсэл болгон ашиглаж байгааг таслан зогсоох.



Ш.ЭНХЖАРГАЛ
Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процессын эрх зүйн тэнхимийн багш, ахмад

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ГОМДОЛ, МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН СУДАЛГАА

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь өөрийн гэсэн онцлог түүхтэйгээр хөгжиж ирсэн. Шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны уламжлал бол эд хөрөнгийн болон эдийн бус эрхийг хамгаалах эх сурвалжтайн дээр хүн төрөлхтний түүхэн хөгжлийн үе шат бүхэнд энэхүү хамгаалалт нь олон янзын арга хэлбэрээр хэрэгжиж байсан байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны түүхэн замнал бол нэн эртнээс улбаатай асуудал юм.

Учруулсан хохирлын төлөөс төлбөрийг гаргуулах талаар эртний онол, практик нь ял шийтгэл, хариу өр төлөөс гэсэн үзэл санааг баримжаалж ирсэн байдаг[24].

Түүхийн хуудаснаас сөхөн үзвэл: **Эртний Хүннү улсын ердийн хэв хуульд** "Ялд унасан хүнийг үйлдвэрлэл, гар урлалын ажилд зүтгүүлдэг" байжээ. Монголын нууц товчоонд Чингис хаан дайн байлдаанд үрэгдсэн хүмүүсийн ар

[24] /Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. МУ-ын төр эрх зүйн түүхэн уламжлал. 1997 он, 390-р тал/

шаардлагатай бол 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно гэж заасан нь ИБУТЭТОУП-д "ахар богино хугацаагаар хорих" талаар заасан заалттай харьцуулахад дэндүү их хугацаа тул Цагдан хорих хугацааны талаар хуульд өөрчлөлт оруулах.

3. Хорих хугацааг сунгахад тавьж буй прокурорын хяналт хангалтгүй байгаа тул энэ талаар тодорхой арга хэмжээ авахуулах.

4. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар нь Цагдан хорих ТСАХ-г хэрэглэхэд бүгд оролцож байдаг тул энэ арга хэмжээг хууль бусаар хэрэглэж хүнийг хууль бусаар хорьсон тохиолдолд дээрхи алба хаагчдад хэрхэн яаж ямар арга хэмжээ авах талаар тушаал,заавар гаргах .

5. Цагдан хорих ТСАХ-г хавтгайруулан хэрэглэж хүнийг залхаах, дарамтлах улмаар хэрэг хүлээлгэх арга хэрэгсэл болгон ашиглаж байгааг таслан зогсоох.



Ш.ЭНХЖАРГАЛ
Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процессын эрх зүйн тэнхимийн багш, ахмад

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ГОМДОЛ, МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН СУДАЛГАА

Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь өөрийн гэсэн онцлог түүхтэйгээр хөгжиж ирсэн. Шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны уламжлал бол эд хөрөнгийн болон эдийн бус эрхийг хамгаалах эх сурвалжтайн дээр хүн төрөлхтний түүхэн хөгжлийн үе шат бүхэнд энэхүү хамгаалалт нь олон янзын арга хэлбэрээр хэрэгжиж байсан байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны түүхэн замнал бол нэн эртнээс улбаатай асуудал юм.

Учруулсан хохирлын төлөөс төлбөрийг гаргуулах талаар эртний онол, практик нь ял шийтгэл, хариу өр төлөөс гэсэн үзэл санааг баримжаалж ирсэн байдаг[24].

Түүхийн хуудаснаас сөхөн үзвэл: **Эртний Хүннү улсын ердийн хэв хуульд** "Ялд унасан хүнийг үйлдвэрлэл, гар урлалын ажилд зүтгүүлдэг" байжээ. Монголын нууц товчоонд Чингис хаан дайн байлдаанд үрэгдсэн хүмүүсийн ар

[24] /Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. МУ-ын төр эрх зүйн түүхэн уламжлал. 1997 он, 390-р тал/

гэрийнхнийг тэтгэх зорилгоох "Өнчдийг тэтгэх сан" байгуулж байсан байна[25]. **Их засаг хуульд** "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг том, бага хэмээн үзэж, ял оногдуулахдаа харгалзан үзэж байсны дээр хулгайлагсдыг алах бөгөөд түүний гэргий ба мал хөрөнгийг хурааж, хулгайлуулагсдад өгмой.[26] гэсэн заалт байсан нь хохирогчийг тогтоож, учирсан хохирлыг нөхөн төлүүлж байсны баримт нотолгоо юм.

Мөн Монголын хаант улсын гол хууль болох Зарлигаар тогтоосон Монгол Улсын зүйлийн бичгийн **"Хүний амин"** хэмээх хуульд ". . . хохирогч хүний ам бүлд 20 лан хүртэл мөнгө гаргаж өгөх, яс хувцаслах мөнгө гаргуулах (оршуулгын зардлыг гаргуулах) . . ."[27] тухай заасан байна.

Эртний улсуудын хууль тогтоогчид шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд одоо үеийнхээс ч илүүтэйгээр анхаарал хандуулж байсан баримт цөөнгүй байдаг. Угсаатны зүй, хууль зүйн антропологийн мэдээ баримт, судалгаанаас үзэхэд хүмүүс мөргөлдөөнийг хүч хэрэглэх замаар, эсхүл тайван, эв зүйгээр шийдвэрлэх гэсэн хоёр үндсэн аргаар зохицуулж иржээ. Хамгийн нийтлэг бөгөөд энгийн арга нь албадлага хэрэглэх буюу хохирлыг арилгах тогтолцоо, нөгөө нь хүч хэрэглэхийг хориглосон ёс, ёслолын буюу эвлэрэх, найрамдах хэлбэрт шилжүүлэн оруулж шийдвэрлэдэг жишиг байжээ.

Монгол оронд 1921 онд Ардын хувьсгал ялж, 1926 онд Ардын шүүх байгуулагдснаар шүүхээс гарсан шийдвэр, тогтоолыг Шүүхийн тогтоол гүйцэтгэгч нар гүйцэтгэж иржээ. 1921 оноос одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдан гарах хүртэлх хугацаанд засаг төрийн дээд байгууллагаас батлагдсан тухайн үеийн хуулиуд, төрийн дээд байгууллага, Яам, Улсын хороо, газруудаас гаргасан зарлиг, тогтоол, тушаал зэргээр зохицуулагдаж явсаар 1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр "Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль" батлагдан гарснаар тогтоол гүйцэтгэлийн алба нь Хорих байгууллагуудыг удирдах газартай нэгдэн Хууль зүйн яамны харъяанд ирсэн.

1990 оны ардчилсан хувьсгал ялсны үрээр социалист дэглэм нуран унаж, өмчийн олон хэлбэрт шилжснээр иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь шинэ хэлбэрт шилжин ажиллах шаардлага тулгарсан. Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь бэрхшээлтэй, хүч хөдөлмөр ихээр шаардсан ажил хэдий ч шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шийдвэр нэг бүрийг биелүүлэхийн төлөө анхааран, үр дүнтэй ажиллаж байгаа нь сүүлийн 3 жилд хийсэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлтийн мэдээнээс харахад илэрхий байна. Улсын хэмжээнд:

-2011 оны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт дунджаар 36,9%,

-2012 оны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт дунджаар 40,3%

---

[25] / Монголын нууц товчоо.1957 он. 25-р тал/

[26] " Сайшаал-Чингис хааны товчоон. Хөх хот. 1987 он 534-р тал/

[27] /Б Содовсүрэн. Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цаазын,1989 он,109-р тал /



-2013 оны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт дунджаар 53,6%-тай байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүн нь шүүхийн шийдвэр /тогтоол, захирамж / бодитой биелэгдэж, нэхэмжлэл хангагдсан байхыг хэлнэ.[28] Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу түргэн шуурхай явуулахад тулгарч буй саад бэрхшээлийн нэг нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд болон гуравдагч этгээдээс шүүх болон хууль хяналтын байгууллагад өргөдөл, гомдол гаргаснаас шалтгаалан шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа удаашрах нэг шалтгаан болдог.

2013 оны 10 сарын байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нийт 2047 өргөдөл, гомдол хүлээн авснаас, 324 өргөдөл, гомдол буюу 15,8 хувь нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны талаар гаргасан өргөдөл, гомдол эзэлж байна. Эдгээр өргөдөл, гомдол бүрийг хуульд заасны дагуу хянан шийдвэрлэж зохих хариуг өгч, ажилласан байна.

Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд онцгой байр суурийг эзэлж, улсын хэмжээний гүйцэтгэлийн 46%-ийг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба дангаараа хариуцан явуулдаг.

Тэгвэл энэ албаны үйл ажиллагаатай холбогдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талууд болон гуравдагч этгээдээс шүүхэд гаргасан нэхэмжлэлийг шийдвэрлэсэн байдалд судалгаа хийж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд тулгарч буй саад бэрхшээлийг тогтоох, шалтгаан нөхцлийг судлах зорилгоор Сүхбаатар дүүргийн шүүхэд иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой гомдол, маргааныг хянаж, шийдвэрлэсэн байдалд судалгаа хийж үзлээ.

Сүхбаатар дүүргийн шүүхэд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд холбогдох

- 2011 онд 125 нэхэмжлэл,
- 2012 онд 61 нэхэмжлэл,
- 2013 онд 29 нэхэмжлэлийг

тус тус хүлээн авч, хянан шийдвэрлэсэн байна.

Хянан шийдвэрлэсэн байдлыг он тус бүрээр нь авч үзвэл:

2011 онд: Нийт шийдвэрлэсэн 125 хэргийн

[28] Хууль дээдлэх ёс. 2007 он №01. 81-р тал

-61,6 хувь буюу 77 нэхэмжлэлийн шаардлагыг хангахаас бүрэн татгалзаж, хэрэгсэхгүй болгосон,

-31,2 хувь буюу 39 нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгож шийдвэрлэсэн,

2012 онд: Нийт шийдвэрлэсэн 61 хэргийн

-47,5 хувь буюу 29 нэхэмжлэлийн шаардлагыг хангахаас бүрэн татгалзаж, хэрэгсэхгүй болгосон,

-49,1 хувь буюу 30 нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгож шийдвэрлэсэн,

2013 онд: Нийт шийдвэрлэсэн 29 хэргийн

-62,0 хувь буюу 18 нэхэмжлэлийн шаардлагыг хангахаас бүрэн татгалзаж, хэрэгсэхгүй болгосон,

-27,5 хувь буюу 8 нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгож тус тус шийдвэрлэсэн байна.

Нэхэмжлэлийн тоон үзүүлэлтээс харахад иргэд, байгууллагаас шүүхэд ирүүлсэн нэхэмжлэлийн тоо буурч байгаа нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны үр дүн юм.

Шүүхийн шийдвэрийг /захирамж, магадлал, тогтоол/ үзэхэд:

Шийдвэрлэсэн хэргийн:

-67.7 хувь нь үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ болон албадан дуудлага худалдааг хүчингүй болгож шийдвэрлэсэн,

-27.4 хувь нь шийдвэр гүйцэтгэгчийн бууутай үйл ажиллагаанаас болж гүйцэтгэлийн ажиллагаа хүчингүй болсон,

-0.67 хувь нь шинжээчийн үнэлгээг бодит бус гэж үзэж, үнэлгээг хүчингүй болгосон,

-4.2 хувь нь бусад /албадан дуудлага худалдааны мэдэгдэл төлбөр төлөгчид хугацаандаа очиж чадаагүйн улмаас дуудлага худалдааг хүчингүй болгож шийдвэрлэсэн гэх мэт/ шалтгаанаар гүйцэтгэлийн ажиллагааг тус тус хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Шийдвэр гүйцэтгэгчийн бууутай үйл ажиллагаанаас болж гүйцэтгэлийн ажиллагааг хүчингүй болгосон хэрэгт дараах нийтлэг дутагдал харагдаж байна.

Үүнд:

-Шүүхийн шийдвэрт зааснаас бусад шийдвэрлээгүй үр дагавар бүхий ажиллагааг дур мэдэн явуулсан,

-Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд тухайн цаг хугацааныхаа сүүлийн бодит лавлагаа, мэдээллийг ашиглаагүй, хуучирсан мэдээлэл, лавлагаанд тулгуурлан ажиллагаа явуулсан,

-Хууль ёсны өмчлөгчийг буруу тогтоон бусдын өмчлөлийн эд хөрөнгөд ажиллагаа явуулсан,

-Албадан дуудлага худалдааны мэдэгдлийг хуулийн хугацаанд гардуулаагүй, эсхүл шуудангаар явуулснаас хугацаа алдсан, буцсан,

-Ажиллагаатай холбоотой асуудлаар шүүхэд гомдол гаргасны дагуу хянан шийдвэрлэгдэж байхад ажиллагаа явуулсан,

-Барьцааны эд хөрөнгөөс өөр хөрөнгөд ажиллагаа явуулсан,

-Гэр бүлийн гишүүдийн хуваарьт эд хөрөнгийг буруу тогтоон ажиллагаа явуулснаас болж шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хүчингүй болсон нийтлэг дутагдал байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ болон албадан дуудлага худалдааг хүчингүй болгосон шийдвэрээс харахад:

-Тухайн эд хөрөнгийн бусад өмчлөгч нараас үнийн санал аваагүй болон шүүхийн шийдвэрээр худалдагдах эд хөрөнгөнөөс хасахаар шийдвэрлэсэн үл хөдлөх эд хөрөнгийг албадан дуудлага худалдаанд /цаашид АДХ[29] гэх/ оруулсан,

-АДХ-ны талаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудад өгсөн мэдэгдэл, АДХ-нд оруулах тогтоол, нийтэд мэдээлсэн үнэ нь хоорондоо зөрүүтэй бичигдсэн байх,

-Төлбөр авагч, төлбөр төлөгч нараас үнийн санал авсан талаар, үнийн санал өгөөгүй, эсхүл тохиролцоонд хүрээгүй гэдгийг баримтаар нотолж чадаагүйн улмаас,

-Төлбөр төлөгч болон төлбөр авагч нараас үнийн санал авахдаа хугацааны хувьд зөрүүтэй авснаар зах зээлийн бодит ханшийг тогтооход нөлөөлсөн,

-Анхны АДХ-нд гомдол гаргаж амжаагүй байхад 2 дахь АДХ-г явуулсан,

-АДХ явагдсан талаар мэдэгдээгүй, мэдэгдсэн ч танилцсан талаарх гарын үсэг, нотолгоо байхгүй, эсхүл гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх бололцоог хангаагүй,

-Шинжээч томилж үнэлгээ тогтоосон талаар төлбөр төлөгч, төлбөр авагч, бие даасан шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээдэд цаг тухайд нь мэдэгдээгүй,

-АДХ явуулахдаа урьд шүүхээр хүчингүй болгосон дуудлага худалдааны үнээр дахин оруулсан зэрэг нийтлэг зөрчлийн улмаас үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдааг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Шүүхээр хянан хэлэлцэгдэж хүчингүй болсон АДХ-ны 83,8 хувь нь Монгол Улсын Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1."Дуудлага худалдаагаар худалдах үл хөдлөх эд хөрөнгийн санал болгох үнийг дуудлага худалдаа явуулахаас өмнө үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, өмчлөгч харилцан тохиролцож тогтоох бөгөөд хэрэв тохиролцохгүй бол дуудлага худалдаа явуулах эрх бүхий этгээд хараат бус, мэргэжлийн үнэлгээчийн саналыг үндэслэн тогтооно. Хараат бус мэргэжлийн үнэлгээчийг дуудлага худалдаа явуулах эрх бүхий этгээд томилно."

Мөн хуулийн 177 дугаар зүйлийн 177.4. "Хоёр дахь дуудлага худалдаанд оролцогчоос санал болгосон үнэ нь дуудлага худалдаа явуулахтай холбогдсон зардал болон үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангахад хүрэлцэхүйц байна. Энэ хэмжээнд хүрэхгүй бол дуудлага худалдаа явуулаагүй гэж үзнэ. Дуудлага худалдаатай холбогдсон зардлыг өмчлөгч хариуцна." гэсэн заалтуудыг зөрчсөний улмаас шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хүчингүй буюу хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1-д заасан тохиролцуулах ажиллагааг явуулахдаа ".....харилцан тохиролцож тогтоох...." гэсэн шаардлагыг хангаагүй байна. Талуудыг байлцуулаагүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаанаар нэгэн зэрэг ирж чадаагүй тохиолдолд нэн даруй нөгөө талуудад үнийн саналын талаар танилцуулж, санал аваагүй байна. Зарим гүйцэтгэлийн ажиллагаан дээр талуудаас авсан саналын хооронд нэг сар гаруйн хугацаа өнгөрсөн байна. Энэ нь бодит ханш гэж үзэхэд учир дутагдалтай.

Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.4-д "...Хоёр дахь дуудлага худалдаанд оролцогчоос санал болгосон үнэ нь дуудлага худалдаа явуулахтай холбогдсон зардал

[29] Албадан дуудлага худалдаа гэж ойлгох

болон үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангахад хүрэлцэхүйц байна....” гэсэн заалтыг Улсын Дээд албан ёсоор тайлбарлаагүйгээс шүүгч бүр өөрийн үзэмжээр шийдэж байгаа нь гүйцэтгэлийн ажиллагааг хүчингүй болгох нэг шалтгаан болж байна. Гэвч зарим хүчингүй болсон гүйцэтгэлийн ажиллагаанаас харахад “...шаардлагыг хангахад хүрэлцэхүйц...” хэмжээг тодорхойлж, тогтоосон үнэлгээгээ нотлох баримтаар нотолж чадаагүй байна.

Цаашид Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.4-т заасан 2 дахь албадан дуудлага худалдааны үнийг тогтоох мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7 дахь заалтын дагуу шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулахад хичнээн төгрөгийн зардал гарсан, гарсан зардлыг хэрхэн хасаж төлбөрт тооцож байгаа, зөрүүг яаж тооцож төлбөр төлөгчид буцааж байгаа зэрэг санал болгох үнийг тогтоосон баримт нотолгоог хангалттай бүрдүүлэх, энэ талаарх хурлын тэмдэглэлийг үйлдэж, төлбөр төлөгч болон төлбөр авагч нараар баталгаажуулах шаардлагатай байна. Тодруулж хэлбэл шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны алхам бүрийг шийдвэр гүйцэтгэгч тэмдэглэл болон бусад нотлох баримтаар баталгаажуулж байх шаардлагатай.

ИХШХШТХуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Хэргийн оролцогчдоос өөрийн шаардлага ба татгалзлаа үндэслэж байгаа, шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, хуульд заасан арга хэрэглэлээр олж авсан бодит нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ”, мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т “Хэргийн нотлох баримт нь зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл ба эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дүрс, дууны бичлэг, ул мөрнөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, таньж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно.” гэж заасан. Шүүх, шүүгч цугларсан нотлох баримтад тулгуурлан шинжлэх ухааны аргуудыг ашиглан өөрийн дотоод итгэлдээ тулгуурлан үнэлдэг тул шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад нотлох баримтыг байнга үйлдэж, баталгаажуулж байх хэрэгтэй байна.

Энэ нь шүүхэд, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Анхны дуудлага худалдаагаар санал болгосон үнэд хүрэх санал гараагүй буюу дуудлага худалдаанд хэн ч оролцоогүй бол хоёр дахь дуудлага худалдааг явуулахаар Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.2-т заасан. Гэвч зарим шүүгч нэг ч хүн оролцоогүй байхыг дуудлага худалдаа явагдсан гэж үзэхэд учир дутагдалтай хэмээн 2 дахь дуудлага худалдааг хүчингүй болгож байна.

Иймд анхны албадан дуудлага худалдаанд оролцогч ирээгүй, үнийн санал өгөөгүй тохиолдлыг шууд утгаар ойлгохоор Улсын Дээд шүүхээс албан ёсны тайлбар гаргуулах хэрэгтэй байна.

Мөн үл хөдлөх эд хөрөнгийг үнэлсэн үнэлгээ нь шүүхээр хүчингүй болсон, эсхүл дуудлага худалдаа хүчингүй болсон бол тухайн үл хөдлөх эд хөрөнгийг үнэлсэн итгэмжлэл бүхий хуулийн этгээд хөнгөлттэй үнээр дахин үнэлгээ хийдэг байхаар холбогдох хууль журам, гэрээнд тусгаж өгөх шаардлагатай байгааг дурьдах нь зүйтэй юм.



С.БУЯНЗАЯА

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процессын эрх зүйн тэнхимийн багш, ахлах дэслэгч

ТӨЛБӨР ТӨЛӨГЧИЙГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд оролцогч талууд бол нэг талаас төлбөр төлөгч, нөгөө талаас төлбөр авагч хоёр байдаг. Төлбөр авагч гэдэг нь хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж түүнийг сэргээх, хамгаалахаар гүйцэтгэх баримт бичигт заасан иргэн, хуулийн этгээдийг хэлнэ. Харин төлбөр төлөгч гэдэг нь төлбөр авагчийн эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн буюу үүргээ биелүүлээгүй гэж гүйцэтгэх баримт бичигт заасан иргэн хуулийн этгээдийг хэлдэг.

Төлбөр авагчийн шаардлагыг хангахын тулд шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан дараах ажиллагаануудыг явуулдаг. Үүнд:

1. Төлбөр төлөгчид эд хөрөнгө байгаа эсэх талаар хуульд заасан журмаар мэдээлэл олж авах, төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгө болон биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, албадан барьцаалах, хураах, худалдан борлуулах

2. Төлбөр төлөгчөөс эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах, өртэй этгээдийн бүртгэлд бүртгэх

3. Төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийлгүүлэх

4. Төлбөр төлөгчийн бусдад байгаа өмч хөрөнгөөс хуульд заасан журмын дагуу төлбөр гаргуулах

5. Шийдвэрт нэр заасан тодорхой эд хөрөнгийг төлбөр төлөгчөөс гаргуулж төлбөр авагчид шилжүүлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх

6. Хуульд заасан бусад үйл ажиллагаа зэрэг болно.

Шүүхийн шийдвэр бүрэн бодитой биелэгдэх болоод төлбөр авагчийн шаардлагыг хангах гол үзүүлэлт бол төлбөр төлөгчийн төлбөрийн чадвар юм. Шийдвэр гүйцэтгэгч нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд шаардлагатай ажиллагаануудыг хийсэн боловч төлбөр авагчийн шаардлага хангагдахгүй байх тохиолдол нь олон байдаг. Үүний нэг бол төлбөр төлөгч нь олдохгүй байх явдал юм. Ийм тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу төлбөр төлөгч болон түүний эд хөрөнгийг эрэн сурвалжлах чиглэлээр дараах ажиллагааг явуулдаг. Үүнд:

1. Төлбөр төлөгчийн хаяг тодорхойгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч нь иргэний бүртгэл мэдээллийн, татварын, зохих нутгийн захиргааны болон холбогдох бусад байгууллагаас лавлагаа авах, тухайн хүний төрөл, садангийн хүнийг дуудан ирүүлж тайлбар гаргуулах замаар хаягийг тодруулах

2. Дээр дурдсан бүхий л ажиллагаануудыг явуулсан боловч олдохгүй байгаа төлбөр төлөгч иргэн, төлбөр төлөгч хуулийн этгээдийг буюу төлбөр төлөгчийн эд хөрөнгийг төлбөр авагч эрэн сурвалжилж болно гэжээ.

Гэхдээ “эрэн сурвалжилж болно” гэдгийг дурдсан бүх ажиллагаанууд хийгдсэн боловч олдохгүй байгаа төлбөр төлөгч болон түүний эд хөрөнгийн байгаа газрыг илрүүлэхийн тулд төлбөр авагч өөрийн санаачлагаар, хувийн журмаар сураглаж, хайхыг хэлнэ гэж Улсын Дээд Шүүхээс тайлбарласан байдаг. Ингэж эрэн сурвалжлахдаа төлбөр авагч нь шийдвэр гүйцэтгэх болон цагдаагийн байгууллагын

бүрэн эрхэд хамаарах ажиллагааг явуулж болдоггүй онцлогтой.

Төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах, олж тогтооход өөрт байгаа мэдээлэл өгөх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад саад учруулж байгаа, эсхүл шийдвэр гүйцэтгэгчийн амь бие, эрүүл мэндэд заналхийлсэн бол цагдаагийн байгууллага туслалцаа үзүүлж болохыг хуульчилсан байна.

Өнөөдрийн байдлаар төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах ажиллагааг дараах хууль тогтоомжуудаар зохицуулж байна.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /А/
- Тахарын албаны тухай хууль /Б/
- Цагдаагийн албаны тухай хууль /В/
- Гүйцэтгэх ажлын тухай хууль /Г/
- Эдгээр хуульд нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актууд зэрэг болно.

А. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

Төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах асуудлыг шийдвэр гүйцэтгэгч өөрөө бие даан явуулдаг байсан бол 2010 оны 8 дугаар сараас эхлэн Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны дэргэд "Эрэн сурвалжлах шуурхай хэсэг" байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Хэсгийн ажиллах журамд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад дараах зүйлийг эрэн сурвалжлахтай холбогдсон харилцааг зохицуулна гэжээ. Үүнд:

- Иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр /тогтоол/ биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн төлбөр төлөгч, ялтан
- Баривчлах байрнаас оргосон сэжигтэн /цаашид "эрэн сурвалжлах хүн" гэх/
- Төлбөр төлөгчийн нуун дарагдуулсан хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө /цаашид "эрэн сурвалжлах эд зүйл" гэх/
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд шийдвэр гүйцэтгэгчийг гэнэтийн халдлагаас хамгаалах зэргийг дурджээ.

Төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах ажлын хэлбэр нь нийслэл болон орон нутгийн гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулагддаг. Эрэн сурвалжлах хэсгийн тодорхой нутаг дэвсгэрт явуулж байгаа ажиллагааг орон нутгийн эрэн сурвалжлах ажиллагаа гэдэг.

Б.Тахарын албаны тухай хууль

2013 оны 7 дугаар сарын 5-ны өдөр батлагдсан "Тахарын албаны тухай" хуулийн 23 дугаар зүйлд "Оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах тухай" эрх зүйн зохицуулалт тусгагджээ. Энэхүү зохицуулалт нь зөвхөн эрүүгийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх болон шүүхийн шийтгэх тогтоол гарсан төлбөртэй ялтан дээр л яригдах заалтууд юм. Энэхүү хууль нь 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх юм. Эрэн сурвалжлах ажиллагаа нь хуульд дараах байдлаар тусгалаа олжээ. Үүнд:

1. Тахарын алба шүүгч, улсын яллагч, гэрч, хохирогчийг хамгаалах зорилгоор оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.
2. Эрэн сурвалжлах ажиллагаа зохион байгуулах үед нийслэл, аймаг, сум, дүүргийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хотын захирагч, цагдаа, хорих, батлан хамгаалах, хил хамгаалах алба зэрэг байгууллагаас хүн хүч, зэвсэг, автомашин, шатахуун, техник хэрэгсэл, түр байрлах байр шаардан гаргуулах, дайчлан ашиглаж болно.
3. Тахарын албаны алба хаагч нь эрэн сурвалжлах ажиллагааны үед боомт, хилийн зурвас, гааль, төрийн тусгай хамгаалалтын бүсэд нэвтрэн ажиллах эрхтэй.
4. Ялтан оргон зайлсан тохиолдолд тухайн хорих байгууллага Тахарын албанд нэн даруй мэдэгдэж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх үүрэгтэй.

В. Цагдаагийн албаны тухай хууль

Шинэчилэн батлагдсан Цагдаагийн албаны тухай хуульд "Эрх бүхий байгууллага, албан

тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжлах" үүрэгтэй болохыг хуульчилжээ. Энэхүү заалт нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах заалттай харилцан уялдаатай байгаа явдал юм. Төлбөртэй этгээдийг эрэн сурвалжлах чиглэлээр цагдаагийн байгууллага дараах үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

1. Гэмт хэрэгтэй тэмцэх - Гэмт хэрэг, зөрчил гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах;
2. Захиргааны хяналт - Эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжлах;
3. Үйл ажиллагаандаа тоо бүртгэл хөтлөх - Эрэн сурвалжлагдаж байгаа хүний талаар бүртгэл хөтлөх зэрэг болно.

Г. Гүйцэтгэх ажлын тухай хууль

Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу эрэн сурвалжлах ажиллагааг явуулахад дараах ойлголтууд хамаарагддаг. Үүнд:

1. "Эрэн сурвалжлах ажил" гэж Тагнуулын байгууллага цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллагад Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хууль тогтоомжоор харьяалуулсан эрүүгийн хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр хийх нууц ажиллагааг хэлнэ.

2. Цагдаагийн байгууллага нь ... түүнчлэн сураггүй алга болсон, нас барсанд тооцогдсон хүн, оргосон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон прокурор, шүүхээс даалгасан бусад хүнийг эрэн сурвалжлах, алдагдсан галт зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, мансууруулах, хордуулах бодис, түүх соёлын дурсгалт болон бусад үнэт зүйлийг эрж олох;

3. *Тахарын алба оргосон яллагдагч, ялтныг* эрэн сурвалжлах, *шүүх, шүүгч, гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх зэрэг болно. Төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах ажиллагааг дараах үндэслэл байгаа тохиолдолд явуулдаг. Үүнд:*

- *Иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн төлбөр төлөгч, сэжигтэн, ялтан болон төлбөр төлөгчийн нуун дарагдуулсан хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг эрэн сурвалжлуулах тухай албан бичиг*
- *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон газар, хэлтэс, түүний эрх бүхий албан хаагчаас ирүүлсэн хүн, эд зүйлийг эрэн сурвалжлуулах тухай албан бичиг*
- *Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн гомдол, санал хүсэлт*
- *Албаны дэд даргын өгсөн үүрэг даалгавар, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нараас гаргасан хүсэлт зэргийг үндэслэнэ.*

Дараах тохиолдолд эрэн сурвалжлах ажиллагааг зогсооож хариуцсан албан хаагч, хэлтэс, газар, албанд нэн даруй мэдэгдэнэ.

- ❖ *Эрэн сурвалжилж байсан хүн, эд зүйлийг олж тогтоосон*
- ❖ *Эрэн сурвалжлагдаж байсан хүн нас барсан нь тогтоогдсон*
- ❖ *Цаашид эрэн сурвалжлах шаардлагагүй нөхцөл байдал бий болсон зэрэг болно.*

Төлбөр төлөгчийг эрэн сурвалжлах ажиллагааны талаарх мэдээ судалгааг хүснэгтээр үзүүлбэл:

Он	*Өмнөх оны үлдэгдэл*	*Шинээр ирсэн*	*ШГА-нд ирүүлсэн*	*Хаяг тогтоосон*	*Хүлээгдэн өгсөн*	*Үлдэгдэл*	*Биелэлт хувиар*
2011	*117*	*237*	*91*	*269*	*159*	*195*	*44,9%*
2012	*160*	*328*	*105*	*247*	*246*	*242*	*50,4%*
2013.10	*209*	*313*	*149*	*366*	*293*	*229*	*56,1%*

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага олдохгүй байгаа төлбөр төлөгчийг цагдаагийн байгууллагаар эрэн сурвалжлуулах ажиллагааг явуулахын тулд шүүгчийн захирамж гаргуулан ажилладаг.

Эрэн сурвалжлуулах тухай шүүгчийн захирамж гарсан байдлыг авч үзвэл:





Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мөнгөн дүнгийн бодит биелэлт /2010.01.01 – 2013.10.01/



№	2010 он			2011 он			2012 он		
Үзүүлэлт	Биелэх ёстой	Бодитой биелсэн	Биелэлт /хувиар/	Биелэх ёстой	Бодитой биелсэн	Биелэлт /хувиар/	Биелэх ёстой	Бодитой биелсэн	Биелэлт /хувиар/
г/х	22391	10002	44,7	20007	9171	45,8	19674	9752	49,6
м/д	173,941,036	65,204,454	37,5	197,657,385	55,314,221	28,0	220,347,197	68,561,816	31,1
	41,1			**36,9**			**40,3**		

№	2013 он			2010 – 2013 онуудын нийт үзүүлэлт		
г/х	21779	10646	48,9	83,851	39,571	47,2
м/д	713,214,777	415,329,406	58,2	1,305,160,395	604,409,897	46,3
	53,6			**46,8**		



Б.ЗАМБАГА

Өвөрхангай аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэр гүйцэтгэгч

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАТАЛГАА

Төрийн эрх мэдлийн нэгэн тулгуур нь шүүх эрх мэдэл бөгөөд энэхүү эрх мэдлийн хэрэгжилтийн биелэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар Тогтоол гүйцэтгэх газар, Шийдвэр гүйцэтгэх газраараа дамжуулан төрийн зорилт чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Шүүхийн шийдвэр[30]-ийг биелүүлэх хүнд, нэн хариуцлагатай ажлыг төр ард түмнийхээ өмнө өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын чухал бүрэлдэхүүн хэсэг болох төр нийгмийн байгуулал, иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх чухал үүргийг саадгүй биелүүлж ирсэн.

Улс орны нийгмийн хөгжилтэй уялдан төрийн албан хаагчдад итгэж, хүндэтгэлтэй хандаж ирсэн нийгмийн сэтгэл зүй өөрчлөгдсөн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, албадын орон байр, материал-техникийн хувьд төдийлөнбэхжээгүй, шийдвэр гүйцэтгэх алба мэргэшлийн болж хөгжиж чадахгүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн үйлдэл, шийдвэрийг эсэргүүцэх, улмаар амь нас, эрүүл мэндийг хохироох явдал өссөн, шийдвэр гүйцэтгэгчийн мэргэжлийн үйл ажиллагааг ойлгодоггүй нь тэдний аюулгүй байдал, эрх зүйн хамгаалал, баталгаа бүрдээгүйтэй холбоотой.

Иймд шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг нэгдсэн байдлаар зохицуулах, албан хаагчийн хариуцлага, ёс зүйн болон сахилгын дүрмийг олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах зарчмын шинэлэг зохицуулалт бий болгох, албан хаагчийн үйл ажиллагаа байгууллагаас бус хуулиас илүү хамааралтай байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлага та бидний өмнө тулгаад байна.

Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна[31] хэмээн төр хүлээх үүрэгээ Үндсэн хуулиндаа тунхаглаж өгсөн.

Энэхүү үүргийн хэрэгжүүлэх төрийн албан хаагчийн эрх зүйн баталгааг хэрхэн хангахыг тус хуульд Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагч Монгол Улсын иргэн байх бөгөөд Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж ард түмнийхээ тусын тулд, иргэний ёсоор төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана[32], төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно[33] хэмээн зааж өгсөн.

Үндсэн Хуулийн үзэл баримтлалд тулгуурлан төрийн албанд холбогдох

[30] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар., 183 дугаар зүйл, 183.1 дэх хэсэг., УБ 2008., 429 дэх тал.,

[31] Монгол Улсын Үндсэн хууль 1992., 19 дүгээр зүйл., 19.1 дэх хэсэг

[32] Монгол Улсын Үндсэн хууль 1992., 46 дугаар зүйл., 46.2 дах хэсэг

[33] Монгол Улсын Үндсэн хууль 1992., 46 дугаар зүйл., 46.3 дэх хэсэг

нийгмийн харилцааг дагнан зохицуулсан Монгол Улсын хууль 1994 онд батлагдан гарч, 1995 онд мөрдөгдөж эхэлсэн. Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын их хурал 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр хэлэлцэн, боловсронгуй болгон нэмэлт хийж, баталсан нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байна. Дээрхи хугацаанд Төрийн албаны хуульд олон удаагийн нэмэлт өөрчилөлт орсны нэг томоохон хэсэг нь УИХ-ын хэлэлцэн баталсан 2008-н оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуулийн өөрчилөлт гэж хэлж болно.

Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулгын гол онцлог нь нийгмийн хөгжлийн тухайн үеийн ололт, эрх зүйн практик хэрэглээ, хууль зүйн шинжлэх ухааны төлөвшлийн хүрсэн түвшинд тулгуурлан шинэтгэлийн үр дүн байсан бол 2008 оны нэмэлт, өөрчлөлт нь төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангах, төрийн жинхэнэ алба, албан хаагчийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, төрийн жинхэнэ албан хаагч улс төржихгүй, төвийг сахиж, зөвхөн төр, засагтаа үйлчилж, ард түмний тусын тулд ажиллах, төрийн албаны төв байгууллагын эрх хэмжээг өргөтгөх зэрэг цогц арга хэмжээг тусган хэрэгжүүлснээрээ бусад нэмэлт өөрчилөлтөөс ялгагдах юм.

Төрийн албыг тодорхойлохдоо "Төрийн зорилт чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ"[34].

Төрийн албан тушаалыг[35] төрийн улс төрийн албан тушаал, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаал хэмээн ангилдаг.

Төрийн аль ч албан хаагчийн эрх зүйн байдлын онцлог нь төрийн албан хаагчаа төрийн зорилт, чиг үүрэг, бүрэн эрхээ биелүүлэн хэрэгжүүлэх өвөрмөц чанартай нөхцөлдөнө. Жишээлбэл цэргийн ба иргэний алба, татварын алба, дипломат алба, салбарын захиргааны үйл ажиллагаа зэрэг төрийн албаны янз бүрийн төрөл, тусгай шинжээр тодорхойлон авч үзэж болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг зохицуулсан анхны хуулийг 1994-н онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль нэртэйгээр батлан гаргасан. 1996 онд хэд хэд хуулийг нэгтгэж "Монгол Улсын Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль" болгон нэгтгэн батлаж эрх зүйн нэгдсэн орчинг бүрдүүлсэн. Тус хууль 2002 онд эрх зүйн шинэчлэлийн хүрээнд шинэчлэн найруулагдаж одоо мөрдөгдөж байгаа хэдий ч анх батлагдсан хуулийн зохицуулалт хэвээр үйлчилэж байгаа нь шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн баталгааг бүрэн хангах эрх зүйн үндэс болж чадахгүй байна.

Иймд иргэний хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэр болон эрүүгийн хэргийн хорихоос өөр төрлийн ялын биелэлтийг хангах, хуульд заасан тохиолдолд шүүхээр баталгаажуулсан бусад байгууллагын шийдвэрийг гүйцэтгэх эрх бүхий албан тушаалтан нь шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн баталгааг төгөлдөржүүлэх асуудал чухал байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нь хууль зүйн дээд боловсролтой, ял шийтгэлгүй, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтаар тэнцсэн Монгол Улсын иргэн байна хэмээн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсэгт заасан бөгөөд энэхүү

[34] Төрийн албаны тухай хууль., 2002., 3 дугаар зүйл., 3.1 дэх хэсэг
[35] Төрийн албаны тухай хууль., 2002., 5 дугаар зүйл.,

тодорхойлолтоор нь авч үзвэл Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дах хэсэгт зааснаар төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч албан тушаалтан, төрийн төлөөлөгч юм.

Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн баталгааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар тусгайлан зохицуулсан бөгөөд хорих байгууллагын албан хаагчийн эрх зүйн байдалтай төстэй баталгаажуулсан хэдий ч дараах баталгааг эдлэхгүй байхаар заасан. Үүнд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.2. дахь хэсэгт зааснаар

- Хорих байгууллагын албан хаагчид үндсэн цалингаас гадна, хоригдолтой ажилласны,
- төрийн алба хаасан хугацааны,
- онцгой нөхцлийн болон тусгай албаны,
- цэргийн цол, зэрэг дэвийн нэмэгдэл олгох ба нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно" гэж заасан.

Эдгээр эдлүүлэхгүй байхаар заасан баталгааг шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид дараах үндэслэлээр хорих байгууллагын албан хаагийн нэгэн адил олгох үндэслэлтэй юм.

✓ Шийдвэр гүйцэтгэгч хорихоос өөр төрлийн 4 төрлийн ялыг эдлүүлдэг,

✓ Шүүхийн шийдвэр биелүүлэх албадан ажиллагаа бүр онцгой нөхцөл байдалд явагддаг. Энэ төлбөр төлөгч иргэн, байгууллага албан тушаалтан шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааг эсэргүүцэх, бие, оюулгүй байдалд халдах тохиолдолд их байдаг нь 2013 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн анхдугаар нэгдсэн зөвөлгөөний үед авсан судалгаагааны үр дүнгээр тодорхойлогдсон.

✓ Монгол Улсын хэмжээнд нийт 205 шийдвэр гүйцэтгэгч, 42 ахлах гүйцэтгэгч ажиллаж байгаагаас 72 гүйцэтгэгч, 7 ахлах гүйцэтгэгч нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд, 123 гүйцэтгэгч, 35 ахлах шийдвэр гүйцэтгэгч хөдөө орон нутагт ажиллаж байна. Орон нутагт ажиллаж байгаа гүйцэтгэгч нарт тухайн бүс нутгийн амжиргааны түвшин, байгаль цаг уурын нөхцөл зэрэг орчны нөлөөлөөр нь ангилан төрөөс тэтгэлэг олгох нь зүйтэй.

✓ Хорих байгууллагын ажилтанд ажилласан хугацааг тооцохдоо 1 жил 2 сараас 1 жил 3 сарын нэмэгдэл тооцон олгодог. Шийдвэр гүйцэтгэгчийн хяналтын дор хорихоос өөр төрлийн ялыг эдлүүлж, онцгой нөхцөлд ажилладагаараа дээрхи нэгмэгдэлд хамрагдах үндэслэлтэй.

Хуулинд эдлүүлэхгүй байхаар заасан баталгааг гүйцэтгэж байгаа ажил, үүрэг, нөхцөл байдалтай нь харьцуулан үзхэд наад зах нь хорих байгууллагын албан хаагчийн нэгэн баталгаагаар хангагдахаар байна.

Шийдэр гүйцэтгэгч буюу төрийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар нарийвчилан зохицуулж, гүйцэтгэх үүрэг, эдлэх эрх, эрх зүйн байдлын хязгаарлалт ба хориглолт, ажиллах нөхцөл баталгааг нарийвчлан зохицуулж хамгаалалт тогтоох шаардлагатай байгааг шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн баталгааг зохицуулсан хууль тогтоомжоос харагдаж байна.



Ж.УУГАНЧИМЭГ

Хууль сахиулахын их сургуулийн Ерөнхий эрдмийн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн ахлах багш

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР КЛИНИК СУРГАЛТ ЯВУУЛАХ ОНЦЛОГ, АЧ ХОЛБОГДОЛ

Хуульч хүний зайлшгүй эзэмшвэл зохих ур чадварыг оюутнууд сургууль төгссөний дараа, ажилд орсон хойно, практик дээр ажиллаж туршлага суух явцад олж авна хэмээн манай ихэнхи их, дээд сургуулиуд үзэж ирсэн. Хуульчдыг бэлтгэж байгаа их, дээд сургуулиудын тогтолцоо, зорилго, сургалтын төлөвлөгөө, агуулгыг үзэхэд дээрхи чиг хандлагыг тодорхой олж харж болно. Үүний улмаас эрх зүйч мэргэжлээр төгсөгчид нь хүмүүст хууль эрх зүйн зөвлөлгөө өгөх, эрх зүйн акт, баримт бичгийн эхийг бэлтгэх, боловсруулах, шүүх хуралдаанд оролцох, мэтгэлцэх, иргэний хэрэгт иргэд, хуулийн этгээдийг төлөөлөн оролцох зэрэг үйл ажиллагаанд мэргэжлийн алдаа гаргах, дутуу дулимаг хандах, дадлага ур чадвар дутагдах тал олонтаа гардаг.

Гэтэл энэхүү ур чадвар, дадал, түүний тодорхой хэсгийг суралцах хугацааны туршид онолын сургалттай хослуулан клиник сургалтын хүрээнд суралцагч бүрт эзэмшүүлж, төлөвшүүлж болно.

Ялангуяа иргэний эрх зүйн чиглэллээр оюутанд олгох онолын мэдлэгийг гүнзгийрүүлэн бататгах, иргэний процесс ажиллагаанд оролцох, хууль зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлэх чадвартай болгоход клиник сургалтын гүйцэтгэх үүрэг маш чухал юм.

Ийм учраас клиник сургалт дахь иргэний эрх зүйн хичээлийг хөтлөн явуулах гол онцлог нь хуульчдын ажил үүргийг хийж гүйцэтгэх практик дадал, ур чадварыг олж авахад нь оюутанд туслахад оршино.

Хуульчийн мэргэжлийн ур чадварт:

- Аливаа асуудлыг шийдвэрлэх бүхий л боломж хувилбарыг бүхий л боломж, хувилбаруудыг урьдчилан харж чаддаг байх
- Бусдыг сонсож, ярилцаж мэдээлэл авч чаддаг байх
- Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах, хуулийг хэрэглэх ур чадвар эзэмшсэн байх
- Сэтгэн бодох, харьцуулан үзэх, хэргийн материалыг шинжлэн судлаж, үнэлэлт дүгнэлт өгөх
- Илтгэх
- Бусдыг итгүүлэх ур чадварыг эзэмшсэн байх гэх мэт олон зүйлийг хамааруулан үздэг.

Иргэний эрх зүйн чиглэлээр клиник сургалтыг явуулах талаар түүний онцлогыг авч үзэхээс өмнө ер нь хууль зүйн клиник сургалтын талаар эхлэн авч үзэх шаардлагатай.

Хуульзүйн дээд боловсрол нь боловсролын ерөнхий тогтолцооны хэсэг бөгөөд **хуульзүйн стандартад зааснаар онолын мэдлэг,практик дадлыг тодорхой хэмжээгээр тэнцвэржүүлэн сургах сургалт** юм.

Хууль зүйн клиник сургалт нь Хууль зүйн дээд боловсролын салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд онолын мэдлэгийг оюутан илүү өөрийн болгож эзэмшүүлэхэд тусладаг төдийгүй оюутныг нийгмийн социаль амьдралд бэлтгэх,дасан зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл хуульзүйн клиник боловсрол нь сургалтын төлөвлөгөөнд тулгуурлан үйлчлүүлэгчтэй ажиллах замаар хуульчийн ажлын ур чадварт оюутныг сургах зорилготой СУРГАЛТЫН ХЭЛБЭР юм.

Хуульзүйн клиникийн зохион байгуулалтын хэлбэр

1. Их сургууль/тэнхмим/-ийн бүтцэд байгуулсан ХЗКТ

2. Хэд хэдэн их сургуулийн оролцоотой байгуулсан их сургууль дундын ХЗКТ
3. Ашгийн бус хуулийн этгээдийн дэргэд байгуулсан ХЗКТ
4. Төрийн байгууллагын дэргэд байгуулсан ХЗКТ
5. Бусад

Хуульзүйн клиник төвийн үйл ажиллагааны чиглэл

- Нийтийн эрхзүйн чиглэлийн хуульзүйн клиник
- Тусгайлсан чиглэлийн хуульзүйн клиник
- Хязгаарлагдмал чиглэлийн хуульзүйн клиник

Хууль зүйн клиник боловсролын зорилт нь танхимд олж авсан онолын мэдлэгээ практикт хэрэглэхэд оюутанд гарч буй хийдлийг шийдвэрлэх явдал юм. Энэхүү зорилт нь ч иргэний эрх зүйн чиглэлээр клиник явуулахад мөн дэвшигдэн гарч ирж байгаа юм.

Хуулийг мэднэ гэдэг нь түүний үг үсгийг бус , харин түүний учир холбогдлыг нь мэднэ гэсэн үг юм. Тиймээс хууль, түүний дотор иргэний хууль тогтоомжийг хэрэглэж сурах, хуулийн зүйл заалтыг зөв ойлгож дүн шинжилгээ хийх, хэрэг маргааныг шийдвэрлэхэд тэдгээрийг бүрэн дүүрэн ашиглах чадварыг эзэмшүүлэх нь Иргэний эрх зүйн хичээлийн нэгэн гол зорилго болон тавигддаг. Энэхүү зорилгыг биелүүлэхэд тухайн чиглэлээр клиник сургалтыг зохион байгуулах нь чухал ач холбогдолтой юм.

Иргэний эрх зүйн чиглэлээр клиник сургалтыг дараахь хэлбэрээр зохион байгуулж явуулж болно.

1. Иргэний хууль тогтоомжийг хэрэглэх
2. Нотлох баримтыг бүрдүүлэх
3. Хууль зүйн зөвлөгөө өгөх
4. Иргэний шүүн таслах ажиллагаанд оролцуулах
5. Эрх зүйн бичиг баримтын эхийг бэлтгэх

Иргэний хэрэг маргааныг шийдвэрлэх шатанд суралцагсад зохигчдийг төлөөлөх, холбогдох нотлох баримтуудыг бүрдүүлэх, цуглуулах, мөн үйлчлүүлж байгаа иргэдтэй харилцах тэдгээрт хууль зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх, өмгөөлөх зэрэг янз бүрийн ажиллагаанд оролцох иргэний төрөл бүрийн хэрэгт биечлэн оролцох зэрэг нь тухайн чиглэлээр явуулж байгаа клиник сургалтын нэг давуу тал юм. Ийнхүү оролцсоноор оюутаны хувьд зохих дадлага туршлага, ур чадвар суух, олж авсан эрх зүйн мэдлэгээ бататгах, шинэ мэдлэг олж авах ач холбогдолтой.

Хууль зүйн клиник сургалтын төвд хандсан үйлчлүүлэгчдийг хүлээн авах, хэргийн бүртгэл хөтлөх, үйлчлүүлэгчээс тавьж буй асуудал, хүсэлтийг судлах шийдвэрлэх арга замыг хайх, хууль зүйн зөвлөлгөө өгөх, эрх бүхий байгууллагад хандах гэх мэт өмгөөлөгчийн үйл ажиллагааг оюутнууд хэрэгжүүлэх нь тэдэнд хуульчийн дадал, хэвшил, зохих чадвар бүрдүүлэхэд онцгой ур нөлөөтэй.

Хууль зүйн клиник сургалтын иргэний эрх зүйн хичээлийг тодорхой зорилго чиглэлтэй бие даасан хэд хэдэн хэсэгт хуваан үзэж болно. тухайлбал:

a) Лекц
b) Семинар дасгал
c) Загварчлал
d) Дүрд тоглох
e) Үр дүнг нь тодорхойлох гэх мэт.....

Клиник сургалтанд хичээлийг лекцийн хэлбэрээр зайлшгүй зохион байгуулах шаардлагатай. Лекцийн зорилго нь оюутан хуульчийн ур чадвар, дадал дүй эзэмшихэд шаардлагатай бүхий л онолын болон практик мэдээллийг өгөхөд оршино.

Танхимын сургалтын өөр нэг хэлбэр нь дасгал, семинарын хичээл байдаг. Энэхүү хичээлийг тухайн клиникийн мэдээллийн бааз суурь, оюутны хөтөлж байгаа иргэний хэрэг маргаанд тулгуурлаж явуулах нь илүү үр дүнтэй, сонирхолтой болдог. Түүнчлэн удирдагч багш нь сэдэв тус бүрээр бодлого,

дасгал, бодит тохиолдол, кейс дээр оюутнуудыг багт хувааж ажиллуулах, өөр хооронд нь мэтгэлцүүлэх, асуудал хэлэлцүүлэх аргыг хэрэглэх боломжтой.

Иргэний хэргийг хянан хэлэлцээд шүүхээс гаргасан шийдвэр, тогтоол, захирамж, магадлал, түүнчлэн иргэд, хуулийн этгээдээс гаргасан иргэний нэхэмжлэл, эрх зүйн баримт бичгийг тарааж судлуулах, иргэний шүүх хуралдааны видео бичлэгийг үзүүлэх зэрэг нь Клиник сургалтын загварчлалын аргад хамаарна.

Иргэний хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн дүрд тоглуулах арга замаар иргэний хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагааг явуулах үйлчлүүлэгчид хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөлөх ур чадварыг оюутанд зохих хэмжээгээр эзэмшүүлэх боломжтой.

Эцэст нь дүгнэж авч үзвэл хууль зүйн клиник сургалт бол бодит үйлдлээр дамжуулан хуульчийн мэргэжлийн ур чадварыг эзэмшүүлэх, суралцагчийг аливаа асуудалд шурган оруулах, хийнгээ суралцах, ярилцангаа сурах зарчим дээр тулгуурласан сургалтын хамгийн оновчтой хэлбэр юм.



Г.НАРАНБАЯР

Дорноговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэр гүйцэтгэгч

ГЭР БҮЛИЙН ДУНДЫН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ.

Гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжил, уламжлал

Монголчууд газар нутагтаа төрөө үүсгэн байгуулж, хууль цаазыг зохиож ирсэн эртний сонгодог уламжлалтай хэмээн судлаачид нэг бус удаа тэмдэглэсэн нь бий. Эртний хууль цаазын сурвалж бичгүүдэд эрх зүйн салбараар нь системчлээгүй харин нэгэн цааз бичигт нэгтгэн бичиж зохицуулж байсан.

Гэр бүлийн харилцааг зохицуулсан бие даасан эрх зүйн акт байгаагүй нь гэр бүлийн эрх зүйгээр зохицуулах нийгмийн харилцаа байгаагүй гэсэн үг биш. Ийм харилцаа түүхийн аль ч үед байсан. Түүнийг төрийн цааз бичиг болон заншлын хэм хэмжээгээр давхар зохицуулж байсан нь илт юм.**Их засаг хууль**[36] бол Монголын феодалын нийгмийн харилцаа, төрт ёсны үеийн гол хууль бөгөөд эзэн Чингисийн үеэс зарлиг, тогтоол, ихэс дээдсийн үүрэг, даалгаврын хэлбэрээр гарч ирсэн хэм хэмжээнүүдийг нэгтгэн эмхтгэж төрийн гол хууль болгон тунхагласан байна. Энэ хуульд гэр бүлийн харилцаа тэр дундаа гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг хэрхэн зохицуулж байсныг тоймлон үзвэл: Олон эхнэртэй

[36] С.Жаалан- Аажав " Халх журам Монголд улсын хууль цаазын эртний дурсгалт бичиг", УБ, 1985, 15 тал

дасгал, бодит тохиолдол, кейс дээр оюутнуудыг багт хувааж ажиллуулах, өөр хооронд нь мэтгэлцүүлэх, асуудал хэлэлцүүлэх аргыг хэрэглэх боломжтой.

Иргэний хэргийг хянан хэлэлцээд шүүхээс гаргасан шийдвэр, тогтоол, захирамж, магадлал, түүнчлэн иргэд, хуулийн этгээдээс гаргасан иргэний нэхэмжлэл, эрх зүйн баримт бичгийг тарааж судлуулах, иргэний шүүх хуралдааны видео бичлэгийг үзүүлэх зэрэг нь Клиник сургалтын загварчлалын аргад хамаарна.

Иргэний хэргийн болон шүүх хуралдааны оролцогчийн дүрд тоглуулах арга замаар иргэний хэрэг маргааныг шийдвэрлэх ажиллагааг явуулах үйлчлүүлэгчид хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөлөх ур чадварыг оюутанд зохих хэмжээгээр эзэмшүүлэх боломжтой.

Эцэст нь дүгнэж авч үзвэл хууль зүйн клиник сургалт бол бодит үйлдлээр дамжуулан хуульчийн мэргэжлийн ур чадварыг эзэмшүүлэх, суралцагчийг аливаа асуудалд шурган оруулах, хийнгээ суралцах, ярилцангаа сурах зарчим дээр тулгуурласан сургалтын хамгийн оновчтой хэлбэр юм.



Г.НАРАНБАЯР

Дорноговь аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэр гүйцэтгэгч

ГЭР БҮЛИЙН ДУНДЫН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ.

Гэр бүлийн эрх зүйн зөхицуулалтын түүхэн хөгжил, уламжлал

Монголчууд газар нутагтаа төрөө үүсгэн байгуулж, хууль цаазыг зохиож ирсэн эртний сонгодог уламжлалтай хэмээн судлаачид нэг бус удаа тэмдэглэсэн нь бий. Эртний хууль цаазын сурвалж бичгүүдэд эрх зүйн салбараар нь системчлээгүй харин нэгэн цааз бичигт нэгтгэн бичиж зохицуулж байсан.

Гэр бүлийн харилцааг зохицуулсан бие даасан эрх зүйн акт байгаагүй нь гэр бүлийн эрх зүйгээр зохицуулах нийгмийн харилцаа байгаагүй гэсэн үг биш. Ийм харилцаа түүхийн аль ч үед байсан. Түүнийг төрийн цааз бичиг болон заншлын хэм хэмжээгээр давхар зохицуулж байсан нь илт юм.**Их засаг хууль**[36] бол Монголын феодалын нийгмийн харилцаа, төрт ёсны үеийн гол хууль бөгөөд эзэн Чингисийн үеэс зарлиг, тогтоол, ихэс дээдсийн үүрэг, даалгаврын хэлбэрээр гарч ирсэн хэм хэмжээнүүдийг нэгтгэн эмхтгэж төрийн гол хууль болгон тунхагласан байна. Энэ хуульд гэр бүлийн харилцаа тэр дундаа гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг хэрхэн зохицуулж байсныг тоймлон үзвэл: Олон эхнэртэй

[36] С.Жаалан- Аажав " Халх журам Монголд улсын хууль цаазын эртний дурсгалт бичиг", УБ. 1985, 15 тал

байхыг хүлээн зөвшөөрч, хэрэв олон эхнэртэй тохиолдолд тэдний дотроос анхны эхнэр нь бусдыгаа ахлана. Мөн түүнчлэн татвар эхнэрээс гарсан хүүхдэд гэр бүлийн эд хөрөнгөөс хувь өгч байсан.

Юань улсын хувьд гэр бүлийн харилцааг урьд оршин байсан Сүн, Алтан улсын хуулийн үзэл баримтлал хийгээд Хятадын зан заншлын уламжлалд тулгуурлан тогтоожээ.

Энд тэмдэглэснээр гэрлэгчид гэрлэлтийн гэрээ хийх ёстой бөгөөд гэрээ нь хүүгийн эцэг, хэрэв эцэг нь нас барсан бол эхээс зөвшөөрөл авч байж сая хүчин төгөлдөр болж гэрлэх эрхтэй байна.

Хэрэв гэрлэлтийн гэрээнд тогтоосон хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр гэрлэх ёслолоо хийгээгүй болон завхайрсан этгээдүүдийн хооронд байгуулсан гэрээ тус тус хүчингүй болно гэж заажээ.[37]

➢ **1640 оны Монгол – Ойрадын** хуулиар Монгол – Ойрадын ноёдын дундах эвдрэлийг зохицуулах, эрүү, иргэн, засаг захиргааны харилцааг зохицуулж байсан. Гэр бүлийн харилцааг хэрхэн зохицуулсан талаар цухас үзвэл: Энэ үед гэрлэлтийг дэмжиж байсан нь хуулийн зохицуулалтаас харагддаг бөгөөд энэ нь цэрэг эрчүүдийг бэлтгэхтэй холбоотой байсан болов уу. Тухайлбал 40 өрхөөс жил бүр 3 хөвгүүнийг гэрлүүлж байх, 10 хамжиж тэдгээрийг гэрлэхэд тусалж байх хэм хэмжээг хуульд тусгасан байна.

Халх журам бол Монголын өөрийн жинхэнэ ахуй амьдралаас ургуулан Монгол сэтгэлгээгээр зохиож эх орны тусгаар тогтнол, эдийн засаг, төрт ёс, шашин шүтлэг, зан заншлаа хуульчлан баталгаажуулж байсныг гэрчлэх эрх зүйн гайхамшигт баримт бичиг болно. Энэхүү түүхэн баримт бичигт гэр бүлийн талаар тусгасан байдлыг үзвэл: энэ хуульд заасан гэр бүлийн зохицуулалтыг харахад нь хүн нөхөрт гарахад нь хаад ноёдын охид нь өндөр инж, сүй бэлэгтэй, харин харцын охинд бол “ бага” байх зарчимтай байжээ.

Ноёд тавнангуудын охиныг гуйваас мөнгөн аяга, сувд, архи хүрвээс тооцно. Үгүй бөгөөс тооцохгүй. Бас харц хүн өөр зуураа сүйлэх аваас архи болоод хонины гэдэс дотор, эвэр туурай гүйцэд болбоос тооцох гэх зэргээр заасан нь гэрлэхэд эрэгтэй, эмэгтэй хоёрын бие биеэ хайрлах нь гол биш сүйд өгсөн эд хөрөнгө гэрлэх хэмжигдэхүүн болдог байсан.

Хүний жам ёсны эрхийн нэг өмчлөх эрхийн харилцааг мөн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Иргэний хуулийг 1926 онд батлан гаргасан[38]. уг хуулийн тавдугаар бүлэг нэг дүгээр анги “ Аливаа хөрөнгө хогшлын тухай”-д дундын өмчийн тухайд зохицуулж өгсөн.

Уг хуулийн 95 дугаар зүйлд “ Аливаа хүний хууль, дүрмийн ёсоор хураасан элдэв хөрөнгө хогшлыг түүний хувийн өмч хэмээвээс зохимой” гэж заасан ба уг хуульд хөрөнгийг хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө гэж зааглан заасан ба тэдгээрт хамаарах хөрөнгийг тусгаарлаж өгсөн.

1926 оны Иргэний хуульд дундын өмчийн талаар анх зохицуулж өгснөөр түүхэн ач холбогдолтой бөгөөд түүний зарим зүйл, заалт нь өнөөг хүртэл уламжлагдан ирсэн байна.

1952 оны Иргэний хуульд дундын өмчийн тухай “өмчлөх эрхийг нэг ба хамтын

[37] Монгол улсын түүх /дэд дэвтэр/, УБ, 2003, 109 тал

[38] З.Сүхбаатар, П.Оюундэлгэр, “Монгол Улсын Иргэний хуулиуд нэмэлт өөрчлөлтүүд”, УБ, 2002, 37 тал

бүхий хоёр бүюу хэд хэдэн хүн нийтээр эдэлж болно" гэж заажээ.

1960 онд шинэ Үндсэн хууль батлагдаж Монгол улсын Социалист чиг баримжаагаар хөгжүүлэх үндсийг тавьсан.

Үүнтэй холбоотойгоор БНМАУ-ын Ардын их хурлаас **1963 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шинэ Иргэний хууль** батласан билээ.Уг хуулийн хоёрдугаар хэсэг нэг дүгээр бүлэгт өмчийн эрхийн талаар хуульчилж өгсөн бөгөөд "... БНМАУ-ын иргэн бүхэн социалист өмчийг нүдний цөцгий мэт хайрлан хамгаалж, бүх талаар арвижүүлан бэхжүүлэх үүрэгтэй" гэж заасан байна.

Уг хуулийн 6 дугаар бүлэгт дундын өмчийн талаар тухайлан бүлэг болгон хуульчилсан бөгөөд 76 дугаар зүйлд "... эд хөрөнгө нь хоёр бүюу хэд хэдэн хөдөө аж ахуйн нэгдэл, хоршоолол, олон нийтийн бүсад байгууллагын хооронд мөн нэг бүюу бүюу хэд хэдэн хөдөө аж ахуйн нэгдэл, хоршоолол, олон нийтийн бүсад байгууллага ба улсын хооронд эсхүл хэд хэдэн иргэдийн хооронд дундын өмч байж болно" гэж хуульчилсан.

Мөн зүйлд дундын өмч нь хэсгээр өмчлөх дундын өмч, хамтран өмчлөх дундын өмч гэсэн хэлбэртэй байхаар зааж өгсөн.

Уг хуулийн 83 дугаар зүйлд"... гэр бүлийн эд хөрөнгө, хөдөө аж ахуйн нэгдлийн өрхийн эд хөрөнгө, нэгдэлжээгүй өрхийн эд хөрөнгө болон хуульд заасан бол бүсад эд хөрөнгө хамтран өмчлөх дундын өмчид байна"гэж заасан байна. Уг хуульд 1990 онд өөрчлөлт орсон бөгөөд уг өөрчлөлтөд хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д"...өмчлөгч нь өмчлөлийн зүйлээ хуулийн хүрээнд бүрэн мэдэж эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй" гэж заасан нь хүний өмчлөх эрхийг жинхэнэ утгаар нь хүлээн зөвшөөрсөн.

1994 оны шинэчлэгдэн найруулагдсан Иргэний хуулийн 65 дугаар зүйлд/ эд хөрөнгийг дундаа өмчлөх/ "... хоёр бүюу түүнээс дээш этгээд эд хөрөнгийг дундаа хэсгээр бүюу хамтран өмчилж болно", мөн "дундаа хамтран өмчлөх эрхийг гэр бүлийн гишүүдэд олгохоор", дундаа өмчилж байгаа этгээдүүд хамтран үүрэг хүлээх бөгөөд хөрөнгө тэнцүү хэмжээгээр өмчилнө" гэж зааж өгсөн.

Иргэний хуулийн 74 дүгээр зүйлд "... Монгол улсад хувийн, нийтийн өмч байна. Төр өмчийн бүх төрөл, хэлбэр чөлөөтэй хөгжих нөхцлийг бүрдүүлж тэдгээрийн халдашгүй байдлыг хуулиар хамгаална", мөн хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д "... хоёр бүюу түүнээс дээш этгээд эд хөрөнгийг дундаа хэсгээр бүюу хамтран өмчилж болох ба тэдгээр нь өмчлөх эрхээ бие даан хамгаалуулах эрхтэй" гэж тус тус заасан.

1994 оны Иргэний хуулийг ардчилсан Үндсэн хуультай нийцүүлэхийн тулд 2002 онд шинэчилэн найруулсан байна.

Гэр бүлийн дундын эд хөрөнгийн талаархи зарим орныхтой харьцуулан үзсэн байдал

БНХАУ-ын шинэчлэн нийтлэсэн Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд "БНХАУ-ын социалист нийгмийн өмч болон хувийн өмч" гэсэн хэлбэртэй байхаар заасан байна.

Монгол улсын Иргэний хуулийн 108 дугаар зүйл, БНХАУ-ын Иргэний хуулийн ерөнхий дүрмийн 78 дугаар зүйлд дундын өмчийн талаар тус тус зохицуулжээ.

Бүгд Найрамдах Япон Улсын Иргэний хуулийн 725-885[39] заалт нь гэр

[39] Япон Улсын Иргэний хууль, 2004

бүлийн эрх зүйтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

Дундын өмчийн хувьд хувийн болон хамтын гэсэн хоёр хэлбэртэй байна гэж заасан.

Япон улсын гэр бүлийн тухай хууль нь манай улсынхаас нилээд онцлогтой байх бөгөөд үүнийг товч үзвэл[40]: Эд хөрөнгийн хэлцэл хийх эрх зүйн чадамж нь 20 наснаас эхлэнэ.Гэр бүл болох эрх зүйн чадамж нь эрэгтэй 18 нас, эмэгтэй 16 наснаас үүснэ.Гэрлэгчдийн үндсэн эрх үүрэг нь хамтран амьдрах, хамтран хөдөлмөрлөх, харилцан бие биедээ туслалцаа үзүүлэх, гэр бүлийн үнэнч байдлыг хадгалах, нэг овогтой байх, эхнэр, нөхөр олсон орлого эд хөрөнгөөрөө гэр бүлд гарсан зардлыг тэнцүү хариуцах мөн гэр бүлийн тэжээн тэтгэх, гэрлэлтийн гэрээ, дундын эд хөрөнгөтэй холбоотой маргааныг шийдвэрлэдэг гэр бүлийн шүүх байдаг.

Мөн БНЯУ-ын Гэр бүлийн тухай хуулийн нэгэн өвөрмөц зохицуулалт нь сүйлэх журам тогтоосон явдал юм. Сүй тавихдаа гэрээ байгуулдаг. Сүйлэх нь харилцан бэлэг солилцох замаар явагдах бөгөөд сүйг сүмд үйлдэхгүй байж болно. Сүйн гэрээг зөрчсөн тохиолдолд гэрээний нэг тал нөгөө талаасаа гэрээг албадан биелүүлэхийг шаардаж болохгүй. Гэхдээ ийнхүү зөрчсөн нь нөгөө талд бодитой хохирол учруулсан тохиолдолд гэм буруутай тал нь нөгөө талд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

ОХУ гэрлэлтийн гэрээний эрх зүйн зохицуулатыг 1995 онд батласан гэр бүлийн хуульдаа суулгаж өгсөн[41].

Уг хуульд хэрхэн зохицуулсныг тоймлон үзүүлвэл: гэрлэлтийн гэрээ гэдэг нь гэр бүл болох гэж буй этгээдүүд эсхүл эхнэр нөхрийн гэр бүл болсон хойноо болон мөн гэрлэлтээ цуцлуулах тохиолдолд эд хөрөнгийн хувьд эдлэх эрх, хүлээх үүргийг харилцан тохиролцох замаар байгуулсан хэлэлцээ байна гэж заасан.

Гэр бүлийн дундын эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэж буй шүүхийн практик

2011 онд гэр бүлийн маргааныг шийдвэрлэсэн нийт хэргийн 81,8 хувийг гэрлэлт цуцлахтай холбоотой маргаан эзэлж байгаа нь 2008 оны тоон үзүүлэлттэй харьцуулахад 6,8 хувиар буюу нэг жилд 2,2 хувиар өсөж байгаа нь хүн бүрд гэр бүлийн баталгаа/ холбоо/ юунд оршиж байна вэ? гэсэн бодлыг өөрийн эрхгүй төрүүлэх буй за. Улсын хэмжээнд 1993 оноос хойш шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоог үзүүлэлтийг авч үзвэл[42]: Хүснэгт 1

Гэрлэлт цуцлахад хамгийн маргаантай гэрлэгчдийн хувьд тэр бүр амархан тохиролцоонд хүрч чаддаггүй асуудал бол гэр бүлийн эд хөрөнгөтэй холбоотой харилцаа байдаг.

Гэр бүлийн тухай хуулийн зорилт нь"... гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа..-г зохицуулахад оршино" гэж заажээ.

Гэвч гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг " Иргэний хуулиар зохицуулна" гэж Монгол улсын Гэр бүлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасан бөгөөд 2002 оны Монгол улсын Иргэний хуулиар бүхэлдээ буюу *есөн зүйлд* гэр бүлийн хөрөнгийн харилцааг зохицуулж байна.

---

[40] "Семейный кодекс РФ", М, 2005, глава

[41] www.maik.ru

[42] Улсын дээд шүүхийн судалгааны төвийн судалгаа, 2003-2012 оны эхний хагас

Энэ нь Гэр бүлийн тухай хууль зорилтоо бүрэн биелүүлж чадахгүй байгаа гэдгийг харуулж байна.

2011 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс 2012 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл шийдвэрлэсэн 15610[43] иргэний хэргийн 1833 буюу 11,7 хувь нь гэрлэлт цуцлахтай холбоотой маргаан байна.

Гэрлэлт цуцлахдаа хамтран өмчлөх дундын эд хөрөнгө болон хуваарьт эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэсэн нь тодорхой бус байна.

Энэ бүгдээс дүгнэлт хийхэд гэр бүлийн дундын эд хөрөнгийн талаар эрт дээр үеэс хуульчлан ирсэн боловч гэр бүлийн дундын эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн судалгаа байхгүй байгаа нь ихэвчлэн зан заншлын хэм хэмжээгээр зохицуулагддаг харилцаа болох нь харагдаж байна.

Өнөөгийн нийгмийн хөгжлийн түвшинг дагаад гэр бүлийн дундын эд хөрөнгийн зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага урган гарч байгаа тул цаашид энэ сэдвээр илүү их судалж эрх зүйн зохицуулалтыг төгөлдөржүүлэх тал дээр хувь нэмрээ оруулахаар ажиллаж байна.

[43] Улсын дээд шүүхийн судалгааны төвөөс авсан шүүхийн шийдвэрүүд

Хүснэгт 1

№	Он	Нийт шийдвэрлэсэн Иргэний хэрэг	Нийт шийдвэрлэсэн гэр бүлийн маргаан	Үүнээс			
				гэрлэлт цуцласан	Эцэг, эх байх эрхийг хассан	Хүүхдийн тэтгэлэг гаргуулах	Тэтгэлэг тогтоосон хүүхдийн тоо
1	1993	14864	2782				
2	1994	15734	2101				
3	1995	18939	1996				
4	1996	26437	2504				
5	1997	26936	2410				
6	1998	28107	2485	1637	1		1427
7	1999	28039	2191	1425	9		709
8	2000	21717	2192	1517	8		899
9	2001	23252	2412	1657	7		1371
10	2002	24100	2630	1799	2		1089
11	2003	23407	2777	1890	7	423	1556
12	2004	23290	2939	2004	3	442	1270
13	2005	24492	2955	2094	3	397	1437
14	2006	27469	2989	2237	12	342	1308
15	2007	30699	3544	1323	4	189	736
16	2008	24480	3629	2703	12	436	1213
17	2009	35822	4294	3295	16	414	1069
18	2010	35787	4732	3852	6	354	2079
19	2011	30368	4449	3642	7	364	1932
20	**2012 оны хагас**		**1833**	**1487**	**3**	**154**	**366**



Н.АНАР
Хорих 409 дүгээр ангийн тоо бүртгэлийн байцаагч, дэслэгч

АВИЛГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ЗҮЙН ТЕХНИКИЙН АСПЕКТААР ХУУЛЬД ХИЙСЭН АНАЛИЗ

Оршил

Сэдвийн шалтгаан: Нийгмийн харилцааг журамлан зохицуулахад шийдвэрлэх гол нөхцөл нь угтаа эрх зүйн хэм хэмжээий техник-хууль зүйн төгс төгөлдөр[44] байдал юм. Хүмүүс хоорондын харилцааны дэг журам, тогтовортой байдлыг хангах нь хуулийн болоод эрх зүйн цэгцтэй, тогтвортой, ойлгомжтой байдлаас ихээхэн шалтгаалдаг. Энэ цэгцтэй байдал нь хууль зүйн техник, түүний элементүүдээс хамаардаг байна.

Энэ орон нь сүүлийн үед хуулийн хэл найруулгын асуудлыг анхаарч үзэхгүйгээс гадна, өөр бусад хууль хоорондын шүтэлцээг анхаарч үзэхгүй байгаа билээ. Үүнээс болж эргээд хууль тогтоомжийн хүчийг сулруулж, түүний хэрэгжилтэнд саад учруулж байгаа болно. Дээрх нөхцөл нь "***Авилгалын эсрэг хууль***" болоод түүнийг зохицуулсан бусад хуульд ч хамааралтай гэдэг үүднээс энэхүү сэдвийг сонгон судалсан болно.

Судалгааны зорилго, зорилт: Илтгэгч миний бие авилгалын эргэн тойрондох асуудлыг бус харин түүнийг зохицуулсан нарийвчилсан хууль тогтоомжийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэдэг хууль тогтоомжийн хэрэгжилтэнд нь анхаарлаа хандуулсан болно. Тэр ч үүднээс ***Авилгалын эсрэг хууль***-д дүн шинжилгээ хийж, түүнийг зохицуулсан бусад хуулийн харилцааг тогтоож, түүнийг боловсронгуй болгох арга замыг олоход гол нь оршино. Зорилгын хүрээнд зорилт нь:

Судалгааны арга, арга зүй. Судлгааны аргын хувьд **норматив,** болон **гервинетик** аргыг хэрэглэсэн болон.

Судалгааны ажлын ач холбогдол, судлах шаардлага: Хуулиар хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, шүүх хэмээх байгууллагаар зөрчигдсөн эрхийг хангадаг.[45] Гэвч угтаа энэ нь хуулийн томьёоллоос ихээхэн шалтгаалдаг. Учир нь хууль ойлгомжтой, олон салаа утгатай бус, хууль хоорондын болоод, зүйл заалтын зөрчилдөөн бага байх[46] тусам шүүх түүнийг зөв үнэлж, хүний эрх, эрх чөлөө баталгаатайгаар хангагдах бололцоо бий болдогтой холбоотой.

Хууль зүйн техник ба Авилгалын хуулиуд:

Эрх зүйн онолын шинжлэх ухааны судлах зүйлийн нэг гол хэсэг нь эрх зүйг бүтээх, боловсруулах, хэрэглэх ажиллагаа байдаг. Энэхүү ажиллагаа нь хууль зүйн техникийн элементүүдээр дамжин хэрэгждэг.

Эрх зүйн актын агуулга ба бүтцийг боловсруулах тэдгээрийг амьдралд хэрэгжүүлэхэд хэрэглэгддэг тодорхой арга, хэрэглүүр, журмын нийлбэр цогц нь эрх зүйн техник (хууль зүйн техник) юм. Хууль зүйн техникийн бүрэлдэхүүн хэсэг нь хууль зүйн нэр томьёо, хууль зүйн бүтэц, эрх зүйн хэм хэмжээний актыг буй болгох арга юм.

---

[44] Судлаачийн зүгээс дээрх ойлголтыг гоо зүйн хувьд бус хэл найруулагын хувьд авч үзсэн болно.

[45] Шүүхийг хүний эрхийг хамгаалах хэмээн томьёолж тусгадаг. Гэвч нь буруу юм. Учир нь шүүх нь оршин байх хэрэгцээ, шаардлага, эрх зүйт ёсны чиг үүргийн дагуу бол хүний эрхийг хамгаалдаггүй харин зөрчигдсөн тохиолдолд нохон сэргээн-тогтоох ажиллагааг хараат бусаар хэрэгжүүлдэг субьект мөн. Хүний эрхийг хамгаалах ажиллагааг хүний эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх ажиллааг зохион байгуулах эрх бүхий субьектийн чиг үүрэг юм.

[46] Хууль хэзээ ч төгс хэлбэржидэггүй. Учир нь хуулийг хүн (Улсын их хурлын гишүүд баталж, эрх бүхий хүмүүс төсөл боловсруулдаг) баталж, төслийг боловсруулдаг. Тиймээс судлаачын зүгээс хууль үргэлж асуудалтай байдаг гэж үзэв.

Хууль зүйн техникийн төрөл нь хууль тогтоомжийн техник, шүүхийн техник зэрэг юм[47]. Мөн ОХУ-ын нэрт эрдэмтэн С.С.Алексеев " Хууль зүйн техник нь эрх зүйн актуудын боловсронгуй байдлыг хангахын тулд түүнийг боловсруулах, системчлэхэд дагаж мөрдөх журмын дагуу ашиглаж буй арга нийлбэр юм" бол Францын эрдэмтэн П.Сандевуар " Хууль зүйн техник нь эрх зүйг бүтээх, хэрэглэхэд ашиглаж буй шинжлэх ухааны арга зүйн хэрэгслүүдийн нийлбэр юм" гэжээ.

Харин ОХУ-ын шинжлэх ухааны академийн сурвалжлагч гишүүн доктор, профессор Д.А.Керимов, доктор, профессор А.Ф.Черданцев нар: "Хууль зүйн техник гэдэг нь хууль зүйн баримт бичгүүдийг бэлтгэх, зохиох, хэлбэршүүлэх журам, арга хэрэгсэлүүдийн цогц мөн"[48] гээд түүнд, хууль бүтээх техник, хэм хэмжээний актуудыг эмхлэх цэгцлэх техник, эрх зүйн актуудын тоо бүртгэлийн техник, нэг бүрчилсэн актуудын техникийг тус тус хамааруулан авч үзсэн байна.

Дээрх эрдэмтэдийн тодорхойлсоноос харахад хууль зүйн техник гэдэг нь эрх зүйг бүтээх, эргээд түүнийг хэрэглэх, мөн хууль бүтээхэд ашигладаг арга хэрэглэгдэхүүний нийлбэр болох нь харагдаж байна.

Хууль зүйн техникийн хүрээнд хууль зүйн нэр томьёо чухлаар тавигддаг. Хууль зүйн нэр томьёо гэдэг бол хууль зүйн техникийн нэг хэсэг: төр эрх зүйн ухагдахууныг заан тэмдэглэж, түүний тусламжтайгаар хэм хэмжээний актын эх бичвэрт үгээр илэрхийлэгдсэн хэлбэр.

Хууль зүйн нэр томьёог дараах гурван төрөлд ангилж болно.

1. Түгээмэл ач холбогдолтой (Өдөр тутам хэрэглэгддэг нийтэд, бүхэнд ойлгомжтой) нэр томьёо:

2. Эрх зүйн онцгой агуулга бүхий хууль зүйн тусгай нэр томьёо.(жишээ нь: аргагүй хамгаалалт, гарцаагүй байдал, барьцаа, хөөн хэлэлцэх хугацаа, *авилгал* зэрэг):

3. Техник, эдийн засаг, анагаах ухаан, мал эмнэлэг, хөдөө аж ахуй зэрэг тусгай шинжлэх ухааныг тусган илэрхийлдэг техникийн тусгай нэр томьёо. (жишээ нь дархлалын олдмол хомсдолын өвчин, нянтай программ зэрэг).

Хууль зүйн нэр томьёоны асуудал нь агуулга, шинжээрээ хууль зүйн техникийн нэг үндсэн хэсэг нь болж, эрх зүйн хэм хэмжээг боловсруулж, түүнийг амьдралд хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг байна. Хууль зүйн нэр томьёо өөрийн гэсэн онцлог шинжүүдтэй. Энэ төрлийн нэр томьёо нь төрөөс тогтоосон буюу хүлээн зөвшөөрөгдсөн байдгаараа албан ёсны шинжтэй, илэрхийллийн хувьд тогтвортой боловч утга агуулга нь логик зүй тогтлоор холбогдсон нарийн нийлмэл байдаг. Ялангуяа хууль, төрийн дээд байгууллагын эрх зүйн актад тусгагддаг учраас амьдралд ойр, харьцангуй тодорхой төвшинд ойлгогдоно. Тэрч үүднээс хууль нь хүмүүс хоорондын нарийн төвөгтэй харилцааг зохицуулдаг тул нэр томьёоны хувьд ойлгомжтой байх хэрэгтэй юм. Нөгөөтэйгүүр хууль нь ард түмэнд, жирийн иргэдэд зориулагддаг тул тэдгээрт эргээд ойлгомжтой байх нь хамгийн гол нь байдаг (Заавал байх шинж юм).

Гэвч энэ улсын хууль тогтоомжийн системчлэл (Хууль зүйн техникийн хувьд) болоод бусад хүчин зүйлийн нөлөөлөл[49] зэргээс шалтгаалан жирийн иргэд (эдгээр нь хууль сахигч, хууль биелүүлэгч, хууль ашиглагч нар юм) битгий хэл хууль тогтоогч (Батлагч), хууль хэрэглэгч нар өөрсдөө ч ойлгоход хэцүү болоод байгаа.

Тодруулбал: Авилгалын эсрэг хуулийн 3.1.1. дугаар зүйлд: *Авилгал*

---

[47] С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг"., УБ, хот., 2008 он, 530 дахь талд

[48] Обшая теория государства и права. Академический курс в 2-х томах. Под ред. Поф.М.Н.Марченко. том 2. Теория права. М.,1998 с 367-368. (дам ишлэл)

[49] Судлаачийн зүгээс бусад зүйл гэдэгт ард иргэдийн боловсрол, мэдээ мэдээлэл олж авах байдал, эдийн засгийн хүчин зүйл, төрийн тогтворгүй байдал зэргийг хамруулан ойлгож байна.

гэдгийг "...энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах[50], бусдад давуу байдал олгох[51], иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг."[52] гэжээ.

Харин Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйл Хээл хахууль авах гэдгийг "Албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан..." гэжээ. Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлд "Хээл хахууль өгөх[53]", 270 дугаар зүйлд "Хээл хахууль зуучлах[54]" хэмээн тусгайлан зааж өгсөн байна. Дээрхээс ажиглахад **Авилгал** гэгч утгын дор хээл хахууль оршиж байгаа нь харагдаж байна.

Үүнээс үзвэл:

Асуудал нэгдүгээрт: Авилгал болон хээл хахууль авах гэмт хэргийн субьект нь "Авилгалын эсрэг" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т[55] заасан этгээдүүдийг ойлгоно. Эдгээр этгээдүүд нь иргэдийн ашиг сонирхол, эрх, эрх чөлөөг нь зөрчсөн шийдвэр гаргах бүрэн эрхтэй байдаг тул тусгайлан зааж өгсөн. Нөгөөтэйгүүр доорхи албан тушаалтанууд нь өөр хоорондоо зэрэг дэв, албан тушаалын хувьд харилцан адилгүй байдаг нь тодорхой. Энэ үүднээс тэдгээрийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учрах хор уршиг нь харилцан адилгүй, өөр хоорондоо ялгаатай байна. Гэвч Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.1-д заасан Хээл хахууль авах гэмт хэргийн хүндрүүлэх шинжгүй ерөнхий бүрэлдээхүүнийг зааж өгсөн харин 268 дугаар зүйлийн 268.2[56]-т түүний хүндрүүлэх шинжийг зааж өгсөн байна. Үүнээс асуудал юунд байна вэ? гэвэл хээл хахууль авах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хор уршигийг огтхон ч тооцоогүй байгаад оршиж байгаа юм. Өөрөө хэлбэл тухайн албан тушаалтаны хахууль авсан үйлдлийн улмаас цаана хэр хэмжээний хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхол хохирсон гэдгийг анхаарахгүй ял оногдуулах нь учир дутагдалтай юм. Уул нь хэр хэмжээний хээл хахууль авсандаа бус харин хэр хэмжээний хор уршиг учирваа гэдэгт хамгийн гол нь байгаа юм.

Жишээ нь: Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын албан тушаалтай этгээдээс хээл хахууль авч гарсан хууль бус шийдвэрийн ард учрах хор уршиг, жирийн замын цагдаагийн зохицуулагчийн учруулах хор уршиг өөр хоорондоо үлэмж ялгаатай байна.[57]Гэвч Эрүүгийн хуулийн нэг заалтаар ижилхэн ял зарим тохиолдолд илүү өндөр санкаар шийтгүүлж байгаа нь харамсалтай хэрэг юм.

---

[50] Авилгалын эсрэг хууль 3.1.3."албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах" гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг;

[50] Авилгалын эсрэг хуулийн 3.1.1. дугаар зүйл.

[51] .Авилгалын эсрэг хууль, 3.1.4."давуу байдал" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг;

[53] "Албан тушаалтанд өөрөө буюу бусдаар дамжуулж хээл хахууль өгсөн бол..." гэжээ.

[54] "Хээль хахууль өгч авахад зуучилсан бол..." гэжээ.

[55] 1. төрийн улс төр, захиргаа, тусгай албан тушаалд байнга, эсхүл түр хугацаагаар томилогдсон буюу сонгогдсон албан хаагч;
2. төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон захиргааны албан тушаалтан;
3. олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, Ерөнхий захирал;
4. төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан;
5. энэ хуулийн 3.1.9-д заасан сонгуульд нэр дэвшигч.

[56] Эрүүгийн хуулийн 268.2. "Энэ хэргийг хясан боогдуулах замаар, эсхүл давтан буюу урьд хээл хахуулийн хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл их буюу онц их хэмжээний хээл хахууль авсан бол эд хөрөнгийг хурааж таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. "

[57] 2008 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр Баянзүрх дүүргийн шүүхээс Замын цагдаагийн зохицуулагч цагдаагаар ажиллагдаг "Л"-д холбогдох Хээл хахууль авсан гэх гэмт хэргийг шийдвэрлэжээ. "Л" нь зөрчил гарсан "Б"-г саатуулж түүнээс албан үүргээ хэрэгжүүлээгүй, болон хэрэгжүүлсэнийхээ төлөө 35.000 төгрөг авсан байна. Харамсалтай нь шүүх түүнд эрүүгийн хуулийн 268-р зүйлийн 2681-д зааснаар Л-н зохищуулагч цагдаагаар ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж 1 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгэсэн байна. (Монгол Улсын Авилгалтай тэмцэх газар, "Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхтгэл"цуврал-1., УБ 2009 он., 23-25 талд)

Тиймээс энэхүү илтгэлийг тэрлэгч миний бие нь Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.1. болоод 268.2.т заалтыг нарийвчлан зааглаж, тодорхой болгож өгөх хэрэгтэй юм байна гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл хүндрүүлэх болон ердийн бүрэлдэхүүнд хор уршигийг зааж өгөх нь чухал юм. Эрүүгийн хуулийн зарчимд энэрэнгүй ёсны зарчим болоод шудрага ёсны зарчим үйлчилдэг билээ. Тиймээс нэг хүний эрх чөлөөг зөрчиж нэг жилийн ял эдэлж, 100 хүний эрх, эрх чөлөөг зөрчөөд торгох, эсхүл үсрээд л 1 жилийн ял эдлээд явах нь мөн чанарын хувьд дээрхи зарчмуудтай нийцэх эсэхийг бодох хэрэгтэй байх.

Асуудал хоёрдугаарт : Судлаач дээр хээль хахууль нь Авилгал хэмээх агуулгын дотор нь оршидог гэдгийг тэмдэглэсэн. Тэгвэл Авилгал нь өөртөө ***Хээл хахууль***[58], ***Шан харамж авах***[59], ***Бэлэг***[60], ***Ах дүүсэх, найзархах,***[61] ***зүй бусаар тал өгөх***[62], ***тал тохой өгөх***[63] гэх мэт зүйлийг өөртөө багтаадаг. Тэгвэл Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг болох Хээл хахууль авах гэмт хэрэг ямар агуулга бүхий болох нь тодорхой бус байгаад байна. Өөрөөр хэлбэл Хээл хахууль гэдэгт зөвхөн мөнгө л өгч авахыг хэлэх үү эсвэл илүү өргөн хүрээтэй ойлголт уу.Хахууль гэдгийг С.Нарангэрэл гуай "хахууль өгөх ба хахууль авах гэмт хэргийн зүйл бөгөөд мөнгө, үнэт цаас, бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн шинжтэй ашгийн байдлалтай материаллаг урамшууллын бүхий л төрлийг багтаасан ерөнхий ойлголт "гэжээ. Гэвч энэ онд гарсан авилгал авсан болоод өгсөн гэмт хэргийг шинжлэвэл бүгд мөнгө авах, өгөх үйлдэл л байгаад Авилгал гэдгийг мөнгө өгөх, авах гэдэг ойлголтонд хардах сэтгэл төрүүлж байгаа юм.[64] Хэрвээ мөнгөнөөс гадна материаллаг эд баялаг, материаллаг бус бусад зүйлийг хамруулан ойлгох юм бол бэлэг, шан харамж авах, ах дүүсэх, найзархах, зүй бусаар тал өгөх, тал тохой өгөх үйлдлүүдийг өөртөө мөн адил багтааж байхаар ойлгогдож байна. Тэгвэл ***Авилгал=Хээл хахууль*** нь тэнцүү ижил утгатай ойлголт уу? Эсхүл ялгаатай юу? Ялгаатай бол юугаараа ялгаатай вэ? гэх олон асуултууд гарч ирнэ. Үүнээс хээль хахууль гэх ойлголтыг тайлбарлахдаа зөвхөн түүний үйл ажиллагаагаа биелүүлэх, биелүүлэхгүй байхаар тайлбарлах нь оновчтой бус байна. Тиймээс түүнийг илүү нарийвчилсан байдлаар тайлбарлах нь (дээд шүүхээс) шаардлагатай байна. Хууль нь хүмүүсийн амин чухал нарийн төвөгтэй харилцааг зохицуулдаг тул ойлгомжтой байхаас гадна нэг мөр ойлгогдохоор байх нь чухал хэмжүүр юм. Олон салаа утгатай, эсхүл утга нь тодорхой бус үг хуулинд байх нь түүнийг эргээд бусдад ашигтайгаар тайлбарлагдах, түүнийг урвуулан ашиглах боломжийг нээж өгдөг учир түүнийг цэгцлэх нь чухал юм.

Асуудал гуравдугаарт: Эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдүүдэд заавал хариуцлага оногдуулдаг. Хариуцлага[65] нь Эрүүгийн, Иргэний, Захиргааны, Сахилгын гэх мэт төрлүүдэд хуваагддаг. Авилгал авсан тохиолдолд хүлээлгэх хариуцлага нь

---

[58] Bribery - хээл хахууль "Албан хаагч, эсхүл бусад хүний албаны буюу хууль ёсны үүргийг нь биелүүлэхгүй болгоход нөлөөлөхийн тулд аливаа үнэт зүйлийг санал болгох, өгөх, авах, зуучлах"

[59] Шан харамж бол авлигын шинжтэй эрх зүйн зөрчлийн нийгмийн хор аюулын зэрэглэлээр харьцангуй бага хэлбэр юм.Албаны үүргээ зохих ёсоор биелүүлсний төлөө тухайн этгээдийг хувиараа урамшуулан шагнахыг шан харамжид хамааруулж ойлгоно.

[60] Авлигын бас нэг хэлбэр бол бэлэг юм.Бэлэг бол хүмүүсийн хоорондын гэсгүй сайхан харилцаа,сайн санааны илэрхийлэл болгон өгч авдаг зүйл юм.Бэлэг өгч авах талаар манай ард түмний дунд эртнээс тогтсон уламжлал бий

[61] Төрөл садан,ах дүү,найз нөхдийн холбоо хүний амьдралд үнэхээр чухал гэдгийг хэн хүнгүй л хүлээн зөвшөөрнө.Мөн л энэ нандин холбоог авлигын шинжтэйгээр ашиглах явдал байдаг байна

[62] Төрийн байгууллага,албан тушаалтан зарим аж ахуйн нэгжид ялгаварлан тал өгч хэт ойр харилцаа үүсгэн түүнд тусгайлсан дэмжлэг үзүүлэх явдлаар авлигын энэ хэлбэр илэрнэ.

[63] Энэ нь ихэвчлэн албан тушаалын томилгоотой холбоотой илэрдэг авлигын хэлбэр юм.Албан тушаалд танилаа,эсхүл танилынхаа санал болгосон хүнийг "дотно танилын шалгуур"-ыг ажил хэргийн шалгуураас илүүд үзэж томилох явдалавлигын энэ хэлбэрийн агуулгыг тодорхойлно

[64] Монгол Улсын Авилгалтай тэмцэх газар "Албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн эмхтгэл"-цуврал-1. УБ-2009 он., (2008 онд шийдвэрлэсэн 18 авилгалын эсрэг гэмт хэргийн зүйл нь бүгд мөнгө байна.)

[65] Хариуцлага нь гэмт халдлагаас иргэд байгууллагын аюулгүй байдлыг хамгаалах, гэмт халдлагад өртөгдсөн этгээдийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээж хохирлыг арилгах, эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн гэм буруутай этгээдэд ял, зэмлэл хэрэглэх төрлийн албадлагын арга хэмжээ юм.

хуулиудад Эрүүгийн, захиргааны, зарим тохиолдолд сахилгын хариуцлага хүлээлгэхээр зохицуулж өгсөн байна. Авилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1."Авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ." гээд 33 дугаар зүйлийн . 33.2. "Энэ хуульд заасан авлигын эсрэг хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх захиргааны шийтгэлийг шүүгч ногдуулна" гэжээ. Харин дээрх Эрүүгийн хариуцлага нь Эрүүгийн хууль заасан хээл хахууль авах, өгөх, зуучлах гэмт хэргүүдэд зааж өгсөн. Мөн төрийн байгууллага, албан хаагчын эрх зүйн байдлыг зохицуулсан, бүрэн эрх, эрх хэмжээг нь зааж өгсөн бусад хууль тогтоомжуудад "Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь Эрүүгийн хариуцлага оногдуулахааргүй бол захиргааны хариуцлага хүлээлгэнэ" гэсэн өгүүлбэрээр зохицуулсан байна. Үүнээс харахад ямарч л байсан авилгал авсан этгээдэд захиргааны хариуцлага[66] хүлээлгэхээр байгаа ойлгомжтой байна. Тэгвэл асуудал юунд байна вэ гэвэл ямар төрлийн үйлдэлд нь Эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ямар төрлийн авилгалын үйлдэлд нь захиргааны хариуцлага хүлээлгэх эсэх нь зааг ялгаа алга байгаад учир байна. Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн Хээл хахууль авах гэмт хэрэгт хэчнээн хэмжээний мөнгө авсан нь чухал биш харин зөвхөн мөнгө авсан, түүтэй холбоотой шийдвэр гаргасан, эсхүл гаргалгүй орхисон тохиолдолд л шууд бий болдог хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг. Харин түүний хүндрүүлэх бүрэлдэхүүнд "Онц их хэмжээний" хээл хахууль авсан бол гэдэг нөхцөл зааж өгсөн нь түүний дээд хэмжээ болохоос (Энэ гэмт хэрэгт) түүний доод хэмжээг зааж өгсөн зүйл алга байна. Боловсролын тухай хуульд зааснаар Багш болон Албан тушаалтан (Сургуулийн албан тушаалтан) хуульд заагаагүй төлбөр, хураамж (өөрөөр хэлбэл орлогоос гадуур мөнгө буюу хахууль) авсан бол захиргааны хариуцлага хүлээлгэхээр эсхүл Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан боловч ямар үйлдэлийг нь Эрүүгийнх, Захиргааных гэдгийг заагласан зүйл алга байна[67]. Хуулийн хэм хэмжээний болоод хууль хоорондын зөрчилдөөнгүй байх нь хууль зүйн техникийн хамгийн үнэтэй шаардлагуудын нэг юм. Харин Авилгалын асуудлыг зохицуулсан эдгээр олон хуулиуд[68] нь өөр хоорондоо

---

[66] Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. Зөрчил гаргасан этгээдэд дараахь захиргааны шийтгэл ногдуулж болно.
1/ торгох
2/ тусгайлан олгосон эрх хасах:
3/хууль бусаар олсон орлого, эд зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах:
4/ баривчлах:

[67] Баянхонгор аймгийн нэгэн сургуулийн Захирал нь 200.000 мянган төгрөгний хахууль авсан хэрэгт холбогдож 1 жилийн хугацаагаар албан тушаалын эрхийг хасаж, 2 жилийн хугацаагаар хорих ял шийтгүүлсэн байна.

[68] Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйл.
15.1.6. Албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсэний төлөө бусад байгууллага аж ахуйн нэгж, иргэнээс мөнгөн шагнал, шан харамж, зээл ваха, төлбөргүй буюу хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэх.
Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйл.
41.1. Төрийн албаны тухай хуулийн дараахь зүйл заалтыг зөрчсөн этгээд, төрийн албан хаагчид Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол захиргааны хариуцлага хүлээлгэнэ.
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 8 дугаар зүйл.
8.5. Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 5, 8, 10 дахь хэсэгт заасныг зөрчсөн намыг 800.000-1.000.000 төгрөгөөр торгох ба мөн зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан данснаас гадуур авсан хөрөнгийг хураж улсын орлого болгоно. Хэрэв уг данснаас гадуур авсан хөрөнгийг зарцуулсан бол түүнийг нөхөн төлүүлж улсын орлого болгоно.
7 дугаар зүйл.
7.8. Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам, нэр дэвшигч нь Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 41 зүйлийн 41.7. дахь хэсэгт заасан этгээдээс сонгуулийн ажилд зориулж хандив авах, түүнчлэн сонгууль бэлтгэн явуулах хугацаанд тусламжийн эд хөрөнгийг иргэдэд тараах буюу борлуулж сонгуульд зарцуулахыг хориглоно.
8.2 Сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
8.6 энэ хуулийн 7-р зүйлийн 6.9 дэх хэсэгт заасныг зөрчсөн хандивлагч, нэр дэвшигч, намын сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтныг 200000-300000 төгрөгөөр, албан тушаалтныг 250000-350000 төгрөгөөр, намыг 800000-1000000 төгрөгөөр торгох ба мөн зүйлийн 6 дахь хэсэгт заасан этгээдээс авсан хандивыгхурааж улсын орлого болгоно.
7.6 Талархан дэмжигч нам, байгууллага, иргэд сонгуульд зориулж мөнгөн хандив өргөж болох бөгөөд түүнийг сонгуулийн зардлыг сангийн дансанд төвлөрүүлэх бөгөөд уг данснаас гадуур сонгуульд зориулж хандав авах, өгөх, зарцуулахыг хориглоно.
7.9 Нэр дэвшигчийг талархан дэмжигчдээс сонгуульд зориулж өргөх хандивын дээд хэмжээ хуулийн этгээдээс 10 сая, иргэдээс 5 сая төгрөгөөс хэтэрч болохгүй.
Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль

зөрчилдөж, нэг нэгнээ үгүйсгэж байгаа нь түүнийг амьдралд хэрэгжүүлэхэд ихээхэн хэмжээний сад тотгор болж байна. Тиймээс

41.1. Нам, эвсэл, нэр дэвшигчид өгөх хандивийн дээд хэмжээ хувь хүнээс 1 сая төгрөг, хуулийн этгээдээс 3 сая төгрөг байна.

41.9 Энэ хуулийн 41.1, 41.3-41.8-д заасныг зөрчсөн хандивлагч, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтныг 150000-250000 төгрөгөөр, албан тушаалтныг 200000-250000 төгрөгөөр, нам эвслийг 800000-1000000 төгрөгөөр торгох, 41.7-д заасан этгээдээс хандив авч зарцуулсан нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах ба 41.1-д заасан хэмжээнээс илүү гарсан түүнчлэн 40.1-д заасан данснаас гадуур өгсөн болон 41.7-д заасан этгээдээс авсанхандивыг хураах, улсын орлого болгоно.

Төрийн хяналт шалгалтын тухай хууль

5.5 Хяналт шалгалтын байгууллага, албан тушаалтан, хяналт шалгалтын ажилд оролцсон бусад этгээд хяналт шалгалтын явцад авсан мэдээллийг өөр зорилгоор ашиглахыг хориглоно.

5.10 Хяналт шалгалтын явцад гэмт хэргийн шинжтэй зөрчил илэрсэн тохиолдолд хяналт шалгалтын байгууллага холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад харьяаллын дагуу шилжүүлнэ.

15.1 Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтан хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Боловсролын тухай хуулийн 48 дугаар зүйл.

48.2. Боловсролын тухай хууль тогтоомж зөрчигчид Эрүүтийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дараахь захиргааны шийтгэл ногдуулна.

48.2.6. Суралцагчийн бие махбодид халдсан, сэтгэл санаагаа дарамт үзүүлсэн, мөнгө өгөх, ном бүтээгдэхүүн худалдаж авахыг тулгасан, тэдний хувийн нууцыг задруулсан, **хуульд заагаагүй төлбөр, хураамж авсан багшийг 10000-30000 төгрөгөөр, албан тушаатныг 40000-60000 төгрөгөөр торгох.**

Газрын тухай хуулийн 36 дугаар зүйл.

36.1. Газрын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол байгаль орчны улсын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл оногдуулна.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 52 дугаар зүйл.

52.1 Монгол Улсын хууль тогтоомж, өргөсөн тангарагаа зөрчсөн цагдаагийн албан хаагчид хууль тогтоомжийн дагуу эрүүтийн, захиргааны болон сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 25 дугаар зүйл.

25.1. Хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр орлого олох.

Тагнуулын байгууллагын тухай хуулийн 29 дүгээр зүйл.

29.1. Тагнуулын байгууллагын тухай хууль зөрчсөн этгээдэд хууль тогтоомжийн дагуу эрүүгийн, захиргааны болон сахтлгын хариуцлага хүлээлгэнэ.

Орон сууц хувьчлах тухай хуулийн 26 дугаар зүйл.

26.1 Албан тушаалтан орон сууц хувьчлах ажилд эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, бүрэн эрхээ хэтрүүлсэн, хайнга хандсан, хэл хахууль авсан, өгсөн, зуучилсан, хуурамч баримт бичиг үйлдсэн гэм буруутай бол Эрүүтийн хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Тусгай зөвшөөрөл олгох тухай хууль

11.2 Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардаж болохгүй.

18.1.5 Энэ хуулийн 6.3, 11.2, 12.1, 13.2, 14.2-ыг зөрчсөн **албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр торгох.**

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль

14 дүгээр зүйл. Улсын төсвийн байгууллагад хориглох зүйл

14.1.4 хуульд зааснаас бусад тохиолдолд төлбөр, хураамж авах, энэ хуульд заасныг зөрчиж нэмэлт бүтээгдэхүүн нийлүүлэх зэрэг аливаа хэлбэрээр орлого олох

судлаачийн зүгээс тавьж буй дараагийн санал бол “Авилгал”-ыг тойрсон эдгээр олон хууль хоорондын зааг ялгаа, харилцаа хамаарлыг хуулийн системчлэлийн дагуу цэгцлэн эмхтгэж нарийвчлан зохицуулж өгөх нь шаардлагатай байна.

Асуудал дорвдугээрт: Авилгал тухайн улс оронд их байх нь хөгжлийг үргэлж хойш татдаг гэмтэй. Манай улсын хувьд Транспэранси Интернэшнилээс авилгалын индексийг судлан зарладаг олон улсын нэр хүндтэй судалгааны үр дүнгээс харахад 1999 онд Монгол Улс 99 орноос 49 дүгээр байранд буюу дундаж үзүүлэлттэй байсан бол 2005 онд 159 орноос 85 дугаар байранд орж үзүүлэлт нэлээд олон нэгжээр доошилжээ. Авлигын нөхцөл байдлын индексын дагуу 10 оноо авах ёстойгоос /авлигагүй бол/ дөнгөж 3.0 оноо авч байгааг тооцвол авлигын нөхцөл байдал даамжран хүндрэх чиглэлтэй байна.[69]Энэ нь олон нөхцөл байдал, шалтгаантай холбоотой. Түүхэн үеэ эргэн харвал энэ улсад бүр эрт дээр үеэс авилгал хэмээх гэмт хэрэг ч юм уу? Эсхүл тийм төрлийн нэр томьёо бараг л байгаагүй ч гэсэн шан харам авах, эрхээ хэрэгжүүлсэний төлөө бусдаас мөнгө, эд хөрөнгө, эрх олж авах нь байсан боловч түүнийг хуулиар зохицуулж өгөөгүй байсан юм. Харин 1996 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр “**Авилгалын эсрэг хууль**” батлагдан гарсан. Энэ нь Авилгалыг буруулахад ихээхэн хэмжээний түлхэц болсон. Дараа нь Авилгалын эсрэг хуулийг 2006 оны 7 дугаар сарын 06-ны өдөр шинэчлэн найруулсан юм. Тэгэхдээ асуудал юунд байна гэвэл “**Авилгалын эсрэг хууль**” нь өөрөө амьдрал дээр төдийлөн буугаагүй өөрөөр хэлбэл тунхагын шинжтэй хууль байгаад гол нь оршиж байна. (Хавсралтаас үз) Тиймээс Монгол Улс Авилгалын тоог бууруулж,

[69] Д.Зүмбэрэлхам, Авлигын гэмт явдал. УБ., 2007. х.21

түүнийг шийдвэрлэхийн тулд "**Авилгалын эсрэг хууль**"-тай холбоотойгоор "**Мэдээллийн тухай хууль**" батлан гаргах, нөгөөтэйгүүр орлого, зарлагын мэдүүлэгийг авах, хянах, иргэдэд мэдээллэх зэрэг аргыг илүү нарийвчилсан системд оруулах шаардлагатай байна. Энэ нь Төрийн албан хаагчийн Авилгал авч буйг хянах, авсан тохиолдолд түүнийг илрүүлэхэд хэрэгтэй механизм гэдэг нь ойлгомжтой юм.

Дүгнэх нь буюу санал:

Авилгал нь нийгмийн шинжтэй үзэгдэл. Нийгэм оршиж байгаа цагт гэмт хэрэг, гэмт явдал оршисоор л байх болно. Тиймээс эрх мэдэл байгаа цагт энэ авилгал амьсгалсаар л байх болно гэсэн үг. Энэ нь яг л компьютер вирустэж, устаж үгүй болж байгаатай адилхан юм. Түүнийг цэвэрлэх л хэрэгтэй (Format-лах л хэрэгтэй) байдаг. Үүний нэгэн адил авилгалын харилцааг зохицуулсан хууль тогтоомжууд нь өөр хоорондоо зөрчилдсөн тодруулбал бохирдсон (вирус) байгаад учир вий. Тиймээс илтгэлийг тэрлэгч дараах саналуудыг дэвшүүдж байна.

1. Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.1, 268.2 заалтыг илүү нарийвчлан зохицуулах хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл тухайн албан тушаалтны хэр хэмжээний мөнгө авсан бэ? гэдэгтэй бус харин түүний хууль бус шийдвэр бусад зүйлсээс болж хэр хэмжээний хохирол учирч вэ? гэдэгт анхаарах хэрэгтэй байна.

2. Авилгал нь хээл хахууль гэх ойлголтыг өөртөө багтаагаад байгаа юм уу? Эсхүл хээл хахууль нь авилгалаас өргөн, тэнцүү ч юм уу. Авилгал хээл хахууль гэх өргөн ойлголтуудыг нарийн зааглаж тайлбарлах шаардлагатай байна. Ойлгох нь зөв ярихаас эхэлдэг. Нэг ойлголтыг хоёр өөр үгээр илэрхийлэх нь алдаатай юм. Хэрвээ өөр ойлголт юм бол түүнийг ялгах нь зүй нь хэрэг билээ.

3. Авилгал авсан үйлдэлд Эрүүгийн болоод Захиргааны хариуцлага хүлээлгэх нь гарцаагүй. Тэгвэл энэ хоёр хариуцлагын зааг ялгааг гаргах учиртай. Ямар төрлийн авилгал авсан үйлдэлд нь Эрүүгийн хариуцлага, ямар төрлийн авилгал авсан үйлдэлд захиргааны хариуцлага хүлээлгэх нь тодорхой байх ёстой. Тиймээс үүнийг зааж өгсөн заалт оруулах, эсхүл хуулинд нэмэлт оруулах маягаар тодорхой зааж өгөх хэрэгтэй байна.

4. Авилгалын эсрэг хууль бол энэ харилцааны гол зэвсэг байх ёстой. Тэрч үүднээсээ энэ хууль өөрөө амьд байх хэрэгтэй. Тиймээс "Авилгалын эсрэг хууль"-ийн зүйл заалтуудтай холбоотойгоор зарим хуулийг батлан гаргах (мэдээллийн тухай хууль), хяналтын системийг боловсронгуй болгох шаардлагатай гэж миний бие үзэж байна.



Э.УНДРАХ

Сүхбаатар аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэр гүйцэтгэгч

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭН ДЭХ ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТЫН АСУУДАЛ

Монгол улсын гэр бүлийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд гэр бүлийн эрх зүйн харилцааны тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага урган гарч байгаа юм.Тэдгээрийн дотроос нилээд бэрхшээлтэй боловч, зайлшгүй шийдвэрлэвэл зохих асуудал нь хүүхдийн эрх ашиг сонирхол, эрхийн хамгаалалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох явдал юм.

Монгол Улс 1990 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцийг хүлээн зөвшөөрч, нэгдэн орж, соёрхон баталснаар хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч, төрийн зүгээс хүүхдийн эрхийг хамгаалахад хүлээх үүрэг тодорхой болсон төдийгүй улмаар хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, гэр бүл, нийгмийн амьдралд оролцох эрхийг бүрэн хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай болсон.

Монгол Улсын Үндсэн хууль болон УИХ-аас 1996 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, 1999 онд Гэр бүлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль зэрэг бусад хууль тогтоомж батлагдсанаар хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн үндэс бүрдсэн билээ. Мөн хүүхдийн эрхтэй холбоотой хэд хэдэн гэрээ конвенцид нэгдэн орж, олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу хүүхдийн эрх хамгаалагдах боломжтой болсон юм. Гэсэн хэдий ч манай улс орны эдийн засаг, улс төрийн үйл явцаас шалтгаалан хүүхдийн ашиг, сонирхол, эрхийн хамгааллын өргөн хүрээтэй энэ асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхэд хүндрэлтэй олон асуудал байна.

Тэдгээрийн нэгээхэн чухал хэсэг нь гэр бүлийн хүрээнд хүүхдийн ашиг, сонирхол, эрхийн хамгаалалтын асуудлыг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулж шийдвэрлэх асуудал юм. Энэ сэдвийг хөндөхийн тулд эхлээд хүүхдийн ашиг, сонирхол эрхийн хамгаалал гэдэг ойлголтыг гэр бүлийн эрх зүйн хүрээнд хэрхэн авч үзэх талаар тодруулах нь зүйтэй гэж үзлээ.

Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д нэр бүлийн гишүүн гэж тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл садан хүнийг хэлнэ, мөн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д хуулийн зорилтыг тодорхойлохдоо “ гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна” хэмээн тодорхойлсон нь энэ хуулиар хүүхэдтэй холбогдсон харилцааг гэр бүлийн гишүүний хувьд эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах үндэслэлтэй байна. Иймд хүүхдийн тэжээн тэтгүүлэх, асран хамгаалуулах эрхийн хүрээн дэхь асуудлыг тусгайлан авч үзээд энэ талаарх харилцааг зохицуулсан холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар өөрийн санал хэлэлцүүлэхийг хүсэж байна.

Гадаадын ихэнх улс оронд хүүхдийн тэтгэлэгийн хэмжээг үндсэн 2 аргаар тодорхойлдог байна.

1. Тэжээгчийн сар бүрийн цалин, түүнтэй адилтгах орлогоос хүүхэд тус бүрд тодорхой хувиар.
2. Хүүхэд тус бүрийн хэрэглээг харгалзан сар бүр тэтгэлэгийн хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлэн тогтоодог.

Манай улсад өмнө үйлчилж байсан 1973 оны Гэр бүлийн хуульд дээр дурьдсан нэгдүгээр аргын үндсэн дээр буюу тэжээгчийн сар бүрийн цалингаас нэг хүүхдэд 15-25 хувь, хоёр хүүхдэд 35 хувь хүртэл, Гурав ба түүнээс дээш хүүхдэд 50 хувь хүртэл хэмжээгээр тогтоодог байжээ. Харин манай улс зах зээлийн харилцаанд шилжсэнтэй уялдан ажилгүйдэл нэлээд их хувийг эзлэх болсон учраас тэтгэлэг төлөгч ажилгүй цалин орлоггүй болсон гэх үндэслэлээр хүүхдийн тэтгэлэг төлөгдөхгүй, хүүхдийн эрх ашиг зөрчигдөх болсон юм.

Тийм учраас УИХ-аас 1999 онд Гэр бүлийн тухай хуулийг батлахдаа хүүхэд тус бүрт тухайн нутаг дэвсгэрт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр буюу тодорхой мөнгөн дүнг тогтоож өгдөг болсон байна.

Тэжээгч нь хүүхдийн тэтгэлэгийг сар бүр төлөх үүрэгтэй бөгөөд цалин орлогогүй, санхүүгийн боломжгүй зэрэг шалтгаанаар хүүхдийг тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөх үндэслэлгүй юм.

Харин тэтгэлэг төлөгч хөдөлмөрийн чадвараа алдсан , тэтгэлэг авагчаас бага орлоготой нь тогтоогдвол тэтгэлэгийн хэмжээг багасгах асуудлыг шүүх шийдвэрлэх боломжтой.

Гэр бүлийн тухай хууль дахь хүүхдийн тэтгэлгийн эрх зүн зохицуулалтыг дээр дурьдсанаас дүгнэн үзэхэд:

1. Тэтгэлэгт хамрагдах хүүхдийг 16 настай | суралцаж байгаа бол 18 нас \ болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй байхаар тогтоосон явдал нь гэр бүлийн тухай хуулийн зарим заалтууд агуулгаараа хоорондоо зөрчилдөж байна.

Тухайлбал: Гэр бүлийн тухай хуулийн 38-р зүйлийн 38.1-д эцэг, эх нь насанд хүрээгүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй гэсэн заалт байдаг талаар дурьдсан. Энэ нь хүүхдийг тэжээн тэтгэхэд заавал байх нэг гол шалгуур бол нас юм гэдгийг илэрхийлсэн төдийгүй эцэг, эхээрээ тэжээн тэтгүүлэх хүүхэд насанд хүрээгүй байна гэдгийг тодорхой болгож байгаа юм.

Тэгвэл насанд хүрээгүй гэж хэнийг ойлгох вэ гэдгийг тодруулхад Иргэний хуулийн 16 дугаар зүйлд зааснаар 14-18 хүртэлх насны хүмүүсийг түүнд багтааж, харин мөн хуулийн 15 дугаар зүйлд 18 насанд хүрснээр өөрийн хийж буй үйлдлийнхээ учир холбогдлыг бүрэн ойлгож, түүнээс гарах үр дагаврыг өөрөө хариуцах боломжтой болж байна.

Гэтэл Гэр бүлийн тухай хуульд хэрэв хүүхэд суралцаж байгаа бол 18 настай болтол нь, бусад тохиололд 16 настай хүүхдэд хуульд заасан хэмжээний тэтгэлэг тогтоохоор заасан нь насанд хүрээгүй тэтгэлэг авагчийн эрх ашгийг хохироосон учир дутагдалтай зохицуулалт болж байна. Тийм учраас хүүхдийг нийтэд нь 18 насанд хүртэл тэжээн тэтгэдэг хуулийн зохицуулалтыг бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

Хүүхдийн тэтгэлэгийн хэмжээ хүүхдийн амьдарч байгаа бүс нутаг, насны байдлаас шалтгаалан сард дунджаар 70000 төгрөг байгаа нь өнөөгийн нөхцөлд хүүхдийн хэрэгцээг хангаж чадахгүй, үүнээс улбаалан хүүхэд ихээхэн хохирч байгаа тул хуулиар тогтоох тэтгэлэгийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай юм.

Хүүхдийн тэтгэлэгийг тогтоохдоо хүүхдийн амьжиргааны түвшин, хэрэгцээ, тэжээгчийн хөрөнгө, цалин орлоготой уялдуулан зохицуулдаг болгох. Нэгэнт хүүхдийн тэтгэлэгийн хэмжээ хүрэлцэхгүй байгаа тул хүүхдийн тэтгэлэгийн хэмжээг нотлох баримтыг үндэслэн нэмэгдүүлэн тогтоох нь зүйтэй санагддаг.

Хүүхдэд онцгой нөхцөл байдал тохиолдсон үед нэмэлт зардал гаргуулах тухай хуульд тусгасан хэдий ч зөвхөн тодорхой хэдэн тохиолдолын хүрээнд л хязгаарлажээ.

Нэгэнт хүүхдийн тэтгэлгийг багасгаж болохоор зааж өгсөн байх тул тэтгэлэг төлөгч хүүхдийн тэтгэлэгийг нэмүү байдлаар төлөх бололцоотой бол хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хүүхдэд нэмэгдэл тэтгэлэг гаргуулах нь зүйтэй.

Хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тухай

Хүүхдийг тэжээн тэтгэх нь эцэг, эхийн хувьд үүрэг байдаг учраас энэхүү үүргээ эс биелүүлвэл хариуцлага тооцох үр дагавар үүсэх учиртай.

Хүүхдээ тэжээн тэтгэх үүргийг биелүүлээгүй. санаатай зайлсхийсэн эцэг, эхэд хариуцлага тооцох асуудал нь гэр бүлийн эрх зүйн хамгаалалтын чухал асуудал юм.Учир нь гэр бүлийн эрх зүйн хамгаалалт нь гэрлэгчид, гэр бүлийн гишүүдийн зөрчигдсөн эрхийг хамгаалах зорилгыг агуулж байх бөгөөд эрх нь зөрчигдсөн этгээд өөрийн эрхээ хамгаалахын тулд хуульд заасан аргуудыг ашиглан хэрэгжүүлэх боломжтой. Өөрөөр хэлбэл эцэг, эх нь хүүхдээ тэтгэхээс зайлсхийвэл хүүхдийн эрх, ашиг, сонирхол зөрчигдөж, хүүхдийн амьдрах нөхцөл дордож, улмаар эрүүл мэнд өсч бойжих, оюун ухаан, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэх, нийгмийн амьдралд оролцох эрх нь ноцтой зөрчигдөнө.

Тийм учраас хүүхдийн хамгаалагдаж буй эрхийн онцлог, эцэг, эхийн гэм буруугийн шинж байдлаас шалтгаалан хүүхдийн эрхийг хамгаалах аргыг сонгох буюу хариуцлагын шинжтэй аргуудыг ашиглана.

Гэр бүлийн тухай хуулийн 50 дугаар зүйлд зааснаар тэтгэлэг төлөх тухай талууд гэрээ байгуулсан бөгөөд тэтгэлэгийг хугацаанд нь төлөөгүй бол учирсан хохиролыг гэрээнд заасан журмаар нөхөн төлнө.

Мөн түүнчлэн шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлэгийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдуулсан хоног тутамд тогтоосон тэтгэлэгийн үнийн дүнгийн 0.5 хувийн алданги тооцно. Алдангийн нийт хэмжээ төлөгдөөгүй тэтгэлэгийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна. Тэтгэлэгийг хугацаанд нь төлөөгүй улмаас учирсан хохиролыг нөхөн төлөх талаар гэрээнд заагаагүй бол алданги гаргуулах талаар заасан. Өөрөөр хэлбэл гэр бүлийн хуулийн зохицуулалтаас хархад тэтгэгч тэтгэлэгийг хугацаандаа төлөхгүй бол учирсан хохиролыг нөхөн төлүүлэх,

хожимдуулсан хоног тутамд алданги төлүүлэхээр заажээ.

Харин практикт тэтгэлэг төлөхгүй байгаа тэжээгчээс алданги, хохиролыг гаргуулах тухай хуулийн энэхүү зохицуулалт хэрэгждэггүй.

Алдангийг тогтоож байгаа нь тэтгэлэг төлөгчийг хугацаандаа хүүхдийнхээ тэтгэлэгийг төлөөгүй тохиолдолд түүнд оногдуулж байгаа нэмэгдэл үүрэг буюу хариуцлагын нэг арга. Харин ямар журмаар алдангийг гаргуулах вэ гэдэг нариивчилсан зохицуулалт байхгүй .

Энэ тохиололд алданги төлүүлэх талаар шүүхийн шийдвэр заавал байх эсэх, эсхүл шийдвэр гүйцэтгэгч дангаараа алданги гаргуулах хариуцлагыг төлбөр төлөгчид ногдуулах эрхтэй эсэх асуудал энд гарч ирдэг.

Гэр бүлийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд тэтгэлэг төлөгчийн мөнгөн хадгаламж болон бусад эд хөрөнгөнөөс тэтгэлэг гаргуулахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмыг баримтална гэжээ.

Энэхүү зохицуулалтыг удирдлага болгон тэтгэлэг төлөгчийн тэтгэлэгийг шийдвэр гүйцэтгэгч хуульд заасан журмыг баримтлан гаргуулах үндэслэлтэй.

Шийдвэр гүйцэтгэгч нь дор дурьдсан 2 үндэслэл байвал хүүхдийн тэтгэлэгийг гаргуулна.Үүнд:

1. Хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар тогтоосон шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр шүүгчийн захирамж гарч, гүйцэтгэх хуудас бичигдсэн тохиолдолд хүүхдийн тэтгэлэгийг гаргуулах ажиллагаа явуулна.

2. Тэжээн тэтгэх гэрээндээ тэжээгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнийг үл маргах журмаар биелүүлэх талаар тохиролцож нотариатаар гэрээгээ гэрчлүүлсэн бол нотариатын мэдэгдэх хуудсыг бичүүлсний үндсэн дээр гэрээний үүргийг биелүүлэхийг шаардах эрхтэй.

Шүүх ИХШХШТХуулийн 184 дүгээр зүйлийн 184.3-т зааснаар нотариатын мэдэгдэх хуудсыг биелүүлэх боломжийг хянан үзэж мэдэгдэх хуудсыг ирүүлснээс хойш 7 хоногийн дотор шүүгч түүнийг албадан биелүүлэх тухай захирамж гаргаж, гүйцэтгэх хуудас бичиж, шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргүүлэх ба энэ тохиололд Шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу шийдвэр гүйцэтгэгч гаргуулна.

Харин шийдвэр гүйцэтгэгч нь алдангийн хариуцлага тооцох тухайд шүүхийн шийдвэрт заагаагүй, үнийн дүн нь тодорхой бус тул тэтгэлэг төлөгчөөс албадан гаргуулах шаардлага бий болж байгаа юм.

Хүүхдийн тэтгэлэг төлөх нь маргаангүй байгаа, шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудсанд тэтгэлэг төлөгч тэтгэлэг төлөх үүрэгтэй болох нь нэгэнт тогтоогдсон, алдангийн хэмжээ, хязгаарыг хуульд нариивчлан заасан зэрэг нь шүүхийн нэмэлт шийдвэр гаргахгүйгээр шийдвэр гүйцэтгэгч бие даан шаардах эрхтэй мэт.

Гэтэл энэ нь ШШГТухай хуулийн 4, 10 дугар зүйлд заасан шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь иргэни хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, бусад байгууллагын шүүх баталгаажуулсан шийдвэр байх,

шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гүйцэтгэх баримт бичиггүйгээр явуулахыг хориглосон заалттай зөрчилдөж байгаа юм.

Гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгчөөс төлбөр авагчид олговол зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, захиргааны шийтгэвэр, шүүхээс баталгаажуулсан мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэр, тэдгээрийн үндсэн дээр олгосон гүйцэтгэх хуудас зэрэг багтаж байхаар хуульчилсан байхад шүүхийн шийдвэрт заагдаагүй алдангийг шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчөөс гаргуулах боломжгүй учраас алданги гаргуулах хуулийн заалт амьдралд хэрэгжихгүй байгаа юм.

Шүүхийн шйидвэр гүйцэтгэх ажиллагаанд хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа нь төлбөр гаргуулах бусад ажиллагаанаас дараах онцлогтой байдаг.

1. Хүүхдийн тэтгэлэг нь сар бүр тодорхой мөнгөн дүнгээр буюу төлбөр төлөгчийн цалингаас суутгах тогтмол төлөгдөх төлбөрт хамаарч байдаг.
2. Хүүхдийн тэтгэлэг нь хүүхдийн насны байдлаас хамааран өөрчлөгддөг.
3. Хүүхдийн тэтгэлэгийг шүүхээс тогтоосон бол жил бүрийн амьжиргааны түвшинээс хамааран өөрчлөгдөж байдаг.
4. Хүүхдийн тэтгэлэгийн мөнгөнөөс өөр төлбөрйиг суутгахыг хориглодог.
5. Хүүхдийн тэтгэлэг бусад бүх төлбөрөөс тэргүүн ээлжинд төлөгддөг.
6. Хүүхдийн тэтгэлэгийн мөнгөнөөс урамшуулал тооцохыг хориглодог.
7. Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хүүхдийг 18 нас хүртэл хугацааны тэтгэлэгийг бүрэн төлж дуусах хүртэл үргэлжилнэ.

Өөрөөр хэлбэл хүүхэд 18 насанд хүрсэн ч тэтгэлэг төлөгч нь тэтгэлэгээ бүрэн төлөөгүй тохиололд тэтгэлэг гаргуулах ажиллагаа үргэлжлэн явагддаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хүүхдийн тэтгэлэгийг гаргуулахдаа Гэр бүлийн тухай хууль, ШШГТХуулийг удирдлага болгох бөгөөд Гэр бүлийн тухай хуулийн 51 р зүйлийн 51.1 д тэтгэлэг төлөгчийн мөнгөн хадгдамжийн болон бусад эд хөрөнгөнөөс тэтгэлэг гаргуулахдаа ШШГТХуульд заасан журмыг баримтална.

ШШГТХуулийн 66 дугаар зүйлийн 66.1 д хүүхдийн тэтгэлэг гаргуулах журмыг гэр бүлийн тухай хуулиар тогтооно гэсэн заалтуудыг тодорхой болгон аль хуульд хүүхдийн тэтгэлэг төлүүлэх журмыг тогтооход нэг мөр зааж зохицуулах хуулийн дагуу хүүхдийн тэтгэлэг биелдэг эрх зүйн орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа вм.

Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хуулль тогтоомжийн зохицуулалтийн хүрээнд хүүхдийн тэтгэлэг төлөх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тэтгэлэг төлөгчид захиргааны болон эрүүгийн хариушлага тооцох үндэслэлтэй.

Захиргааны хариушлагыг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журам зөрчсөн тэтгэлэг төлөгч болон журам зөрчсөн бусад этгээдэд ногдуулж болно.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн иргэнээс төлбөл зохих тэтгэлэгийг төлүүлж түүнийг 50000 төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлах шийтгэлийг сум

дүүргийн Засаг даргын шийдвэрээр Захиргааны шийтгэл ногдуулах зохицуулалттай боловч энэ шийтгэлийг ногдуулах сум дүүргийн харьяалал нь тодорхой бус байдаг. Мөн Эрүүгийн хуулийн 120 дугаар зүйлд зааснаар Эрүүгийн хариушлага хүлээлгэхээр заасан.

Хүүхдээ тэжээн тэтгэхээс зайлсхийсэн тохиололд хүлээлгэн хариушлагын талаар дээр нэрлэсэн хуулиудад тодорхой заасан боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа юм.

Цаашид хүүхдийг тэжээн тэтгүүлэх эрхийг зохих хэмжээнд хангах үүднээс энэ талаар хуулийг боловсронгуй болгох талаар :

1. Монгол улсын Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд хүүхдийг 18 настай болтол нь тэтгэлэг тогтоож байхаар өөрчлөлт оруулах
2. Хүүхдийн хэрэгцээ амжиргааны түвшин тэтгэлэг төлөгчийн цалин орлоготой нь уялдуулан тэтгэлэгийн хэмжээг тогтоодог журамд шилжих
3. Нэгэнт хуулиар тогтоосон тэтгэлгийн хэмжээ бага учраас аль болох тохиролцон гэрээний үндсэн дээр төлөх боломжийг эцэг эхэд олгох
4. Эцэг эх нь хүүхдээ тэжээн тэтгэх үүргээс санаатай зайлсхийдэг, хугацаа хождог үүнээс үүдэн хүүхдийн эрх ашиг хохироход хүрдэг. Имйд шүүх шийдвэр гаргахдаа хүүхдийн тэтгэлгийг нөхөн гаргуулдаг зохицуулалт шаардлагатай байна. Одоо мөрдөгдөж байгаа гэр бүлийн тухай хуульд шүүх тэтгэлгийг нөхөн гаргуулах тухай заалт байгаа боловч ямар нөхцөлд хэдийд буюу шүүхэд хандахаас өмнөх үеийн эсвэл шүүхийн шийдвэр гарсаны дарааа тэтгэлэг төлхөөс зайлсхийсэн үеийн гэх нь тодорхойгүй байна.
5. Хүүхдийн тэтгэлэгийг төлөхөөс санаатай зайлсхийсэн тэтгэлэг төлөгчид хүлээлгэх иргэний хариушлага хэрэгжих эрхй зүйн орчинг бүрдүүлэх, эрүүгийн болон захиргааны хариушлагыг чангатах. Тухайн заалтыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэлийг нарийн тогтоож өгөх.
6. Гэр бүлийн тухай хуулийн 51, ШШГТХ ийн 66.1 заалтуудыг тодорхой болгон аль хуульд хүүхдийн тэтгэлэг төлүүлэх журмыг тогтоохийг нэг мөр заажа зохицуулах. Хуулийн дагуу хүүхдийн тэтгэлэг биелдэг эрх зүйн орчинг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.
7. ШШГА ны явцад хүүхдийн тэтгэлэг гаргуулах бие даасан төрөлжсөн албатай болох, ШГ ч энэхүү онцлог ажиллагааг гүйцэтгэх талаар мэрэгшсэн байх зохицуулалтийг ШШГТХуульд тусгаж өгөх зэрэг асуудалыг дэвшүүлж байна.



Б.ЭРДЭНЭ-ОЧИР

Хууль сахиулахын их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн процессын эрх зүйн тэнхимийн багш, ахмад



М.АБАЙ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн 531 дүгээр дамжааны сонсогч

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процессын эрх зүйн тэнхимээс гадаад орнуудын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиас цуврал болгон товчлон орчуулж байна. Энэ удаа Казахстан улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулиас шийдвэр гүйцэтгэгчийн эрх үүрэг, сонгон шалгаруулалт хэрхэн явагддаг талаар товчлон хүргүүлж байна.

КАЗАХСТАН УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИАС

Казахстан улсын Шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль 1998.04.30-нд батлагдсан. Нийт 5 бүлэг, 17 зүйл, 175 заалттай.

16 дугаар зүйл

Казакстан улсын хувийн шийдвэр гүйцэтгэгчид:

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн албан тушаалд 25 нас хүрсэн, дээд боловсролтой, хуульч мэргэжилтэй, хувийн шийдвэр гүйцэтгэлийн албанд доод тал нь 1 жил тасралтгүй ажилласан, сонгон шалгаруулалтанд тэнцсэн, хувийн шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн, гүйцэтгэх баримт бичигт ажиллагаа явуулах талаар хөдөлмөр эрхлэх эрхийн гэрчилгээ авсан, энэ хуулинд заасан журмын дагуу хувийн шийдвэр гүйцэтгэх албаны сул орон тоонд шалгалт өгч тэнцсэн Казакстан улсын иргэнийг томилно.

2. Хуульд заасан журмын дагуу тэнцээгүй, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулах мэдлэггүй ба үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарласан, шүүхийн шийдвэрээр бусдад төлөх төлбөртэй хүн хувийн шийдвэр гүйцэтгэгч болох боломжгүй. Өөрөө цагаатгах боломжгүй гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон ба хувийн шийдвэр гүйцэтгэгч хөдөлмөр эрхлэх гэрчилгээ нь хүчингүй болсон хүн хувийн шийдвэр гүйцэтгэгч болохыг хориглоно.

3. Хувийн шийдвэр гүйцэтгэгч тэтгэврийн насанд хүртэл өөрийн хөдөлмөрийг эрхлэх эрхтэй. Хувийн шийдвэр гүйцэтгэгч тэтгэвэрийн насанд хүрсэний дараа өөрийнхөө үүргийг хувийн шийдвэр гүйцэтгэгч нарын холбооны саналыг үндэслэн авч, зөвхөн төлөөлөгчийн газрын зөвшөөрлөөр тэтгэвэрийн насанд хүрсэний дараа дээд тал нь 5 жил хүртэл хугацаанд ажиллах эрхтэй.

4. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн, журмын төлөөлөгчийн газар болон хувийн шийдвэр гүйцэтгэгчийн холбооны тохиролцсоны үндсэн дээр хувийн шийдвэр гүйцэтгэгчийг томилно.

5. Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь өөрийн албаны үүргийг нэр төртэй, хариуцлагатайгаар гүйцэтгэнэ. Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь хуулийн этгээд тул

Казахстан улсын татварын хуулинд заасан журмын дагуу улсад тодорхой хэмжээний татвар төлнө.

142 дугаар заалт

Гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгэх тухай ажиллагааг явуулах эрхийн гэрчилгээ

1. Шийдвэр гүйцэтгэгчийн эрхийн гэрчилгээ авсан хувийн шийдвэр гүйцэтгэгч нь хуулийн хүрээнд гүйцэтгэх баримт бичигт гүйцэтгэх ажиллагаа явуулах эрхтэй.

2. Шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг ур чадварын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн төлөөлөгчийн газар олгоно. Төлөөлөгчийн газар нь гүйцэтгэх баримт бичгийг гүйцэтгэх тухай ажиллагааг явуулах эрхийн гэрчилгээг улсын бүртгэлээр явуулна. Төлөөлөгчийн газар нь гэрчилгээ олгохоос татгалзсан нөхцөлд шийдвэрийг гардаж авсан өдрөөс эхлэн 15 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

3. Ур чадварын шалгалтанд бүрдүүлэх шаардлагтай материал, баримт бичгийн жагсаалтыг төлөөлөгчийн газар, хувийн шийдвэр гүйцэтгэгч нарын холбооны тохиролцсоноор батлаж ур чадварын шалгалтын тухай дүрэм батлаж тэмдэглэнэ. Шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээ олгох хугацаа ба журам нь Казакстан улсын гэрчилгээ олгох тухай хуулийн хүрээнд явагдана.

4. Шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг төлбөртэй олгоно. Уг төлбөрийн хэмжээ ба журмыг Казакстан улсын татварын тухай хуулиар тодорхойлно.

5. Шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг хугацаагүй олгох бөгөөд уг гэрчилгээ нь ерөнхий гэрчилгээ байна. Ерөнхий гэрчилгээ нь Казакстан улсын нийт нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилнэ.

6. Ерөнхий гэрчилгээг авсан боловч шийдвэр гүйцэтгэлийн албанд 3 жил хүртэл хугацаанд ажиллаагүй бол ур чадварын шалгалт давтан өгсөний дараа шийдвэр гүйцэтгэгчийн албанд ажиллах эрх нь үүснэ. Ур чадварын шалгалтыг давтан өгсөний төлөө төлбөр авахгүй. Дээрхи хугацааг тооцохдоо уг хүний хувийн шийдвэр гүйцэтгэгчийн туслахаар ажилласан хугацааг оруулан тооцохгүй.

7. Хууль зөрчсөний төлөө шүүгчийн албанаас чөлөөлөгдсөн шүүгч, төлөөлөгчийн газар ба түүний тойргийн бүрэлдэхүүнд зөрчлийн улмаас чөлөөлөгдсөнөөс хойш 5 жил өнгөрөөгүй иргэдээс бусад шүүх, прокурорын системд 10-аас доошгүй жил ажилласан шүүгч, прокурор шалгалтанд орохгүйгээр шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг шууд авах эрхтэй.

143 дугаар зүйл

Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн түр түдгэлзүүлэх үндэслэл

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн эрхийг түр түдгэлзүүлэхдээ сахилгын хорооны шийдвэрийг үндэслэн төлөөлөгчийн газрын өргөдөлийн дагуу шүүхийн шийдвэрээр түдгэлзүүлнэ.

2. Шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг түдгэлзүүлэх үндэслэлүүд:

- Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь эрүүгийн хэрэгт сэжигтнээр татагдсан
- Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэх ажиллагаа явуулах үед Казакстан улсын хуулийг ноцтой зөрчсөн
- Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь өөрийнхөө хуулиар тогтоосон тойргоос бусад тойрогт гүйцэтгэх ажиллагаа явуулсан.

3. Шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг ашиглахыг түдгэлзүүлэх тухай шүүхийн

шийдвэрт түдгэлзүүлсэн үндэслэл ба хугацааг тодорхой заана. Түр түдгэлзүүлсэн шүүхийн шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хувийн шийдвэр гүйцэтгэгч үйл ажиллагаа явуулах эрх нь түр хугацаагаар зогсоно. Түр түдгэлзүүлэх үндэслэлүүд арилсан нөхцөлд төлөөлөгчийн газраас шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах эрхийг нь олгоно.

4. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааг түр түдгэлзүүлэх тухай шүүхийн шийдвэр гарсан өдрөөс эхлэн хувийн шийдвэр гүйцэтгэгчийн хувьд үүрэг гүйцэтгэгч болно.

144 дугаар зүйл

Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн эрхийг зогсоох

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээг цуцлах ерөнхий үндэслэл.

- Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулахдаа улс олон нийт, иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулж, Казакстан улсын хуулийг ноцтой зөрчсөн.
- Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түр түдгэлзүүлсэн үндэслэлүүд арилаагүй
- Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь шийдвэр гүйцэтгэгчийн эрхийг авахын тулд шаардлагтай баримт бичгүүдийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон
- Ур чадварын зөвлөл дахин аттестачилсан дүнгийн дагуу хувийн шийдвэр гүйцэтгэгчийн ажиллагаанд тэнцэхгүй гэж заасан.
- Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн ажиллагааг тодорхой үндэслэл, шалтгаангүйгээр 3 хүртэл хоногоор явуулаагүй.
- Эрүүл мэндийн байдлаас болон албаны үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон нь шүүхээр тогтоогдсон.

2. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн үйл ажиллагааг зогсоох ерөнхий үндэслэлээс бусад тохиолдолууд:

- Хувийн шийдвэр гүйцэтгэгч өөрөө өргөдөл гаргасан
- Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн иргэний харъяа нь өөрчлөгдсөн эсвэл Казакстан улсаас гадна улс оронд суурьших болсон
- Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон
- Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь нас барсан эсвэл сураггүй алга болсонд тооцогдож зарлагдсан нөхцөлд зогсооно.

3. Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь гэрчилгээ ашиглахыг зогсоох тухай хүсэлтээ төлөөлөгчийн газарт, прокурорт, хувийн шийдвэр гүйцэтгэгч нарын ёс зүйн зөвлөлд эсвэл тойргийн албанд гаргана.

4. Хувийн шийдвэр гүйцэтгэгч нарын зөвлөл төлөөлөгчийн газрын даалгаврын дагуу гэрчилгээ ашиглахыг зогсоох ба шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа явуулах, түүнчлэн хүчингүй болсон хувийн шийдвэр гүйцэтгэгчийн гэрчилгээ, тэмдэгийг төлөөлөгчийн газарт хүлээлгэн өгч устгуулах арга хэмжээ авна. Банк ба банк бус санхүүгийн байгууллага гүйцэтгэх байгууллагын төлөөлөгчийн газрын даргын тушаалыг үндэслэн ажиллагааны зардлын данс, тайлан тооцоог шинээр томилогдсон хувийн шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлнэ.

5. Хэрвээ хувийн шийдвэр гүйцэтгэгчид хамаатай захиргааны зөрчил үүссэн бол уг зөрчлийн арга хэмжээ дууссаны дараа төлөөлөгчийн газраас албанаас чөлөөлнө.

6. Хувийн шийдвэр гүйцэтгэгч төлөөлөгчийн газрын шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрхтэй.

147-Р ЗҮЙЛ
Хувийн шийдвэр гүйцэтгэгч нарын эрх үүрэг ба хариуцлага

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгч нь гүйцэтгэлийн ажиллагаа хийлгүүлэх хүсэлт гаргасан иргэн болон хуулийн этгээдийн боломжоор хангах
2. Дурын банк ба Банк санхүүгийн түүний дотор валютын данс нээх , үл хөдлөх ба хөдлөх эд хөрөнгийн хураах, ажилтан албан хаагчдад мэдэгдэл гардуулах, хөлслөх, шүүхийн шийдвэрийн дагуу ажлаас нь чөлөөлөх, цалингийн суутгал хийх, шүүхэд тайлбар гаргах, Казакстан улсын хуульд нийцсэн бусад аргуудыг хэрэглэх
3. Казакстан улсын хуулинд заасны дагуу улсын нийгэм, эрүүл мэнд, нийгэм хамгааллын системийн бүх хөнгөлөлт эдлэх
4. Төлбөр төлөгчтэй холбоотой бүх мэдээллийг улсын болон хувийн байгууллагуудаас өмчийн хэлбэр харгалзахгүй албадан гаргуулах
5. Казахстан улсын хууль эрхийн актуудад заасан бусад эрхийг эдлэх эрхтэй.

148-Р ЗҮЙЛ
Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн үүрэг

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн албанд томилогдсоны дараа бүртгүүлэхийн тулд ажлын 3 хоногийн дотор татварын албанд өргөдөл гаргах
2. Уг хууль ба Казахстан улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дотоод журам бусад нарийвчилсан эрх зүйн актанд нийцсэн гүйцэтгэлийн ажиллагаа явуулах
3. Өөрийн албан үүргээ шударгаар гүйцэтгэх, гүйцэтгэх ажиллагаа явуулах явцад өөрт нь тодорхой болсон төрийн болон хувийн нууцыг задруулахгүй, чандлан сахих үүрэгтэй.
4. Гүйцэтгэх баримт бичгийг хүлээн авмагц үйл ажиллагаа явуулсан өдрөөс эхлэн 24 цагийн дотор хувийн шийдвэр гүйцэтгэгч нарын зөвлөлд мэдэгдэх
5. Албаны ёс зүйг сахих
6. Албаны өрөөтэй байх
7. Хувийн шийдвэр гүйцэтгэгч ажлын тайлангаа долоо хоног, сар, улирал, хагас жил, жилээр нь гаргаж, гүйцэтгэсэн арга, шаардлагтай баримт бичгийн хуулбарын хамт хувийн шийдвэр гүйцэтгэлийн холбоонд явуулж байна.
8. Төлбөр төлөгчийн хууль бус үйлдэл талаар үндэслэлтэй гэж үзвэл тойргийн хэлтэст холбогдох материалыг бүрдүүлж явуулах
9. Өөрийн албаны ур чадварыг байнга нэмэгдүүлж байх
10. Казакстан улсын хууль эрх зүйн актанд заасан бусад үүргийг хүлээнэ

149 дүгээр зүйл
Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн ажлыг хязгаарлах

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгч эрдэм шинжилгээний, багшлах, эсвэл зохиолчийн хөдөлмөрөөс бусад ажлыг эрхлэх эрхгүй.

150 дугаар заалт
Хувийн шийдвэр гүйцэтгэгчийн хариуцлага

1. Хувийн шийдвэр гүйцэтгэгч өөртөө оногдсон албаны үүргээ үл биелүүлбэл Казакстан улсын хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.
2. Хувийн шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх ажиллагаа явуулахдаа өөрийн

буруутай үйлдэл, эс үйлдэлээс бусдад хохирол учруулсан бол Казахстан улсын хуульд заасны дагуу учирсан хохирлыг бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

"ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН СТАТИСТИК" ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД ОРОЛЦЛОО



Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн процессийн тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа Б.Алтангэрэл, ахлах багш, ахмад О.Батсайхан, Ахлагчийн сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тэнхимийн ахлах багш, хошууч Н.Батдорж нар 2013 оны 09 дүгээр сарын 13-наас 09 дүгээр сарын 15-ны хооронд ОХУ-ын Буриад улсын Улаан-үд хотод зохион байгуулагдсан "Эрүүгийн эрх зүйн социологи: Эрүүгийн эрх зүйн статистик" олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцлоо. Тус олон улсын эрдэм шинжилгээний хуралд ОХУ, Украйн, Казактсан, Монгол, Буриад улсын төлөөлөгч нар оролцож илтгэл хэлэлцүүллээ.

Олон улсын эрдэм шинжилгээний хурал 09 дүгээр сарын 13-ны 09.30-17.00 минутад Улаан-Үдийн төр, захиргааны төв байрны хурлын зааланд эхэлж доорхи үндсэн илтгэлүүдийг авч хэлэлцсэн.Үүнд:

1.Скуратов Юрий Ильич, 21 дүгээр зууны эрх зүйн технологи сангийн